



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 11 он 11  
сарын 21 өдөр

Дугаар ЗГ-1 / 146

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224002451



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2014 он 11 дугаар  
сарын 01-ны өдөр

Дугаар 177/2595

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 747 ... хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225011344



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.10.18 № 1/5247

танай 2022.10.14-ны № ХЭ/2360-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



ХНЯМБААТАР

151604847

А5 Файл.2022



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>


2022.10.24 № 0117253

танай 2022.10.14-ны № ХАГ/2369 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



**Б.ЖАВХЛАН**

**9761001306**



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт, “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан 3 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрхтэй” гэсэн зарчмыг тусган хуульчилсан.

Мөн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, тус хуваарийн 1.1.1-д “...стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх...зарчмыг хуульчлах”, 1.2.6-д “төрийн

нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох” зорилтыг дэвшүүлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “...төрийн өмчийн ангиллыг түүний зориулалт, шинж чанараас хамаарч зөв зохистой хуульчлах, зориулалт тус бүрээр удирдах, захиран зарцуулах эрх, үүргийг зөв хуваарилах” чиглэлд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны зорилтын 5.2.6-д “Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ.” гэж, 5.2.19-т “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан.

Ийнхүү Монгол Улсын төрөөс эрх зүйн шинэчлэл, хөгжлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн “төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчлэлд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн өмчийн төрөл, хэлбэрийг зохистой тогтоож, “Үндэсний баялгийн сан”, “байгалийн баялгийн өгөөж нь ард түмэнд ногдох” зарчмыг хэрэгжүүлэх, бүртгэл, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх” зорилт нь тус хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн шаардлагыг илэрхийлж байна.

## **1.2.Практик хэрэгцээ, шаардлага:**

1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай бие даасан хуулийг баталсан бөгөөд тус хууль хэрэгжиж эхэлснээс хойших 25 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2005 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай хууль болон Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулиуд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн 4 жилд 1 удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан явуулна” гэж заасны дагуу өнөөгийн байдлаар улсын тооллогыг 7 удаа (1996, 2000, 2003, 2007, 2011, 2015, 2022 он) явуулсан байна.

2015 оны тооллогоор нийт 30 их наяд, 74 тэрбум, 984.7 сая төгрөгийн хөрөнгө тоологдсон нь өмнөх буюу 2011 оны тооллогын дүнгээс 15 их наяд, 614 тэрбум, 300 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчид нийт 83.8 их наяд төгрөгийн хөрөнгө 6600 нэгж, байгууллагад байгаа гэсэн урьдчилсан дүн гарчээ. /2022 оны тооллогын дүнг нэгтгэх ажил хийгдэж байгаа бөгөөд эцэслэгдээгүй болно/.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани 105, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 275 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогоор улсын төсөвт 2019 онд 155.2 тэрбум, 2020 онд 173.6 тэрбум, 2021 онд 207.2 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн нь 2018 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 4.9 дахин нэмэгдсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 53,4 их наяд төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 10,6 их наяд төгрөгийн орлого олж, 1,03 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 8.7 хувиар буюу 860 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 407 хувиар буюу 831 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой эерэг үр дүн цөөнгүй байгаа боловч хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хуульд цаг үеийн шинжтэй нөхцөл байдлыг харгалзсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь зохицуулалтын цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.

Өнгөрсөн хугацаанд тус хуульд нийт 33 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тодруулж үзвэл, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн асуудлаар 2 удаа, хууль хоорондын зөрчлийг арилгах болон зохицуулагдаагүй харилцааг нөхөн зохицуулах зорилгоор 23 удаа, бусад асуудлаар 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Гэвч эдгээр өөрчлөлтийн дийлэнх нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд биш харин салбарын бусад хуулиуд шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Дээрх 33 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд нь өөрчлөлт орсон бөгөөд үүнээс дүгнэн үзэхэд хуулийн зохицуулалтын дийлэнх хэсэгт нэгдсэн бодлого, зарчмаар биш салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<sup>1</sup>

Мөн хуульд төрийн өмчийг нийтийн зориулалттай болон төрийн өөрийн өмч гэж ангилж, ангилал тус бүрт хамаарах өмчийг ялган тодорхойлсон боловч өөр хооронд нь давхцал үүсгэсэн, төрийн мэдэлд байх эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн төрлийг орхигдуулсан, төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ангиллыг Иргэний хуулиас зөрүүтэй, өмчийн талаар эдлэх эрх, хүлээх үүрэг, хөрөнгийн зориулалт, хэлбэртэй уялдуулж тогтоогоогүй, төрийн өмчит хуулийн

---

<sup>1</sup>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он.

этгээдийг үүсгэн байгуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг хэт ерөнхий тодорхойлсон зэрэг нь хийдэл үүсгэж байна.<sup>2</sup>

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурал нь орон нутгийн өмчийн өмчлөгч байхаар заасан боловч өмчлөх эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх журмыг тодорхой зохицуулаагүйгээс хуулийн хэрэгжилтэд хүндрэл учрах болжээ. Түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрх хэт хязгаарлагдмал буюу хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад эд хөрөнгө захиран зарцуулах эрх олгоогүй нь Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахад хүргэжээ.

Мөн хуульд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх этгээдүүдийн чиг үүрэг, эрх хэмжээг хэт ерөнхий болон давхцал, хийдэлтэй зохицуулсны улмаас төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, хяналт хэрэгжүүлэх эрх хэмжээ хязгаарлагдаж, төрийн өмчийн бүртгэл, хяналтыг нэгдсэн журмаар хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сулруулж, үр өгөөжгүй захиран зарцуулах үр дагаварт хүргэж байна.

Төрийн өмчийн зонхилох хэсэг болох газрын бүртгэл манай улстай адил өмчийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд тооцогддог боловч Монгол Улсын хувьд төрийн ба орон нутгийн өмчид хамаарах үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл байхгүй хэвээр байна.

Иймд дээр дурдсан хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл, Тавин есдүгээр зүйл болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн орон нутгийн өмчийн удирдлагын зохицуулалтыг шинэчлэх, төрийн ба орон нутгийн өмчийн удирдлага, бүртгэл тооллого, хяналт шалгалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.

### **Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилгыг “Төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрх хэмжээг тогтоож, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, үнэлэх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах” гэж өргөжүүлэн тодорхойлж, хуулийн төсөлд дараахь зарчмын өөрчлөлтүүдийг тусгана:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор тус хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд хамаарахгүй болон тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлно.

<sup>2</sup> Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс хийсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн байдлын судалгаа”. 2020 он.

2.Хуулийн нэр томъёог Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх, тооцоо, судалгаанд үндэслэсэн, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх зэрэг тусгай зарчмыг тусган хуульчилна.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал өмчлөгч байх зарчмыг хэвээр хадгалж, улмаар өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх субъект болох Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээний давхцлыг арилгаж, харилцан уялдаатай байдлаар зохицуулна. Мөн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон Орон нутгийн өмчийн газрын чиг үүргийг тодруулан хуульчилна.

4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ангиллыг тэдгээрийн хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилох зэрэг асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулиар зохицуулахаар хуульчилна.

5.Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, орон нутгийн өмч болон хувийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг эдийн засгийн хэмнэлттэй, зохистой, шударга байдлаар хэрэгжүүлэх журмыг нарийвчлан хуульчилна. Энэ хүрээнд төрийн өмчийг нийтийн эрх ашгийн төлөө түр ашиглуулах зориулалт, гэрээний нөхцөл, төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх журмыг шинээр тогтооно.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсэг (төрийн нийтийн болон тусгайлсан өмч, орон нутгийн өмч)-ийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулна. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, хязгаарлагдмал эрх, оюуны өмчийг ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гэрээний бүртгэлийн шинэ төрөл бий болгож, холбогдох мэдээллийг ил тод хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэлийг бүрдүүлнэ.

7.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналт, мөн дотоодын хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газраас хэрэгжүүлэх үндэслэл, журмыг тодорхойлно.

8.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах үйл ажиллагааны ил тод байдал болон олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор өмчийн бүртгэл, тайлагналттай холбоотой журмыг шинэчилж, өмчийн бүртгэл, хөдөлгөөн, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг жил бүр гаргаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг Засаг дарга, Засгийн газар хэрэгжүүлэхээр зохицуулна.

9.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г бүрдүүлж, санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг хуульчилна.

10.Хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт буюу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрөл, ангиллын шинэчлэлд нийцүүлэн хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах зэрэг арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тогтоон хуульчилна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хэлбэр, мөн хуулийн 28-30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийг бүтцийн хувьд дараахь агуулга бүхий 13 бүлэгтэй байхаар боловсруулах бөгөөд Нэгдүгээр бүлгээр Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэр, Гуравдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, түүний эрх хэмжээ, Дөрөвдүгээр бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний хөрөнгийн эрхийн зохицуулалт, Тавдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах үндэслэл, журам, Зургадугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого хийж журам, Долдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, Наймдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх, Есдүгээр бүлгээр Дуудлага худалдаа явуулах нийтлэг журам, Аравдугаар бүлгээр Уралдаант шалгаруулалт зохион байгуулах нийтлэг журам, Арван нэгдүгээр бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын хяналт, тайлагналтын үйл ажиллагаа, Арван хоёрдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан, Арван гуравдугаар бүлгээр бусад асуудлыг зохицуулна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон удирдлага хэрэгжүүлэх субъектын чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл, зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо, Үндсэн хуульд тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих хууль зүйн нөхцөл бүрдэнэ.

Төрийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийг эргэлтэд оруулах болон үнэлэх,



бүртгэх, эзэмших ашиглах ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуульд заасан шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн, Иргэний хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.2-т заасны дагуу 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

Мөн хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Боловсролын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Газрын тосны тухай, Газрын тухай, Генетик нөөцийн тухай, Геодези, зураг зүйн тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Иргэний нисэхийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Кино урлагийг дэмжих тухай, Концессын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Ойн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Цөмийн энергийн тухай, Шилэн дансны тухай, Эрчим хүчний тухай зэрэг хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---ооо---



## ТАНИЛЦУУЛГА

### *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэл нь төрийн болон орон нутгийн өмчийн талаарх ойлголт, ангиллыг шинээр тодорхойлох, түүнийг удирдах этгээдийн эрх хэмжээг нарийвчлан зааглаж, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, удирдлага, төрийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн тогтооход чиглэгдсэн.

Улсын Их Хурлаас 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд тус хуульд нийт 33 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Ийнхүү хуулийн үндсэн бүтэц болох нийт зүйлийн 75 хүртэл хувьд өөр, өөр зорилго, цаг хугацаанд удаа дараа өөрчлөлт оруулсан нь хуулийн зохицуулалтын нэгдмэл цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.<sup>1</sup>

Түүнчлэн тус хуулиар зохицуулаагүй орхигдуулсан төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг Улсын Их Хурал, Засгийн газар, яамд, холбогдох төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагаас батлан гаргасан өмч хувьчлалын үндсэн чиглэл, хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт, бусад журам, заавар, аргачлал, маягт зэргээр нөхөн зохицуулж ирсэн байна.

Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойших 26 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс гадна холбогдох бусад хуулийн шинэчлэл хамаарч байна. Тухайлбал, 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2006 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай, Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулиуд байна.<sup>2</sup>

Тодруулбал, тус хуулийн хувьд эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, зарим төрлийн харилцааг зохицуулалтгүй үлдээсэн зэрэг зөрчил, хийдлээс гадна 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд хүртээх, орон нутгийн өмчийн эрхийн бие даасан байдлыг хангах зарчмыг тогтоосон зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэх хууль зүйн шаардлагыг бүрдүүлж байна.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. 2021 он. Ажлын хэсэг

<sup>2</sup> Хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн судалгаа. 2021 он.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээс гадна холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээс санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, мэргэжлийн хуульчдын багаар хуулийн төслийн шүүмж судалгааг гүйцэтгүүлэх, байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулах зэргээр санал авах ажлыг зохион байгуулсан.

Төрийн өмчийн хууль, эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг холбогдох цахим хуудас, эх сурвалжаас авсан мэдээлэлд үндэслэн 37 улсын тодорхой зохицуулалтыг хамруулан гүйцэтгэсэн болно. Мөн орон нутгийн өмчийн газрын мэдээлэл, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт, улсын төсөвт үйлдвэрийн газар, тусгай сангуудын судалгааг гүйцэтгэж, мэдээлэл, үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудал, түүнд нөлөөлж байгаа хуулийн зохицуулалтын талаарх судалгааг гүйцэтгэж, үр дүнг хуулийн төслийн боловсруулалтад ашигласан.<sup>3</sup>

Хуулийн төслийн бүтцийг 13 бүлэг, 69 зүйлтэй тогтоож, Нэгдүгээр бүлгээр Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэр, Гуравдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, түүний эрх хэмжээ, Дөрөвдүгээр бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрхийн зохицуулалт, Тавдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах үндэслэл, журам, Зургадугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого хийх журам, Долдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах журам, Наймдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх үндэслэл, журам, Есдүгээр бүлгээр Дуудлага худалдаа явуулах нийтлэг журам, Аравдугаар бүлгээр Уралдаант шалгаруулалт зохион байгуулах нийтлэг журам, Арван нэгдүгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт, тайлагналтын үйл ажиллагаа, Арван хоёрдугаар бүлгээр Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан, түүнийг хөтлөх журам, Арван гуравдугаар бүлгээр бусад харилцаа буюу гомдол, мэдээллийг шийдвэрлэх, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага болон шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгайлан зохицууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу Хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн дараах зарчмын шинжтэй, шинэлэг зохицуулалтыг тусгасан:

1.Хуулийн зорилтыг өргөжүүлэн томъёолж, тус хуулиар зохицуулах харилцааны хүрээг тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг нэгтгэн тогтоосон. Хуулийн үйлчлэлд хамаарахгүй болон тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг холбогдох хууль тогтоомж, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлтэй<sup>4</sup> уялдуулан тодорхойлсон.

Тухайлбал, улсын болон орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, Засгийн газрын болон Орон нутгийн тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалт, төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах нөхцөл, журам болон үйл ажиллагаатай холбоотой харилцаа, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, түншлэлийн төлбөрийг санхүүжүүлэх болон дэмжлэг үзүүлэх, төрийн зарим чиг үүргийг

<sup>3</sup> Хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн танилцуулга. 2021 он.

<sup>4</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан хуулийн төсөл. 2022 он. [www.moiha.gov.mn](http://www.moiha.gov.mn)

гэрээгээр, эсхүл хуулиар эрх олгосон этгээдээр гүйцэтгүүлэх болон Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглахтай холбоотой харилцаа, түүнчлэн, газар, ой, ургамал, ан амьтан, усны сан бүхий газар зэрэг ашиглалт болон бүртгэл, тооллогыг тусгай журмаар зохион байгуулдаг төрийн нийтийн өмчийн харилцааг тухайлсан хуулиар зохицуулахаар тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх зарчмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой тодорхой харилцааг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтлах бөгөөд тухайлсан хуулиар зохицуулагдаагүй харилцаанд энэ хууль нөхөн үйлчлэхээр зохицуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд ил тод, нээлттэй байх, өмч, хөрөнгийн удирдлагыг үр нөлөөтэй, үр ашигтай хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага нэгдмэл байх, хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхээс гадна аливаа шийдвэрийг судалгаа, тооцоонд үндэслэж гаргах зарчмыг баримтлахаар тусгасан.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж, төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмч, түүнчлэн орон нутгийн өмчид хамаарах өмчийн төрлийг зааглан тусгасан. Үүнд, төрийн нийтийн өмчид Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байхаар болон үр өгөөжийг нь ард түмэнд хүртээхээр заасан байгалийн баялаг, хөрөнгийг хамруулсан бол төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчид төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой хөрөнгийг нэрлэн тодорхойлсон.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болох Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээг шинэчилж, өнөөгийн хууль хэрэглээний практикт үүсээд байгаа чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, харилцан уялдаатай, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд анхаарсан.

Тухайлбал, Улсын Их Хурал нь төрийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд төрийн өмчийг удирдах эрхийг хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт олгох, төрийн өмчит компани байгуулах стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалт батлах, тус салбарт компани байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох, тооллогын дүн, өмчийн талаарх тайлантай танилцах, өмчлөгчийн хувьд хуульд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх онцгой эрхтэй байхаар заасан бол Засгийн газар нь хуулиар олгосон эрхийн хүрээнд өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлж, үр нөлөө, ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах чиг үүргийг тодорхойлсон.

Мөн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргаас орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой хэрэгжүүлэх чиг үүргийг зааглан зохицууллаа. Тухайлбал, иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь өмчлөгчийн хувьд орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах, эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах, орон нутгийн өмчит компанид хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчийг томилох, харьяа нэгжид хамаарах орон

нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх шийдвэр гаргах эрх хэмжээг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.

4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг шинэчлэн тогтоож, тэдгээрийн эд хөрөнгийн эрхийг нийтлэг болон онцлог байдлыг харгалзан тодорхойлсон. Мөн Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрөлд төрийн байгууллага, албан газраас гадна “улсын төсөвт үйлдвэрийн газар”, “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” зэрэг Иргэний хуулиар зохицуулаагүй хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд тусгасныг өөрчилж, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт, улсын төсөвт үйлдвэрийн газрыг төрийн байгууллага, албан газрын ангилалд хамрууллаа.

Энэхүү шинэ ангиллын дагуу “төрийн байгууллага”, “албан газар” гэх ойлголтыг шинээр тодорхойлж, тэдгээрийн хөрөнгө удирдах эрхийг ялгамжтай байдлаар зохицуулсан.

5.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг өргөжүүлж, өмчийг удирдах ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байхаар зохицууллаа.

Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өмчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахын зэрэгцээ төрийн өмчит компани байгуулах, татан буулгах болон төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, зориулалтыг нь өөрчлөх асуудлаар дүгнэлт гаргах, өмчийн хөдөлгөөн, үр ашгийг тодорхойлсон жил бүрийн тайлан болон өмчийн улсын нэгдсэн тооллогыг зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого болон хөрөнгийг удирдах үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг нэгдсэн журмаар хэрэгжүүлэх боломжийг хангах зорилгоор Орон нутгийн өмчийн газрын чиг үүргийг хуулиар тодорхойлсон.

6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хөрөнгө олж авах, үнэлж бүртгэх, эзэмших, ашиглах, бусдын өмчлөлд шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг хөрөнгийн харилцаатай холбоотой зохицуулалтын журмыг шинэчилсэн. Тухайлбал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх асуудлыг Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хэрэгжүүлэх бол төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, мөн хөдлөх хөрөнгийг худалдах асуудлыг өөрөө шийдвэрлэх боломжийг олгож, хөрөнгийн хөдөлгөөний шуурхай байдлыг хангасан.

Түүнчлэн төрийн өмчийн хөрөнгийг ашиглуулах зохицуулалтыг оновчтой болгож, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах журмаар шилжүүлэх зэрэг аргыг хэрэглэх үндэслэл, журмыг нарийвчлан тогтоосон.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлсний дараах хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

7.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсэг (төрийн нийтийн өмч, төрийн тусгайлсан өмч, орон нутгийн

өмчийн)-ийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг илүү нарийвчлан зохицуулсан. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, хязгаарлагдмал эрх, оюуны өмчийг ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гэрээний бүртгэлийн шинэ төрөл бий болгож, холбогдох мэдээллийг ил тод байх зарчмыг тусгасан.

8.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналт, мөн дотоодын хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулсан.

Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь хуульд заасны дагуу өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газар нь төрийн хяналтыг хэрэгжүүлнэ.

Энэ чиг үүргийн дагуу төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчийн газарт ажиллах улсын байцаагч нь өмчийн бүртгэл, тооллого, хөрөнгийн удирдлагын хэрэгжилт, түүний үр дүн, жилийн болон хагас жилийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт гаргах, мөн хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Өмчийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн тухайн жилийн хөдөлгөөн, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг жил бүр гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг Засаг дарга, Засгийн газар хүлээхээр зохицуулсан. Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь мэдээ, тайлангаа олон нийтэд ил тод, байгууллагын цахим хуудсандаа байршуулах үүргийг хүлээх зохицуулалтыг тусгасан.

9.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмч удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г бүрдүүлж, санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хангах үүргийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцахаар зохицуулсан.

Түүнчлэн Мэдээллийн нэгдсэн сан дахь төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хязгаарлалтай мэдээллээс бусад мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байх шаардлагыг тогтоосон.

10.Хуулийн шинэчлэлттэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах асуудлыг тус хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд багтаан зохион байгуулахаар зохицуулсан. Өөрөөр хэлбэл, одоогийн ангиллын дагуу улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах асуудлыг Засгийн газрын шийдвэрийн дагуу зохион байгуулахаар шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, мөн хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Боловсролын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Газрын тосны тухай, Газрын тухай, Генетик нөөцийн тухай, Геодези, зураг зүйн тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Иргэний нисэхийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Кино урлагийг дэмжих тухай, Концессын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Ойн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Цөмийн энергийн тухай, Шилэн дансны тухай, Эрчим хүчний тухай зэрэг хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

----000----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрх хэмжээг тогтоож, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, үнэлэх үйл ажиллагаа, өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдахтай холбоотой дараах харилцааг тухайлсан хуулиар зохицуулна:

3.2.1.улсын болон орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, Засгийн газрын тусгай сан болон Орон нутгийн тусгай сан, улсын болон орон нутгийн нөөцийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, түүнийг захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих;

3.2.2.энэ хуулиар зохицуулснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанитай холбоотой харилцаа;

3.2.3.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус сангийн зохион байгуулалт, хяналтын бүтэц, эд хөрөнгийн эрх, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.5.энэ хуулийн 8.1, 8.2.1, 8.2.4, 8.2.5, 8.2.7, 9.1.5, 9.1.6, 10.3.6, 10.4.6-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогыг зохион байгуулах, өмчийг эзэмшүүлж, ашиглуулах болон 8.2.2, 8.2.3-т заасан агаарыг хамгаалах, агаарын орон зайг ашиглуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.6.соёлын биет өвийг бүртгэх, үнэлгээ тогтоох, тооллого хийх, түрээслэх, солилцох, шилжүүлэх болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, түншлэлийн төлбөрийг санхүүжүүлэх болон дэмжлэг үзүүлэх;

3.2.8.Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглах;

3.2.9.хууль болон гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон хуулиар тусгайлан эрх олгосон этгээдээр гүйцэтгүүлэх.

3.3.Тухайлсан хуулиар тогтоох төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдахтай холбоотой зохицуулалт нь энэ хуульд заасан өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн нийтлэг эрх хэмжээнд нийцсэн байна.

3.4.Тухайлсан хуулиар зохицуулагдаагүй энэ хуулийн 3.2-т заасан төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.5.Төрийн болон албаны нууцад хамаарах хөрөнгийг удирдах, түүнд хяналт тавих журмыг энэ хууль болон холбогдох хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн байгууллага” гэж төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг дээд, төв болон орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа нэгжийг;

4.1.2.“албан газар” гэж төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн болон орон нутгийн байгууллагын хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг эрхлэх зорилготой, үйл ажиллагаа, өмчлөх эрхээ төрөөс тогтоосон журмын дагуу хэрэгжүүлж, төсвөөс олгосон хөрөнгө болон өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.3.“төрийн болон орон нутгийн өмчит компани” гэж Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 4.1.1, 4.1.4-т заасан хуулийн этгээдийг;

4.1.4.“өмчийн удирдлага” гэж хуульд заасны дагуу өмчлөгч болон түүнээс эрх олгосон этгээдээс хэрэгжүүлэх төрийн болон орон нутгийн өмчийг олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг;

4.1.5.“хөрөнгийг удирдах” гэж өөрийн эзэмшилд байгаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хууль болон гэрээнд заасан зориулалт, нөхцөл, журмын дагуу эзэмших, ашиглах болон бусдад ашиглуулах, шилжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг.



## **5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах зориулалт, зарчим**

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийг дараах зориулалтаар удирдана:

- 5.1.1.төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 5.1.2.нийтийн эрх ашгийг хангах;
- 5.1.3.үр өгөөж, ашиг бий болгох;
- 5.1.4.нөөц бий болгох, хадгалах.

5.2.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

5.2.1.төрийн болон орон нутгийн өмч, гадаад улс болон нээлттэй далай тэнгис, агаарын орон зай дахь Монгол Улсын төрийн өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх;

5.2.2.хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх;  
5.2.3.үр өгөөжийг ард түмэнд тэгш шударга хүртээх;  
5.2.4.тооцоо, судалгаанд үндэслэсэн үр нөлөөтэй, үр ашигтай байх;  
5.2.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлж, хариуцлагатай, ил тод, нээлттэй байх;

5.2.6.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол биет болон биет бус хөрөнгийн иж бүрдэл нь нэг эд хөрөнгөд хамаарах бол өмчийн удирдлагыг нэг этгээд хэрэгжүүлэх.

## **6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл**

6.1.Төрийн болон орон нутгийн өмч нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө байна.

6.2.Төрийн болон орон нутгийн өмч нь эдийн болон эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл болох эдийн бус хөрөнгө байж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ**

### **7 дугаар зүйл.Төрийн өмчийн ангилал**

7.1.Төрийн өмч нь төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

### **8 дугаар зүйл.Төрийн нийтийн өмч**

8.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараах байгалийн баялаг, хөрөнгө нь төрийн нийтийн өмч байна:

- 8.1.1.Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар;
- 8.1.2.газрын хэвлий, түүний баялаг;
- 8.1.3.ой, түүний нөөц, дагалдах баялаг;
- 8.1.4.ус, түүний нөөц, доторх баялаг;
- 8.1.5.ан амьтан;
- 8.1.6.Эрдэнэсийн сан;
- 8.1.7.Үндэсний баялгийн сангийн хөрөнгө.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны №1 дугаарт нийтлэгдсэн.

8.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар төрийн хамгаалалтад байхаар заасан болон үр өгөөжийг нь нийт ард түмэнд хүртээхээр заасан дараах баялаг, хөрөнгө төрийн нийтийн өмчид хамаарна:

- 8.2.1.ургамал;
- 8.2.2.агаар;
- 8.2.3.агаарын орон зай;
- 8.2.4.хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаагаас бусад түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгал;
- 8.2.5.палеонтологи, археологийн олдвор;
- 8.2.6.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа;
- 8.2.7.төрийн архивын сан хөмрөг;
- 8.2.8.нийтийн зориулалтаар ашиглахаар хуульд заасан бусад.

8.3.Монгол Улсын иргэн нь бусдад эзэмшүүлж, ашиглуулснаас бусад газар, ой, усны сан бүхий газарт чөлөөтэй нэвтрэх, энэ хуулийн 8.1.3, 8.1.4, 8.1.5, 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан төрийн нийтийн өмчийг хуульд заасны дагуу хувийн болон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар ашиглах, үр шимийг хүртэх эрхтэй.

8.4.Төрийн нийтийн өмчийн газрыг Газрын тухай хуульд<sup>2</sup> заасан болзол, журмын дагуу Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, олон улсын болон гадаадын хуулийн этгээдэд ашиглуулж болно.

## **9 дүгээр зүйл.Төрийн тусгайлсан өмч**

9.1.Төрийн тусгайлсан өмчид дараах хөрөнгө хамаарна:

- 9.1.1.төрийн байгууллага, төрийн өмчит албан газрын хөрөнгө;
- 9.1.2.улсын төсвийн хөрөнгө;
- 9.1.3.Засгийн газрын тусгай сан;
- 9.1.4.улсын нөөц;
- 9.1.5.төрийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;
- 9.1.6.төрийн үйл ажиллагаанд хамаарах хуульд заасан бүртгэл, мэдээллийн сан;
- 9.1.7.хуульд заасан бусад.

## **10 дугаар зүйл.Орон нутгийн өмч**

10.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна.

10.2.Орон нутгийн өмч нь орон нутгийн нийтийн зориулалттай болон орон нутгийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

10.3.Аймаг, нийслэлийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

- 10.3.1.аймаг, нийслэлийн орон нутгийн байгууллага, албан газрын хөрөнгө;
- 10.3.2.аймаг, нийслэлийн төсөв;
- 10.3.3.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон цэвэр, бохир усны шугам, хог хаягдал болон хаягдал ус цэвэрлэх байгууламж, үерийн далан, ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө;

10.3.4.орон нутгийн тусгай болон бусад сангийн хөрөнгө;

---

<sup>2</sup> Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны №27 дугаарт нийтлэгдсэн.

10.3.5.орон нутгийн өмчит компанийн аймаг, нийслэлийн эзэмшлийн хувьцаа;  
10.3.6.аймаг, нийслэлийн нөөц;  
10.3.7.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч,  
эрх;

10.3.8.хуульд заасан бусад.

10.4.Сум, дүүргийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

10.4.1.сум, дүүргийн орон нутгийн байгууллага, албан газрын хөрөнгө;  
10.4.2.сум, дүүргийн төсөв;  
10.4.3.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж,  
талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто  
зам, авто зогсоол болон төвлөрсөн бус ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн  
байгууламж;

10.4.4.орон нутгийн тусгай болон бусад сангийн хөрөнгө;

10.4.5.орон нутгийн өмчит компанийн сум, дүүргийн эзэмшлийн хувьцаа;

10.4.6.сум, дүүргийн нөөц;

10.4.7.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;

10.4.8.хуульд заасан бусад.

10.5.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай  
хуулийн<sup>3</sup> 17.1-д заасны дагуу байгуулсан сангийн хөрөнгө нь тухайн аймаг, сум, нийслэл,  
дүүргийн тусгайлсан өмч байна.

10.6.Энэ зүйлийн 10.3.3, 10.3.5-д заасан хөрөнгө нь аймаг, нийслэлийн нийтийн  
зориулалттай өмч, 10.4.3, 10.4.5-д заасан хөрөнгө нь сум, дүүргийн нийтийн зориулалттай  
өмч байна.

10.7.Энэ зүйлийн 10.3.1, 10.3.2, 10.3.4, 10.3.6, 10.3.7-д заасан хөрөнгө нь аймаг,  
нийслэлийн тусгайлсан өмч, 10.4.1, 10.4.2, 10.4.4, 10.4.6, 10.4.7-д заасан хөрөнгө нь сум,  
дүүргийн тусгайлсан өмч байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА**

**11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

11.1.Улсын Их Хурал нь ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна.

11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн талаар Улсын Их Хурал дараах бүрэн  
эрхтэй:

11.2.1.төрийн нийтийн өмчийн үр өгөөжийг ард түмэнд хүртээх стратеги, төрийн  
болон орон нутгийн өмчийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг батлах,  
биелэлтийг хангуулах асуудлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх;

11.2.2.хуульд заасны дагуу төрийн нийтийн өмчид болон энэ хуулийн 11.2.6,  
11.2.7-д заасны дагуу төрийн өмчид хөрөнгө олж авах;

11.2.3.төрийн өмчийг удирдах эрхийг хууль тогтоомжийн дагуу Засгийн газар  
болон эрх бүхий бусад этгээдэд олгох, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх;

---

<sup>3</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны №07 дугаарт нийтлэгдсэн.

11.2.4.төрийн өмчит компанийн бүтцийн өөрчлөлтийн талаар баримтлах үндсэн чиглэл болон бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалтыг батлах;

11.2.5.төрийн өмчит компани байгуулах стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалт батлах;

11.2.6.стратегийн ач холбогдол бүхий салбарт төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах болон хувьцаа олж авах, шилжүүлэхтэй холбоотой Засгийн газрын саналыг хэлэлцэж, зөвшөөрөл олгох;

11.2.7.нийтийн эрх ашиг, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, шилжүүлэн авах шийдвэр гаргах;

11.2.8.төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогын дүн, төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын талаарх Засгийн газрын тайлан /цаашид "Өмчийн төлөв байдлын тайлан" гэх/-г хэлэлцэж, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх;

11.2.9.хуульд заасан бусад.

## **12 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

12.1.Засгийн газар нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

12.2.Засгийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхтэй:

12.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.2.2.хууль тогтоомжийн хүрээнд төрийн өмчийг удирдаж, төрийн өмчийг удирдах эрхээ хуульд заасны дагуу бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн харьяа байгууллага, албан газарт, эсхүл бусад этгээдэд шилжүүлэх, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлж, шаардлагатай асуудлаар үүрэг, чиглэл өгөх;

12.2.3.төрийн тусгайлсан өмчид болон энэ хуулийн 12.2.5-д заасны дагуу төрийн өмчид хөрөнгө олж авах;

12.2.4.Улсын Их Хурлын зөвшөөрлийг үндэслэн энэ хуулийн 11.2.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах;

12.2.5.хуульд заасан үндэслэлээр энэ хуулийн 11.2.5-д зааснаас бусад салбарт төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг олж авах, шилжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах;

12.2.6.төрийн өмчит компани байгуулах стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалт болон төрийн өмчит компанийн бүтцийн өөрчлөлтийн талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12.2.7.төрийн өмчит компани байгуулж болох нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний тодорхой салбарын болон орон нутгийн өмчит компани байгуулах салбарын жагсаалт батлах;

12.2.8.төрийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх асуудлаар шийдвэр гаргах;

12.2.9.төрийн тусгайлсан өмчийн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх;

12.2.10.улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийг үндэслэн газрыг нөхөн олговортойгоор солих, эргүүлэн авах болон хуульд заасны дагуу хураан авах шийдвэр гаргах;

12.2.11.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулах шийдвэр гаргах, гэрээ байгуулах;

12.2.12.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллага, албан газар байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, дүрмийг батлах;

12.2.13.төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогыг зохион байгуулах шийдвэр гаргах, дүнг хэлэлцэх, тооллогын талаарх Засгийн газрын тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх;

12.2.14.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргах, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх;

12.2.15.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан журмыг батлан мөрдүүлэх;

12.2.16.хуульд заасан бусад.

12.3.Засгийн газар энэ хуулийн 11.2.4, 11.2.6, 11.2.7-д заасан асуудлаар Улсын Их Хуралд санал гаргах болон энэ хуулийн 12.2.3, 12.2.5, 12.2.7, 12.2.8, 12.2.9, 12.2.11-д заасан асуудлыг хэлэлцэхдээ Төрийн өмчийн хорооны дүгнэлтийг авсан байна.

### **13 дугаар зүйл.Өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг**

13.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “Төрийн өмчийн хороо” гэх/ хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

13.2.Төрийн өмчийн хороо нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, төрийн захиргааны байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус найман гишүүнтэй байна.

13.3.Засгийн газар нь Төрийн өмчийн хороо /Засгийн газрын тохируулагч агентлаг/-ны бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, дарга, гишүүнийг томилж, чөлөөлнө.

13.4.Төрийн өмчийн хорооны хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

13.5.Төрийн өмчийн хороо нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн<sup>4</sup> 7 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

---

<sup>4</sup> Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны №16 дугаарт нийтлэгдсэн.

13.5.1.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлийг хянах;

13.5.2.төрийн тусгайлсан өмчид энэ хуулийн 12.2.5, 12.2.8, 12.2.10, 12.2.11-д зааснаас бусад үндэслэлээр хөрөнгө олж авах;

13.5.3.энэ хуулийн 12.3-т заасан асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

13.5.4.Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан хөрөнгө шилжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон энэ хуулийн 11.2.4-т заасан төрийн өмчит компанийн бүтцийн өөрчлөлт хийх шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;

13.5.5.төрийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх болон тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх, ашиглах боломжгүйд тооцож, данс, бүртгэлээс хасах саналыг хянаж, зөвшөөрөл олгох;

13.5.6.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогыг зохион байгуулж, нэгдсэн дүнг Засгийн газарт тайлагнах;

13.5.7.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг бэлтгэн Засгийн газарт тайлагнах;

13.5.8.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, хөтлөлтийг эрхлэх;

13.5.9.Орон нутгийн өмчийн газрыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар үүрэг, чиглэл өгөх;

13.5.10.төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

13.5.11.төрийн өмчийн оролцоотой компаниас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн өмчийн төлөөлөгчийг түр томилон ажиллуулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх;

13.5.12.төрийн өмчийг удирдах эрх, төрийн өмчид учруулсан хохирлыг барагдуулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

13.5.13.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн талаар төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулахад Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

13.5.14.хуульд заасан бол төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

13.5.15.хуульд заасан бусад.

13.6.Төрийн өмчийн хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

13.7.Төрийн өмчийн хорооны дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгоно.

#### **14 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

14.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуульд заасан чиг үүргийн дагуу орон нутгийн өмчийн өмчлөгч байна.

14.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн өмчийн талаар дараах нийтлэг бүрэн эрхтэй:

14.2.1.орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд өмчийн удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх асуудлыг тусган батлах, биелэлтийг хангуулах чиглэлээр тухайн шатны Засаг даргад үүрэг, чиглэл өгөх;

14.2.2.орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хөрөнгө олж авах болон хувийн өмчит компанийн хяналтын багц, түүнээс дээш хувийг олж авах, эсхүл энэ хуулийн 14.2.4, 14.2.6, 14.2.7-д заасан үндэслэлээр орон нутгийн тусгайлсан өмчид хөрөнгө олж авах;

14.2.3.хуульд заасны дагуу өмчлөх эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тухайн шатны Засаг даргад шилжүүлэх, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлж, шаардлагатай асуудлаар үүрэг, чиглэл өгөх;

14.2.4.орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа олж авах, шилжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах;

14.2.5.бусдын өмчлөлд шилжүүлж үл болох орон нутгийн тусгайлсан өмчийн жагсаалт батлах;

14.2.6.орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргах;

14.2.7.аймаг, сум, нийслэл, дүүргийн тусгай хэрэгцээг үндэслэн хуульд заасны дагуу бусдын эзэмшил газрыг нөхөн олговортойгоор солих, эргүүлэн авах шийдвэр гаргах;

14.2.8.орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргах;

14.2.9.орон нутгийн өмчийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг хэлэлцэх, тухайн шатны Засаг даргад үүрэг, чиглэл өгөх;

14.2.10.хуульд заасан бол орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

14.2.11.хуульд заасан бусад.

14.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 14.2-т зааснаас гадна орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.3.1.орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит албан газар байгуулах;

14.3.2.орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг хэлэлцэн баталгаажуулж, Төрийн өмчийн хороонд хүргүүлэх шийдвэр гаргах.

14.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 14.2.2, 14.2.4, 14.2.5, 14.2.6, 14.2.8-д заасан асуудлыг тухайн шатны Засаг даргын саналаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **15 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх**

15.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь хуульд заасны дагуу орон нутгийн өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлж, өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцна.

15.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхтэй:

15.2.1.орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

15.2.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх, тайлагнах;

15.2.3.орон нутгийн тусгайлсан өмчид энэ хуулийн 14.2.2, 14.2.6, 14.2.7-д зааснаас бусад үндэслэлээр хөрөнгө олж авах;

15.2.4.орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх, орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг бусдын өмчлөлд шилжүүлэх шийдвэр гаргах;

15.2.5.энэ хуулийн 14.2.2, 14.2.4, 14.2.5, 14.2.6, 14.2.8-д заасан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлэх;

15.2.6.орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

15.2.7.харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд өмчийн тооллогыг зохион байгуулах, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

15.2.8.орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

15.2.9.орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, орон нутаг дахь төрийн өмчийг удирдах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

15.2.10.хуульд заасан бол орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

15.2.11.хуульд заасан бусад.

15.3.Засаг дарга нь энэ хуулийн 14.2.2, 14.2.4, 14.2.5, 14.2.6, 14.2.8-д заасан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал гаргах, энэ хуулийн 15.2.3, 15.2.4-т заасан асуудлаар шийдвэр гаргахдаа Орон нутгийн өмчийн газрын дүгнэлтийг авсан байна.

### **16 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэг**

16.1.Орон нутагт төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, орон нутгийн нэгжийн удирдлагын өмчийн талаарх холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, өмчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг орон нутгийн өмчийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн Засаг даргын харьяаны агентлаг /цаашид “Орон нутгийн өмчийн газар” гэх/ хэрэгжүүлнэ.



16.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг нь томилж, чөлөөлнө.

16.3.Орон нутгийн өмчийн газар нь дараах чиг үүрэгтэй:

16.3.1.харьяа орон нутгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж, шаардлага өгөх;

16.3.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн талаар гарах шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

16.3.3.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмч шилжүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах болон бүтцийн өөрчлөлт хийх шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах;

16.3.4.орон нутгийн өмчийн болон орон нутаг дахь төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

16.3.5.орон нутгийн өмчийн оролцоотой компаниас бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор өмчийн төлөөлөгчийг түр томилон ажиллуулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх;

16.3.6.аймаг, нийслэлийн өмчийн төлөв байдлын тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх дүгнэлт, саналыг бэлтгэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, Төрийн өмчийн хороонд хүргүүлэх;

16.3.7.энэ хуулийн 65.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд оруулах орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн бүрдүүлэлт, хөтлөлтийг хариуцах;

16.3.8.энэ хуулийн 15.3-т заасан асуудлаар дүгнэлт гаргах;

16.3.9.орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг түрээслэх, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүйд тооцож, данс, бүртгэлээс хасах саналыг хянаж, зөвшөөрөл олгох;

16.3.10.орон нутгийн өмчийн тооллогыг зохион байгуулах, нэгдсэн дүнг Төрийн өмчийн хороонд хүргүүлэх;

16.3.11.орон нутгийн өмчийг удирдах эрх, орон нутгийн өмчид хохирол учруулсан асуудлаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

16.3.12.төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, төрийн албан хаагчдыг бэлтгэхэд холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

16.3.13.хуульд заасан бусад.

16.4.Орон нутгийн өмчийн газарт улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана. Улсын байцаагчийн эрхийг өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга олгоно.

16.5.Шаардлагатай бол энэ хуулийн 16.3.1, 16.3.2, 16.3.4, 16.3.7, 16.3.11, 16.3.12-т заасан чиг үүрэг бүхий өмчийн асуудал хариуцсан ажилтныг сум, дүүрэгт ажиллуулж болно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ**

**17 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангилал**

17.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дараах байдлаар ангилна:

- 17.1.1.төрийн байгууллага;
- 17.1.2.албан газар;
- 17.1.3.төрийн болон орон нутгийн өмчит компани.

17.2.Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т заасан хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах бөгөөд иргэний эрх зүйн чадвар нь хуульд заасны дагуу байгуулагдсанаар үүсэж, татан буугдсанаар дуусгавар болно.

17.3.Энэ хуулийн 17.1.3-т заасан хуулийн этгээд нь нь хувийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах бөгөөд иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

**18 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх**

18.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон хөрөнгийг хууль, дүрэмд заасны дагуу үр ашигтай удирдах, өмчийн бүртгэл, тооллого, дотоодын хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж, хөрөнгийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнах, эзэмшлийн хөрөнгөнд учирсан хохирлыг барагдуулах асуудлаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах нийтлэг үүрэгтэй.

18.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрт олгогдсон хөрөнгийг дараах шаардлагын дагуу эзэмшиж, ашиглана:

18.2.1.хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгийн бүртгэл хөтлөх, хуульд заасан бол улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүү, өмчийн болон хуульд заасан бусад тайлан, статистик мэдээ гаргах, тайлагнах;

18.2.2.хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, арчлах, зохистой болон аюулгүйн нөөц бүрдүүлэх, эрсдэлээс хамгаалах, даатгуулах;

18.2.3.илүүдэл, ашиглалтгүй хөрөнгийг түрээслэх, хөлслөх, бусад хэлбэрээр үр ашгийг дээшлүүлэх арга хэрэгслийг ашиглах;

18.2.4.хууль зүйн арга, хэрэгслийг ашиглан өмчлөгч, эзэмшигчийн эрхээ хамгаалах;

18.2.5.эд хариуцагчтай хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах;

18.2.6.дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах;

18.2.7.хөрөнгийн үйлчилгээ, ашиглалтын найдвартай, аюулгүй байдлыг хангаж бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

18.2.8.тухайлсан хуульд заасан бусад.

18.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуульд заасны дагуу хөрөнгө олж авах, өөрт олгогдсон хөрөнгийг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах болон энэ хуулийн 12.2.5, 12.2.8, 13.5.5, 14.2.2, 14.2.6, 15.2.4-т зааснаас бусад өөрийн эзэмшлийн үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг хуульд заасны дагуу бусдад ашиглуулах, шилжүүлэх болон ашиглах боломжгүйд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэр гаргах эрхтэй.

18.4.Төрөөс иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах, нийтэд тустай үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ашгийн төлөө бус санг үүсгэн байгуулж болно.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад Сангийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина.

18.6.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мөнгөн хөрөнгийг удирдах журмыг Засгийн газар батална. Журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулах бөгөөд Монголбанкны саналыг авсан байна.

18.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн зээл авах, үнэт цаас гаргахтай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 18.1, 18.2-т заасны дагуу зохицуулна.

18.8.Төрийн байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах тодорхой хөрөнгийн удирдлагыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн<sup>5</sup> 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бусад этгээдэд шилжүүлж болно. Гэрээгээр шилжүүлэх чиг үүргийн жагсаалтыг Засгийн газар батална.

18.9.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх эд хөрөнгө болон хуульд зөвшөөрөл авахаар заасан хөрөнгийг эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, ашиглуулах, данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

18.10.Төсвийн тухай хуулийн<sup>6</sup> 14.1-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх салбар, хүрээний төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн удирдлага, бүртгэл, тооллого, тайлагнах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хуульд заасан хүрээнд хяналтыг хэрэгжүүлнэ.

18.11.Төсвийн тухай хуулийн 17.1-д заасан төслийн нэгж, ашиглалтын өмнөх захиргаа нь энэ хуулийн 18.1, 18.2, 18.3-т заасан эрх, үүргийг төрийн байгууллага, албан газрын нэгэн адил хэрэгжүүлнэ.

18.12.Төрийн болон орон нутгийн өмчит компани эд хөрөнгийн эрхээ холбогдох хуульд заасны дагуу бие даан хэрэгжүүлнэ.

18.13.Төрийн өмчит компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигч нь Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

18.14.Засгийн газар болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн эрхээ өөрөө, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээдийг томилж төлөөллийн журмаар хэрэгжүүлнэ.

---

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1993 оны №3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Төсвийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны №03 дугаарт нийтлэгдсэн.

18.15.Хувьцаа эзэмшигч болон төлөөллийн журмаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдийн эрх хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар тогтооно.

### **19 дүгээр зүйл.Албан газар, түүний эд хөрөнгийн эрх**

19.1.Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн болон орон нутгийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй, эсхүл үр ашиггүй нөхцөлд албан газрыг байгуулна. Албан газрын үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус байна.

19.2.Хуульд өөрөөр заагаагүй бол албан газрыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон түүний бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох эрх хэмжээг дараах эрх бүхий этгээд хэрэгжүүлнэ:

19.2.1.төрийн өмчит албан газрыг Засгийн газар;

19.2.2.орон нутгийн өмчит албан газрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

19.3.Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчит албан газрын, аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа орон нутгийн өмчит албан газрын даргыг томилж, чөлөөлнө.

19.4.Албан газрын дүрэмд эрхлэх үндсэн үйл ажиллагаа, хүрэх үр дүн, үйл ажиллагаа эрхлэх хугацаанаас гадна дараах нөхцөлийг тусгасан байна:

19.4.1.жилийн төсвийг бэлтгэх суурь болон санхүүгийн төлөвлөгөөг жил бүр гаргах;

19.4.2.орлого, зарлагыг санхүүгийн төлөвлөгөөтэй нийцсэн байдлаар төсвийн задаргаанд тусгаж байх;

19.4.3.дотоод аудитын нэгж, эсхүл дотоод аудитортой байх эсэх, түүний ажиллах журам;

19.4.4.өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл.

19.5.Дараах албан газрыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, дүрмийг батлах болон бүтэц, зохион байгуулалт, хяналтыг тухайлсан хуулиар зохицуулна:

19.5.1.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын харьяанд ажиллах албан газар;

19.5.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах албан газар;

19.5.3.хуульд тусгайлан заасан бусад.

19.6.Албан газрын дарга нь Төрийн албаны тухай хуулийн<sup>7</sup> 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон холбогдох хууль, албан газрын дүрэмд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

19.7.Албан газар нь өөрийн үйл ажиллагааны орлогыг хууль, дүрэмд заасан чиг үүрэгтээ нийцүүлэн захиран зарцуулах эрхтэй бөгөөд хууль тогтоомж болон дүрэмд өөрөөр заагаагүй бол бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнийхээ үнэ, тарифыг тогтоож болно.

<sup>7</sup> Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны №01 дугаарт нийтлэгдсэн.

19.8.Албан газар нь энэ хуулийн 18.1, 18.2, 18.3-т заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах үүрэгтэй.

19.9.Албан газар нь хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан өмчийн тайлан мэдээ, бүртгэл, тооллогын дүнгээс гадна дараах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулах үүрэгтэй:

19.9.1.албан газрын дүрэм, удирдлагын талаарх мэдээлэл;

19.9.2.албан газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайлан;

19.9.3.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тариф;

19.9.4.албан газрын байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

19.9.5.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

19.9.6.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан хөрөнгө, бусдад өгсөн дэмжлэг, хандив, тусламж;

19.9.7.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

19.9.8.дүрэмд заасан бусад.

19.10.Албан газрын дүрэмд заасан бол байгууллагын сүүлийн таван жилийн хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан болон тухайн жил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод байршуулна.

19.11.Албан газрыг татан буулгахад энэ хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ**

### **20 дугаар зүйл.Төрийн өмчид хөрөнгө олж авах**

20.1.Төрийн өмчид дараах үндэслэлээр хөрөнгө олж авна:

20.1.1.эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан;

20.1.2.төрийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон, эсхүл хөрөнгө зарцуулсны үр дүнд шинээр бий болгосон хөрөнгө;

20.1.3.төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

20.1.4.шүүхийн болон шүүхийн бус журмаар шаардах эрх, авлага, хохирлын нөхөн төлбөрт тооцон авсан, даатгалын нөхөн олговорт авсан хөрөнгө;

20.1.5.хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өвлөх, эрх залгамжлах журмаар олж авсан хөрөнгө;

20.1.6.эзэнгүй болон дарагдмал эд хөрөнгө;

20.1.7.зээлээр авсан хөрөнгө;

20.1.8.арилжиж авсан хөрөнгө;

20.1.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө;

20.1.10.орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;

20.1.11.эргүүлэн авсан, сольж авсан газар;

20.1.12.хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн авсан, дайчлан авсан, хураасан буюу улсын орлого болгосон хөрөнгө;

20.1.13.хуульд заасан бусад.

20.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон эд хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

20.3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн эзэмших этгээдийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн эзэмших этгээдийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

20.4.Дарагдмал эд зүйл болох түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Иргэний хуулийн 118.3-т заасны дагуу төрийн өмчлөлд шилжүүлэн авна.

20.5.Бусад этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол тухайн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна.

20.6.Энэ хуулийн 20.1.9, 20.1.11, 20.1.12-т заасан журмаар төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах нөхцөл, журмыг тухайлсан хуулиар зохицуулна.

## **21 дүгээр зүйл.Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах**

21.1.Орон нутгийн өмчид энэ хуулийн 20.1.3, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.1.8, 20.1.9, 20.1.11, 20.1.12-т зааснаас гадна дараах үндэслэлээр хөрөнгө олж авна:

21.1.1.төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;

21.1.2.орон нутгийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;

21.1.3.орон нутгийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

21.1.4.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчид зориулж бэлтгэсэн хөрөнгө.

21.1.5.хуульд заасан бусад.

## **22 дугаар зүйл.Хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар хөрөнгө олж авах**

22.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Төсвийн тухай хууль, Иргэний хуульд<sup>8</sup> заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл болон өв залгамжлалын журмаар хөрөнгө олж авч болно.

22.2.Төрийн өмчит хуулийн этгээд нь бэлэг, хандив, буцалтгүй тусламжаар хүлээн авсан хөрөнгийг үнэлгээ тогтоож, данс бүртгэлд тусгах үүрэгтэй.

<sup>8</sup> Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны №7 дугаарт нийтлэгдсэн.

22.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад бэлэглэсэн, хандивласан, буцалтгүй тусламжаар олгосон хөрөнгийг үнэлэх, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг Төрийн өмчийн хороо тогтооно.

22.4.Энэ хуулийн 22.3-т заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өвийн журмаар авсан хөрөнгө нь орон нутагт зориулсан бол уг хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлнэ.

22.5.Монгол Улс, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хэрэгцээ шаардлагагүй, илүү зардал гарах, эсхүл үүрэг хүлээх нөхцөлтэй хөрөнгийг бэлэг, хандив, өвийн журмаар хүлээн авахаас татгалзах эрхтэй.

### **23 дугаар зүйл.Хураан авах журмаар хөрөнгө олж авах**

23.1.Хураан авсан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар хүлээн авч, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг тогтооно.

23.2.Эрх бүхий этгээдийн шийдвэрт хураан авсан хөрөнгийг тодорхой нэг хуулийн этгээдэд шилжүүлэхээр заасан бол хөрөнгийг тухайн этгээдийн эзэмшилд шилжүүлнэ.

23.3.Хураан авсан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгож улсын төсвийн дансанд оруулна.

23.4.Хураан авсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг төрийн өмчид шилжүүлэх бөгөөд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу эзэмших этгээдийг тогтооно.

23.5.Хураан авсан хөрөнгө нь хэрэгцээ, шаардлага хангахгүй, хуулиар хориглосон, аюултай эд зүйл бол хүлээн авахаас татгалзаж болно.

23.6.Хураан авсан эд зүйлийн үнэлгээ нь бодит байдалтай нийцэхгүй бол үнэлгээг шинээр тогтооно. Шинээр тогтоосон үнэлгээгээр хөрөнгийг бүртгэж, үнэлгээний хувийг тухайн өмчийг хураан авах шийдвэр гаргасан этгээдэд хүргүүлнэ.

23.7.Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар нь энэ хуулийн 23.5-д заасны дагуу гаргасан хөрөнгийг хүлээн авахаас татгалзах шийдвэрийг тухайн хөрөнгийг хураан авах шийдвэр гаргасан этгээдэд даруй мэдэгдэнэ.

23.8.Хохирлын нөхөн төлбөрт хураан авсан хөрөнгийн үнэлгээг энэ хуулийн 23.6-д заасны дагуу шинээр тогтоосны улмаас үнийн зөрүү үүссэн, эсхүл хөрөнгийг энэ хуулийн 23.5-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан бол Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **24 дүгээр зүйл.Хөрөнгийг өмчлөх эрх дуусгавар болох**

24.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн өмчлөх эрх нь Иргэний хууль болон энэ хуульд заасан үндэслэлээр дуусгавар болно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГО**

### **25 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл**

25.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг дараах ангиллын дагуу цаасан болон цахим хэлбэрээр хөтөлнө:

- 25.1.1.төрийн өмчийн бүртгэл;
- 25.1.2.орон нутгийн өмчийн бүртгэл.

25.2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь дараах мэдээллийг агуулсан байна:

- 25.2.1.хөрөнгийн зориулалт, бусад хөрөнгөөс ялгаж тодорхойлох мэдээлэл;
- 25.2.2.тухайн хөрөнгийн удирдлага, хадгалалт, хамгаалалтыг хариуцах эрх бүхий этгээдийн мэдээлэл;

25.2.3.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмших, ашиглах, түүнтэй холбоотой бусад эрх үүссэн, нэмэгдсэн, өөрчлөгдсөн, дуусгавар болсонтой холбогдох мэдээлэл;

25.2.4.хяналтын багцыг эзэмшиж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны бизнес, стратеги төлөвлөлт;

25.2.5.хөрөнгийн ашиглалтын нөхцөл, хүчин чадал болон засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл.

25.3.Хуульд заасан бол хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулна.

## **26 дугаар зүйл.Төрийн өмчийн бүртгэл**

26.1.Бүртгэлийн асуудлыг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад төрийн өмчийн бүртгэлийг дараах байдлаар төрөлжүүлэн хөтөлнө:

- 26.1.1.төрийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн өмч, хөрөнгө;
- 26.1.2.төрийн байгууллага, албан газрын үл хөдлөх эд хөрөнгө;
- 26.1.3.төрийн өмчит компани дахь төрийн эзэмшлийн хувьцаа;
- 26.1.4.төрийн өмчид хамаарах соёлын биет өв;
- 26.1.5.төрийн өмчид хамаарах оюуны өмч;
- 26.1.6.итгэмжлэл, бусад удирдлагын гэрээгээр шилжүүлсэн төрийн тусгайлсан өмчийн хөрөнгө.

26.1.7.бусад өмч, хөрөнгө, эрх.

26.2.Хуулиар тухайлан зохицуулсан төрийн нийтийн болон тусгайлсан өмчийн бүртгэлийг тухайн хуульд заасны дагуу хөтөлнө.

26.3.Хуульд тухайлан заасан бол төрийн нийтийн өмчийн төрлөөр дагнасан бүртгэл хөтлөх журмыг холбогдох эрх бүхий этгээд батална.

## **27 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн бүртгэл**

27.1.Бүртгэлийн асуудлыг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад орон нутгийн өмчийн бүртгэлийг дараах байдлаар төрөлжүүлэн хөтөлнө:

- 27.1.1.орон нутгийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн өмч, хөрөнгө;
- 27.1.2.орон нутгийн байгууллага, албан газрын үл хөдлөх эд хөрөнгө;
- 27.1.3.орон нутгийн өмчит компани дахь орон нутгийн эзэмшлийн хувьцаа;
- 27.1.4.орон нутгийн өмчид хамаарах оюуны өмч;
- 27.1.5.итгэмжлэл, бусад удирдлагын гэрээгээр шилжүүлсэн орон нутгийн өмчийн хөрөнгө;

27.1.6.орон нутгийн нийтийн өмчид хамаарах хөрөнгө;



27.1.7.бусад өмч, хөрөнгө, эрх;

27.2.Орон нутгийн нөөцийн бараа, материал, материаллаг зүйлийн бүртгэлийг эрх бүхий байгууллага хуульд заасны дагуу хөтөлж, удирдана.

## **28 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл**

28.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээрийг ашиглах, шилжүүлэх болон холбогдох гэрээ хэлцэлд хяналт тавих, бүртгэлийн нэгдмэл байдал болон мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг хөтөлнө.

28.2.Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

28.3.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

28.3.1.үл хөдлөх эд хөрөнгө, түүний зориулалт;

28.3.2.үл хөдлөх эд хөрөнгийн хөдөлгөөн, удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээдийн талаарх мэдээлэл;

28.3.3.үл хөдлөх хөрөнгийг ашиглуулах, дамжуулан ашиглуулах болон шилжүүлэх гэрээ, тухайн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шийдвэр, мэдэгдэл, бусад гэрээ;

28.3.4.бусдын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд ашиглаж байгаа бол холбогдох шийдвэр, гэрээ;

28.3.5.үл хөдлөх эд хөрөнгийн цахилгаан, дулаан ашиглалтын талаарх мэдээлэл;

28.3.6.хуульд заасан бусад.

28.4.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээд нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний талаарх мэдээллийг гэрээ байгуулсан, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш ажлын таван өдрийн дотор бүртгэлд оруулах үүрэгтэй. Гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын таван өдрийн дотор төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд оруулна.

28.5.Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээдийн талаарх мэдээллээс бусад мэдээлэл хууль зүйн үр дагавар үүсгэхгүй бөгөөд тэдгээрийг статистикийн болон мэдээллийн зорилгоор ашиглана.

## **29 дүгээр зүйл. Өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журам**

29.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг дараах этгээд хариуцан хөтөлнө:

29.1.1.төрийн өмчийн бүртгэлийг Төрийн өмчийн хороо;

29.1.2.орон нутгийн өмчийн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар;

29.1.3.төрийн болон албаны нууцад хамаарах өмчийн бүртгэлийг энэ хуулийн 3.5-д заасан журмаар эрх олгосон этгээд, Төрийн өмчийн хороо хамтран;

29.1.4.Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт бүртгэлтэйгээс бусад Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна оршиж байгаа Монгол Улсын төрийн өмчийн бүртгэлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн хороо хамтран.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийн анхан шатны бүртгэлийг хариуцан хөтөлнө.

29.3.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо батална.

29.4.Энэ хуулийн 29.1.3-т зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн ангилал, код, маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг үндэслэн Төрийн өмчийн хороо батална.

### **30 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого**

30.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого дараах төрөлтэй байна:

- 30.1.1.улсын тооллого;
- 30.1.2.орон нутгийн өмчийн тооллого;
- 30.1.3.дотоодын тооллого.

30.2.Улсын болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам, аргачлалыг Төрийн өмчийн хороо, хуульд тухайлан заасан бол өмчийн төрлөөр дагнасан тооллого явуулах журмыг эрх бүхий этгээд батална.

30.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг тухайн өмчийн бүртгэл дээр үндэслэн явуулна.

### **31 дүгээр зүйл.Улсын тооллого**

31.1.Улсын тооллогыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

31.1.1.төрийн тусгайлсан өмчийн болон орон нутгийн өмчийн эргэлтийн бус хөрөнгийн (шаардлагатай бол эргэлтийн хөрөнгийг хамруулах) улсын нэгдсэн тооллого;

31.1.2.төрийн нийтийн өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

31.1.3.төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

31.1.4.тодорхой салбарт ашиглагдах төрийн болон орон нутгийн өмчийн дагнасан тооллого.

31.2.Энэ хуулийн 31.1.1-д заасан тооллогыг 4 жил тутам, 31.1.2-т заасан тооллогыг холбогдох хуульд заасан хугацаанд, 31.1.3, 31.1.4-т заасан тооллогыг Засгийн газрын шийдвэрээр тухай бүр зохион байгуулна.

31.3.Улсын тооллогын зохион байгуулалтыг улсын хэмжээнд Төрийн өмчийн хороо, орон нутгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн газар хариуцна.

31.4.Шаардлагатай бол улсын тооллогыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах төлөөлөгчийг орон нутагт, эсхүл тодорхой салбарт Төрийн өмчийн хороо томилон ажиллуулж болно.

31.5.Засгийн газар энэ хуулийн 31.1-д заасан улсын тооллогын дүнг Улсын Их Хуралд хүргүүлнэ.

### **32 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн тооллого**

32.1.Орон нутгийн өмчийн тооллогыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Орон нутгийн өмчийн газар, Засаг дарга хамтран зохион байгуулна.

32.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр сум, дүүргийн хэмжээнд өмчийн тооллого зохион байгуулж болно.

32.3.Орон нутгийн өмчийн тооллогын зардлыг орон нутаг хариуцна.

### **33 дугаар зүйл.Дотоодын тооллого**

33.1.Дотоодын тооллогыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага дараах хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгах үүрэгтэй:

33.1.1.үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт болон барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 31-ний өдрийн дотор;

33.1.2.түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг хагас жил тутам гүйцэтгэж, тайланг тухайн оны 6 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

33.1.3.дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд тутам хийж, тайланг улирлын сүүлийн сарын 25-ны өдрийн дотор;

33.1.4.мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж, тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор;

33.1.5.мал, амьтдын тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

33.1.6.бүх төрлийн харилцах дансны хуулгыг тухай бүр нь авч, дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг баталгаажуулах;

33.1.7.гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас хөрөнгөнд хохирол учирсан, эсхүл хөрөнгийг арилжих бол хэсэгчилсэн тооллогыг тухай бүр.

33.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хөрөнгийн дотоодын тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг тооцож, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

### **34 дүгээр зүйл.Тооллого хийхэд бэлтгэх**

34.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэлийг хангах үүрэгтэй:

34.1.1.үндсэн хөрөнгө, түүнд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх;

34.1.2.бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хөрөнгө хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;

34.1.3.агуулахад байгаа түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл зэрэг эд хөрөнгийг төрөлжүүлж, хураалт, хадгалалтыг цэгцэлсэн байх;

34.1.4.хэрэгцээнээс илүү байгаа үндсэн хөрөнгө, түүхий эд, хагас боловсруулсан зүйл, бэлэн бүтээгдэхүүн ашиглаж болох хоёрдогч түүхий эд зэргийг агуулахад шилжүүлж гологдол болсон бүтээгдэхүүнийг шийдвэрлэсэн, гүйцэтгэсэн ажлын бүртгэл хөтлүүлж,

дуусаагүй ажлын хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажлын хэмжээг тодорхойлсон байх;

34.1.5.мал, амьтныг эзэмшигч бүрээр тоолоход бэлтгүүлэх;

34.1.6.тооллогод хэрэглэгдэх хэмжих багаж, хэрэгслийг шалган баталгаажуулж бараа материалын үнийн болон хэвийн хорогдлын нормын жагсаалтыг үйлдсэн байх;

34.1.7.өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх;

34.1.8.өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх;

34.1.9.хөрөнгийн мэдээллийг батлагдсан аргачлалын дагуу бүртгэлд тусгасан байх.

### **35 дугаар зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг**

35.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага тооллого эхлэхээс өмнө Тооллогын комисс байгуулна.

35.2.Тооллогын комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусгах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

35.3.Тооллогын комисс дараах эрхтэй:

35.3.1.тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтыг хүлээн авсан эсэхийг шалгах;

35.3.2.тооллого явуулахын өмнө хариуцагчийн хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох этгээдээс шаардах;

35.3.3.тооллогын явц дундуур түүхий эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, тавьж олгох явдлыг бүрэн зогсоох, байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулахгүйн тулд тооллогын комиссын хяналт дор зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

35.4.Тооллогын комисс дараах үүрэгтэй:

35.4.1.хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

35.4.2.тоолсон, хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишиг үнэтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

35.4.3.агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

35.4.4.комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

35.4.5.эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр авсан, доогуур үнээр борлуулсан

үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг гаргаж, холбогдуулан авах арга хэмжээний талаарх санал гаргах.

35.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий /ахлах/ нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана.

### **36 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ**

36.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бүрийн үнэлгээг бүртгэлд тусгасан байна.

36.2.Хөрөнгийг удирдах этгээд нь дараах ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө тухайн хөрөнгөнд үнэлгээ хийлгэх үүрэгтэй:

- 36.2.1.хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх бол;
- 36.2.2.компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах бол;
- 36.2.3.бусад этгээдээс тухайн өмчид хөрөнгө оруулах бол;
- 36.2.4.төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох бол;
- 36.2.5.хохирол арилгуулах, нэхэмжлэх бол;
- 36.2.6.авлагад тооцож хөрөнгө хүлээн авах, өглөгөд тооцож хөрөнгө шилжүүлэх

бол;

- 36.2.7.барьцаа, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавих бол;
- 36.2.8.хуульд заасан бусад.

36.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь дараах тохиолдолд хөрөнгийн үнэлгээг хийлгэж болно:

36.3.1.тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон бол;

36.3.2.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой үл хөдлөх эд хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох бол;

36.3.3.хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаагүй боловч цаашид ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй, эсхүл ашиглах боломжгүй болсон бол;

36.3.4.шаардлагатай бусад.

36.4.Үл хөдлөх хөрөнгө, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, биет бус хөрөнгө, хязгаарлагдмал эрхээс бусад дараах хөрөнгийн үнийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн тухайн байгууллагын удирдлага шинэчлэн тогтоож болно:

36.4.1.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгө;

36.4.2.акталсан боловч бусдад худалдах боломжтой хөрөнгө.

36.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээ хийх нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо, хуульд тусгайлан заасан бол эрх бүхий этгээд батална.

### **37 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг магадлах ажиллагаа**

37.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхийн өмнө төрийн болон орон нутгийн хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор магадлах ажиллагаа хийнэ.

37.2.Дараах тохиолдолд магадлах ажиллагаа хийхгүй байж болно:

37.2.1.төрийн болон орон нутгийн байгууллага, албан газарт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, эсхүл улс орны эдийн засгийн хөгжилд ач холбогдол бүхий хөрөнгө оруулалттай төслийг хэрэгжүүлэх, эсхүл тухайн бүс нутагт бизнесийн орчныг хөгжүүлэхэд төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хязгаарлагдмал эрхээр ашиглуулах шаардлагатай болсон бол;

37.2.2.үл хөдлөх хөрөнгийг нийтийн хэрэгцээний шугам сүлжээний ажил, улсын болон орон нутгийн чанартай автозамын ажилд ашиглуулж байгаа бол;

37.2.3.үл хөдлөх хөрөнгөд сервитутын эрх үүсгэж байгаа бол.

37.3.Магадлах ажиллагааг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн баг хэрэгжүүлнэ:

37.3.1.өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд;

37.3.2.хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл үл хөдлөх хөрөнгө байрлаж байгаа нэгжийн нутгийн захиргааны байгууллага;

37.3.3.Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар;

37.3.4.холбогдох бусад.

37.4.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь магадлах ажиллагаа явуулах тухай мэдэгдэл гаргаж нийтэд мэдээлнэ. Магадлах ажиллагааг эхлүүлэхээс өмнө ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах тухай хүсэлтийг мэдэгдэлд хавсаргана.

37.5.Сонирхогч этгээдээс тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах хүсэлт хүлээн авах хугацааг энэ хуулийн 37.4-т заасан мэдэгдлийг нийтлүүлсэн өдрөөс хойш 21 хүртэл хоног байхаар тогтооно.

37.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт нь бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтээс давуу эрхтэйд тооцогдоно.

37.7.Үл хөдлөх эд хөрөнгийн магадлах ажиллагаа явуулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

### **38 дугаар зүйл.Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох**

38.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дараах тохиолдолд ашиглах боломжгүй болсонд тооцно:

38.1.1.ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан ба цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

38.1.2.иргэний гүйлгээнд оруулахыг хуулиар хориглосон;

38.1.3.улс, олон нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд илт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй болсон;

38.1.4.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

38.1.5.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй болсон;

38.1.6.бүрэн болон хэсэгчлэн утсан, гэмтсэн, тоногдсон, муудсан, хулгайд алдагдсан зэрэг шалтгааны улмаас ашиглах, хэрэглэх, эсхүл бусдад ашиглуулах, шилжүүлэх боломжгүй болсон.

38.2.Төрийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэрийг тухайн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн саналыг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо, орон нутгийн байгууллага, албан газрын эзэмшлийн хөрөнгийн хувьд Орон нутгийн өмчийн газар зөвшөөрөл олгоно.

38.3.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газрын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 38.1.1, 38.1.2, 38.1.3, 38.1.4-т заасан үндэслэлээр өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгө, газар ашиглах эрх болон тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөс бусад хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг Өмч хамгаалах зөвлөлийн санал, эсхүл тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн гаргана.

38.4.Төрийн байгууллага, албан газрын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 13.5.5, 16.3.9-д заасан хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг гаргана.

38.5.Энэ хуулийн 38.1.6-д заасан үндэслэлээр хөрөнгө данснаас хасах тохиолдолд буруутай этгээдийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

38.6.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах боломжгүй болсонд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийн тодорхойлолт, шийдвэр гаргасан үндэслэл болон бусдад шилжүүлэх, устгах хэлбэрийг тодорхой тусгаж, шаардлагатай бусад мэдээллийг хавсаргана.

### **39 дүгээр зүйл.Ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасах**

39.1.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон хөрөнгийг бусдад шилжүүлсэн, устгасан, барилга байгууламж бол нурааж буулгасан, сэлбэгээр ашиглах болсон тухай тэмдэглэгээг холбогдох бүртгэлд хийж, данс бүртгэлээс хасна.

39.2.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах, ажиллагааг боломжит хамгийн бага зардлаар, хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр гүйцэтгэнэ.

39.3.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, данс бүртгэлээс хасах журмыг Төрийн өмчийн хороо батална.

39.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгах, данснаас хассан нь төрийн газар ашиглах эрхийг дуусгавар болгох, эсхүл зориулалтыг өөрчлөх үндэслэл болохгүй.

39.5.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, газар ашиглах эрхийг эрх бүхий этгээдийн шийдвэр, энэ хуулийн 13.5.5, 16.3.9-д заасан хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙГ АШИГЛУУЛАХ**

#### **40 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах**

40.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор бусад этгээдэд гэрээний үндсэн дээр төлбөртэй, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр хөлслүүлэх, түрээслүүлэх, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулж болно.

40.2.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулахтай холбоотой нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг Иргэний хууль болон Газрын тухай хуулиар зохицуулна.

40.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувийн хэвшилд эзэмшүүлэх, ашиглуулах журмыг Засгийн газар батална.

40.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн эзэмшилд байгаа хөрөнгийг барьцаалах, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавих болон хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж, эсхүл зориулалтын бусаар, эсхүл эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй, эсхүл хууль бусаар төлбөргүй, төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хөрөнгийг бусдад ашиглуулахыг хориглоно.

40.5.Төрийн тусгайлсан өмчийн хөрөнгийг барьцаалах, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавих шийдвэрийг Засгийн газар гаргана.

40.6.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах шийдвэр гаргахаас өмнө магадлах ажиллагааг энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу явуулна.

40.7.Хөрөнгө ашиглуулах гэрээг бичгээр байгуулах бөгөөд гэрээнд хөрөнгийг ашиглах зориулалт, нөхцөл, хугацаа, төлбөрийн хэмжээ, төлбөрт тохируулга хийх нөхцөл болон татвар зэрэг хөрөнгөтэй холбоотой үүсэх нэмэлт зардлыг төлбөрт хамруулах эсэх, төлбөр төлөх журам болон хөрөнгийг дамжуулан ашиглуулж болох эсэхийг тодорхой тусгасан байна.

40.8.Өмч ашиглалтын төлбөрийг зах зээлийн үнээр тогтоох бөгөөд хуульд заасан үндэслэлээр хөрөнгийг төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж болно. Ашиглалтын хөнгөлөлттэй төлбөрийн доод хэмжээ нь тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай хадгалалт, хамгаалалтын зардлаас багагүй байна.

40.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулсны төлбөрийг улсын болон орон нутгийн төсөвт оруулна.

40.10.Төрийн өмчийн хөрөнгө ашиглуулах гэрээний бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах гэрээний бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

40.11.Төрийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

40.12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглаж байгаа этгээд зориулалтын бусаар ашигласан, эсхүл гэрээнд заасан нөхцөлийг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 40.4-т заасныг зөрчиж гэрээ байгуулсан тохиолдолд гэрээг цуцалж, хөрөнгийг буцаан авах, хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно.

40.13.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах болон барьцаа авах журам, гэрээний үлгэрчилсэн загварыг Төрийн өмчийн хороо батална.



40.14.Өмчийг 10 болон түүнээс дээш жилийн хугацаагаар ашиглуулах бол Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авсан байна.

#### **41 дүгээр зүйл.Хөрөнгийг төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй төлбөрөөр ашиглуулах**

41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараах үндэслэлээр төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж болно:

41.1.1.албан ажлын хэрэгцээнд, эсхүл улс болон орон нутгийн хөгжлийг дэмжих төслийг хэрэгжүүлэхэд зориулан төрийн болон орон нутгийн байгууллагад үнэ төлбөргүй;

41.1.2.албан газрын үйл ажиллагааны зорилго, чиглэл, нийтийн эрх ашгийг харгалзан үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй төлбөрөөр;

41.1.3.хууль тогтоомжид заасан бол төрийн болон орон нутгийн тодорхой чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдэд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулж, эсхүл ашгийн төлөө бус хуулийн этгээдээс явуулж байгаа нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй төлбөрөөр;

41.1.4.олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн зэрэг нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагааны зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй төлбөрөөр;

41.1.5.хуульд заасан бусад.

41.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй ашиглаж байгаа бол ашиглагч нь тухайн эд хөрөнгийн элэгдэл, ашиглалтын зардлыг төлнө.

41.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй болон хөнгөлөлттэй төлбөрөөр ашиглуулах, шилжүүлэх нөхцөл, төлбөрийн хэмжээ болон хөнгөлөлт тогтоох аргачлал, үнийн тохируулга хийх болон түрээсийн зүйлд хөрөнгө оруулах нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

41.4.Энэ хуулийн 40.12-т заасан үндэслэлээр гэрээ цуцлагдаж байсан этгээдэд дахин хөрөнгө ашиглуулахыг хориглоно.

#### **42 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах**

42.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах бол холбогдох шийдвэрт эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг тусгана.

42.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг сервитутээр ашиглуулах тухай шийдвэрт сервитут хэрэгжих талбай, нэвтрэх буюу зорчих хэсгийн зураглалыг хавсаргана.

42.3.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих хязгаарлагдмал эрх бүхий этгээд нь уг эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, сервитут тогтоох, уг эрхийн үндсэн дээр баригдсан барилга байгууламжийг гуравдагч этгээдэд ашиглуулахдаа өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс зөвшөөрөл авна.

42.4.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг харилцан тохиролцсон зорилгоос өөрөөр ашигласан бол өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно.

42.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтад олгосон газрыг эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр бусдад хязгаарлагдмал эрхээр ашиглуулах, зориулалтын бус барилга байгууламж барихыг хориглоно.

#### **43 дугаар зүйл.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээ, төлбөр**

43.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээ нь хууль болон хязгаарлагдмал эрх үүсгэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэрт нийцсэн байна.

43.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээнд хязгаарлагдмал эрхийн төрөл, агуулгыг тусгана.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөр төлөх журмыг эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн гэрээгээр тохирно.

43.4.Хязгаарлагдмал эрхийн төлбөр төлөх үүргийг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэх бөгөөд хязгаарлагдмал эрх дуусгавар болсноор уг эрхийн бүртгэлийг хүчингүй болгоно.

43.5.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээнд заасан нөхцөл байдал өөрчлөгдсөн, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрх үүссэнээс хойш гурван жил тутамд уг эрхийн төлбөрийн хэмжээнд тохируулга хийхийг шаардах эрхтэй байна.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙГ БУСДЫН ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЭХ**

#### **44 дүгээр зүйл.Хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх үндэслэл**

44.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн нийтийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмч, газар ашиглах эрхийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавихыг хориглоно.

44.2.Шилжүүлэхийг хуулиар хориглосноос бусад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараах үндэслэлээр бусдад шилжүүлж болно:

44.2.1.илүүдэлтэй, эсхүл зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон хөрөнгийг худалдах, арилжих;

44.2.2.энэ хуулийн 41.1-д заасан хэрэгцээг харгалзан хөрөнгийг шилжүүлэх шийдвэрийг эрх бүхий этгээд гаргасан;

44.2.3.арилжиж байгаа хөрөнгийн үнийн зөрүүнд тооцож өгөх;

44.2.4.өр, бусдад учирсан хохирлыг нөхөн төлөх;

44.2.5.компанийн хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх буюу өмч шилжүүлэх замаар төлөх, хувь нийлүүлэх;

44.2.6.хөрөнгийн үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилгоор худалдах, эсхүл хэрэгцээтэй өөр хөрөнгөөр арилжих шийдвэрийг эрх бүхий этгээд гаргасан;

44.2.7.хандивлах, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх;

44.2.8.хуульд заасан бусад.

44.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг энэ хуулийн 44.2-т зааснаас бусад үндэслэлээр аливаа этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

44.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг түүний зах зээлийн үнэлгээтэй тэнцэх хэмжээний төлбөртэйгөөр бусдад шилжүүлнэ.

44.5.Энэ хуулийн 41.1-д заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр шилжүүлж болно.

44.6.Төрийн болон орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр шилжүүлэх нөхцөл, төлбөрийн хэмжээг энэ хуулийн 41.3-т заасан журмаар тогтооно.

44.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй, хөнгөлөлттэй төлбөрөөр, эсхүл нэмэлт нөхцөлтэйгөөр шилжүүлэн авсан этгээд хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, эсхүл нэмэлт нөхцөлийг зөрчсөн нь гэрээг цуцалж, хөрөнгийг буцаан авах, хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно.

44.8.Энэ хуулийн 44.7-д заасан үндэслэлээр гэрээ цуцлагдаж байсан этгээдэд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр шилжүүлэхийг хориглоно.

44.9.Төрийн өмчийн эд хөрөнгөөс хандив, тэтгэмж, тусламж олгох журмыг Засгийн газар, орон нутгийн өмчийн эд хөрөнгөөс хандив, тэтгэмж, тусламж олгох журмыг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батална.

#### **45 дугаар зүйл.Хөрөнгө шилжүүлэх шийдвэр гаргах**

45.1.Өмчлөгч, эсхүл хуульд заасны дагуу тухайн хөрөнгийг бусдад шилжүүлэх эрх бүхий этгээд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

45.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх тухай шийдвэр гаргахад дараах нөхцөлийг урьдчилан тогтоосон байна:

45.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад шилжүүлэх болсон үндэслэл, үнэлгээний тайлан, дүгнэлт;

45.2.2.шилжүүлэн өгөх этгээдийг тогтоох арга, тухайн аргыг сонгосон үндэслэл;

45.2.3.худалдах, арилжих доод үнэ, үнэ тогтоосон аргачлал, төлбөрийн нөхцөл;

45.2.4.уралдаант шалгаруулалтаар шилжүүлэх бол нэмэлт нөхцөл;

45.2.5.арилжааны журмаар шилжүүлэх бол нэмэлт нөхцөл;

45.2.6.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах, төлөөлөн гэрээ байгуулах этгээд, түүний эрх, үүрэг;

45.2.7.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах зардал, зардлын эх үүсвэр.

45.3.Хөрөнгө шилжүүлэх шийдвэрт шилжүүлэх хөрөнгийн тоо хэмжээ, үнэлгээ болон хөрөнгийг хүлээлгэн өгөх, өмчлөх эрхийг шилжүүлэх журам, нөхцөл, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалт, хугацаа зэрэг мэдээллийг тусгасан байна.

45.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг шилжүүлэх шийдвэрт тусгагдах нэмэлт нөхцөлийг холбогдох хуулиар зохицуулна.

45.5.Энэ хуулийн 45.1-д заасан этгээд нь өмч шилжүүлэх шийдвэр гаргахын өмнө хөрөнгийг үнэлэх болон үл хөдлөх хөрөнгийн магадлах ажиллагаа хийж, хуульд заасан бол холбогдох дүгнэлт, зөвшөөрлийг гаргуулсан байна.

#### **46 дугаар зүйл.Хөрөнгийг шилжүүлэх журам**

46.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдын өмчлөлд дараах журмаар шилжүүлнэ:

- 46.1.1.дуудлага худалдаа;
- 46.1.2.уралдаант шалгаруулалт/төсөл сонгон шалгаруулах;
- 46.1.3.шууд гэрээ байгуулах.

46.2.Шаардах эрх, урлагийн бүтээл зэрэг үнэлгээг нь шууд тогтоох боломжгүй хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг холбогдох хуульд заасан тусгай аргыг ашиглан хөрөнгийн үнэлгээг тогтоож болно.

46.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэхдээ тэргүүн ээлжид дуудлага худалдааны аргыг хэрэглэх бөгөөд тусгай нөхцөл заах шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

46.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараах үндэслэлээр бусдын өмчлөлд шууд гэрээ байгуулах журмаар шилжүүлж болно:

46.4.1.энэ хуулийн 44.2.1, 44.2.2-т заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар хооронд;

46.4.2.энэ хуулийн 44.2.2-т заасан үндэслэлээр 41.1.3, 41.1.4-т заасан этгээдэд;

46.4.3.энэ хуулийн 44.2.3, 44.2.4, 44.2.5, 44.2.7-д заасан үндэслэлээр бусад этгээдэд.

46.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг энэ хуулийн 46.4-т зааснаас бусад үндэслэлээр шууд гэрээ байгуулах журмаар бусад этгээдийн өмчлөлд шилжүүлэхийг хориглоно.

46.6.Төрийн өмчийн хөрөнгө шилжүүлэх ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

46.7.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх журам, гэрээний загварыг Төрийн өмчийн хороо батална.

#### **47 дугаар зүйл.Хөрөнгийг өөр хөрөнгөөр арилжих**

47.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэрэгцээгүй боловч бусад этгээдэд хэрэгцээтэй хөрөнгийг өөрт хэрэгцээтэй хөрөнгөөр арилжиж болно.

47.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн арилжааг нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай нөхцөлд хийнэ.

47.3.Энэ хуулийн Хөрөнгийн арилжаа хийх нөхцөл, шаардлагыг ил тод зарлаж, арилжаа хийх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулна.

47.4.Хөрөнгийн арилжаа хийхийн өмнө арилжих хөрөнгө тус бүрийн үнэлгээг энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу, үл хөдлөх эд хөрөнгө бол магадлах ажиллагааг энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу хийнэ.

47.5.Энэ хуулийн 47.4-т заасны дагуу тогтоосон үнэлгээний талаар талууд саналын зөрүүтэй байгаа нөхцөлд үнэлгээг хөндлөнгийн хараат бус үнэлгээчнээр хийлгэнэ.

47.6.Арилжиж байгаа хөрөнгийн зах зээлийн үнийн зөрүү үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 10 хувиас, хөдлөх эд хөрөнгийн хувьд 30 хувиас хэтрэхгүй байна.

47.7.Энэ хуулийн 47.6-д заасны дагуу арилжиж байгаа хөрөнгийн үнийн зөрүүг мөнгөн хэлбэрээр тооцон авах бөгөөд орлогыг улс, орон нутгийн төсөвт, хэрэв хуульд заасан бол тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө болно.

47.8.Харилцан тохиролцсон бол арилжин авч байгаа хөрөнгийн үнийн зөрүүнд тооцон түүнтэй тэнцүү үнэлгээ бүхий хөрөнгийг өгч болно.

47.9.Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр арилжина.

47.10.Соёлын биет өвийг бусдад арилжихыг хориглоно.

#### **48 дугаар зүйл.Хөрөнгө шилжүүлэх гэрээ**

48.1.Энэ хуулийн 45.1-д заасан эрх бүхий этгээд нь хөрөнгө шилжүүлэн авч байгаа этгээдтэй дараах нөхцөл бүхий гэрээг бичгээр байгуулна:

48.1.1.хөрөнгийн нийт үнэ, түүнийг төлөх хугацаа, хэлбэр;

48.1.2.өмчлөх эрхийн гэрчилгээ олгох нөхцөл;

48.1.3.хөрөнгийг шилжүүлэн өгөх газар, хугацаа болон хүлээлцэх ажлыг гүйцэтгэх журам, талуудын эрх, үүрэг;

48.1.4.хөрөнгийг хариу төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр шилжүүлж байгаа бол өмчийг ашиглах тусгай зориулалт, хөрөнгө шилжүүлэн авсан зорилгыг биелүүлэх хугацаа;

48.1.5.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;

48.1.6.хөрөнгийн ашиглалтын талаар хүлээх үүрэг, хариуцлага болон эд хөрөнгийг хүлээн авах, хүлээлгэн өгөх хугацаа, журам зөрчсөний хариуцлага, маргаан шийдвэрлэх журам;

48.1.7.бусад нэмэлт нөхцөл.

48.2.Гэрээнд хөрөнгө хүлээлгэн өгсөн тухай акт болон холбогдох баримт бичгийг хавсаргана.

48.3.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр хөрөнгө шилжүүлэх бол гэрээг Төрийн өмчийн хороо, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр шилжүүлэх хөрөнгийн гэрээг тухайн шатны Засаг дарга энэ хуулийн 48.1-д заасны дагуу байгуулна.

48.4.Хөрөнгө шилжүүлэх гэрээний нэгдсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо хөтөлнө.

#### **49 дүгээр зүйл.Өмч шилжүүлсний дараах хяналт**

49.1.Өмч шилжүүлсний дараах хяналтыг хөрөнгийг шилжүүлсэн зорилго, хөрөнгийг ашиглах тусгай зориулалт болон уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөлийг хангаж байгаа эсэхийг энэ хуульд заасан гэрээний биелэлтийг хянах болон хяналт шалгалтын журмаар хэрэгжүүлнэ.

49.2.Өмч шилжүүлсний дараах хяналтыг дараах этгээд хэрэгжүүлнэ:

49.2.1.гэрээний биелэлтийн хяналтыг энэ хуулийн 45.1-д заасан этгээд;

49.2.2.хяналт шалгалтын журмаар хэрэгжүүлэх төрийн өмчид хамаарах хяналтыг Засгийн газрын шийдвэрээр Төрийн өмчийн хороо;

49.2.3.хяналт шалгалтын журмаар хэрэгжүүлэх орон нутгийн өмчид хамаарах хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр орон нутгийн өмчийн газар.

49.3.Өмч шилжүүлсний дараах хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.

49.4.Өмч шилжүүлэн авсан этгээд өмчийг шилжүүлсэн зорилго, зориулалтаас гадуур ашигласан, гэрээний нөхцөл болон уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөлийг зөрчсөн, эсхүл хяналтаар дараах нөхцөл байдал илэрсэн нь гэрээг цуцлах, шилжүүлсэн өмчийг буцаан авах, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно:

49.4.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр зохион байгуулж, ялагчид хууль бус давуу байдал үүсгэсэн;

49.4.2.энэ хуулийн 54.5.2, 54.5.4-т заасан нөхцөл илэрсэн;

49.4.3.гэрээ байгуулсан этгээд хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;

49.4.4.худалдах доод үнээс бага үнээр худалдсан буюу худалдах, шилжүүлэхийг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулан авсан, өгсөн;

49.4.5.хөрөнгө шилжүүлэн авсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;

49.4.6.шилжүүлсэн хөрөнгийн үнийг төлөхөд хуулиар хориглосон эх үүсвэрийг ашигласан.

49.5.Энэ хуулийн 49.4-т заасан үндэслэлээр гэрээг цуцлах шийдвэрийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар гаргана.

49.6.Гэрээг цуцлах шийдвэрт тухайн хөрөнгийг хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаар заана.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **50 дугаар зүйл. Дуудлага худалдаа**

50.1. Дараах тохиолдолд дуудлага худалдааны аргыг хэрэглэнэ:

50.1.1. төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг энэ хуулийн 37.2.1, 37.2.2-т зааснаас бусад үндэслэлээр бусдад ашиглуулах бол;

50.1.2. энэ хуулийн 46.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулахаас бусад тохиолдолд өмчийг бусдад ашиглуулах, эсхүл шилжүүлэх бол;

50.1.3. дуудлага худалдааны аргыг хэрэглэхээр хуульд заасан бол.

50.2. Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын болон тухайн өмчийг эзэмшигч байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

50.3. Санал хүлээн авах хугацааг мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 14-өөс доошгүй хоног байхаар тогтоох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааны талаарх зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

50.4. Энэ хуулийн 50.2-т заасан мэдэгдэлд шилжүүлэх, ашиглуулах хөрөнгө, зориулалт, хөрөнгийн үнэ, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт, хөрөнгийг худалдах доод үнэ, эд хөрөнгө, ажил үйлчилгээний нөхцөл, онцлогтой холбогдох бусад болон гэрээний төслийн талаарх мэдээлэл, дуудлага худалдаа явуулах хугацаа, хураамж, дэнчин ба бусад нөхцөлийг тусгасан байна.

50.5. Дуудлага худалдааны талаар мэдэгдэх, сурталчлах ажлыг энэ хуулийн 50.2-т зааснаас гадна бусад нэмэлт арга хэрэгслээр нийтэд түгээж болно.

50.6. Дуудлага худалдааны тухай нийтэд мэдээлснээс хойш сонирхогч аливаа этгээд зохион байгуулагчийн тогтоосон газар, цагт ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийг үзэж, шалгаж болох ба гэрээний нөхцөл, саналтай танилцаж болно.

50.7. Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөд үзлэг, тооллого хийх бөгөөд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах, хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэл хамгаалалтыг хариуцах үүрэгтэй этгээдийг томилж, зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийхийг хориглоно.

50.8. Дуудлага худалдаа зохион байгуулах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

50.9. Дуудлага худалдаа зохион байгуулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

50.10. Дуудлага худалдааны тайланг Төрийн өмчийн хороонд хүргүүлж, баримтыг зохих журмын дагуу архивд шилжүүлнэ.

50.11. Дуудлага худалдааны дүнг Мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд оруулж, хөрөнгийн шилжилтийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

## **51 дүгээр зүйл. Дуудлага худалдааны доод үнэ**

51.1. Дуудлагаар худалдахаар шийдвэрлэсэн эд хөрөнгийн санал болгох доод үнийг тухайн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд нь тогтооно.

51.2. Дуудлага худалдааны доод үнийг тухайн хөрөнгийн зах зээлийн үнэлгээг харгалзан тогтоох бөгөөд Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авна.

51.3. Дуудлага худалдааг дахин зарлах тохиолдолд доод үнийг шинээр тогтоох бөгөөд хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг анхны дуудлага худалдааны доод үнийг 20 хүртэл хувиар багасган тогтоож болно.

51.4. Дуудлага худалдааны доод үнэ тогтоох журмыг Төрийн өмчийн хороо батална.

## **52 дугаар зүйл. Хураамж, дэнчин тогтоох**

52.1. Энэ хуулийн 51.1-д заасан этгээд хураамж болон дэнчингийн хэмжээг тогтооно.

52.2. Дуудлага худалдаанд оролцох хураамжийг тухайн хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн хоёр хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно. Хураамжийн хэмжээг тогтоохдоо дуудлага худалдаа зохион байгуулах зардал, хүлээгдэж байгаа оролцогчдын тоо зэргийг үндэслэнэ.

52.3. Дэнчинд төлөх мөнгөн дүнг тухайн хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн 20 хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно.

52.4. Дуудлага худалдаанд ялагч болсон этгээд гэрээг тогтоосон хугацаанд байгуулаагүй, байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй нөхцөлд дэнчингийн мөнгийг буцаан олгохгүй.

## **53 дугаар зүйл. Дуудлага худалдааг зохион байгуулах**

53.1. Дуудлага худалдааг танхим, эсхүл цахим хэлбэрээр нээлттэй, хаалттай зохион байгуулна.

53.2. Оролцогчид дуудлага худалдаанд биечлэн оролцох боломжтой нөхцөлд дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж болно.

53.3. Танхимаар зохион байгуулах дуудлага худалдаанд оролцогчид саналаа дуудлага худалдааны нөхцөлийн дагуу тогтоосон өдөр битүүмжилсэн дугтуйнд хийж ирүүлнэ.

53.4. Дуудлага худалдаанд оролцогчийн санал дуудлага худалдааны дүн гартал хүчинтэй гэж тооцогдох ба дуудлага худалдаанд ялагчийн үнийн саналыг гэрээ байгуулах хүртэл хүчинтэй гэж үзнэ.

53.5. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулах бол оролцогчид нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан дуудлага худалдаа зохион байгуулагчтай холбогдож, саналаа гаргана. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн санал бусад бүх оролцогчдод нэгэн зэрэг ил харагдах боломжтой байна.

#### **54 дүгээр зүйл. Дуудлага худалдааны үр дүнг батлах**

54.1. Танхимын аргаар зохион байгуулсан дуудлага худалдааны ялагч ба хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн үнийн санал, бүртгэлийн дугаарыг дуудлага худалдааны ялагч тодормогц оролцогчид болон олон нийтэд зарлан мэдэгдэнэ.

54.2. Цахим дуудлага худалдааны үр дүнг ялагч тодормогц бүх оролцогчид болон олон нийтэд нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан тэр даруй мэдэгдэнэ.

54.3. Дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааны үр дүнг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор дуудлага худалдааг хүчинтэй эсэхийг баталгаажуулна.

54.4. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулсан шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн нэрийг, ялсан үнийн санал болон хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн этгээдийн нэрийг үнийн саналын хамт тусгана.

54.5. Дараах тохиолдолд дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзаж, энэ тухай зарлана:

54.5.1. оролцогчид хөтлөгчийн зааварчилгааг дагаагүй, дуудлага худалдааны журам, дэг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

54.5.2. дуудлага худалдааны үеэр оролцогчид өөр хоорондоо хуйвалдсан, түүнтэй төсөөтэй үйлдэл гаргасан бөгөөд энэ нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн болох нь илэрсэн бол;

54.5.3. дуудлага худалдааг зохион байгуулах этгээд, эсхүл дуудлага худалдааны хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах журам, дэгийг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

54.5.4. дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаанд оролцох эрхгүй этгээд бол.

54.6. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах тухай шийдвэрт шалтгааныг тодорхой тусгана.



## **55 дугаар зүйл. Дуудлага худалдааг дахин зарлах**

55.1. Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин зарлана:

55.1.1. хоёроос доошгүй оролцогч бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн хоёроос доошгүй оролцогч дуудлага худалдаанд оролцоогүй бол;

55.1.2. хоёроос доошгүй санал ирээгүй, эсхүл шаардлага хангасан нэг ч санал ирээгүй бол;

55.1.3. энэ хуулийн 56.4-т заасан нөхцөл бий болсон;

55.1.4. дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах тухай шийдвэр гарсан бол.

## **56 дугаар зүйл. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах**

56.1. Энэ хуулийн 45.1-д заасан этгээд нь ялагчтай гэрээ байгуулах хугацааг дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулснаас хойш хоёр сараас илүүгүй байхаар тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацааг нэг удаа сунгаж болно.

56.2. Ялагч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй бол хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулж, гэрээ байгуулах саналыг гаргана.

56.3. Энэ хуулийн 56.2-т заасны дагуу хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулсан бол гэрээг нэг сарын дотор байгуулна.

56.4. Хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан бол дуудлага худалдааг дахин зарлана.

56.5. Дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийг өмчлөх эрх нь худалдах, худалдан авах гэрээний зүйлийн үнийг бүрэн төлсний, хэрэв энэ нь үл хөдлөх эд хөрөнгө бол үнийг бүрэн төлж, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

## **АРАВДУГААР БҮЛЭГ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **57 дугаар зүйл. Уралдаант шалгаруулалт**

57.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэхэд тусгай болзол, шаардлагыг тогтоох бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

57.2. Уралдаант шалгаруулалтын зар мэдээллийг шалгаруулалт явуулахаас 60-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

57.3. Уралдаант шалгаруулалтын талаарх зар мэдээлэлд энэ хуулийн 50.4-т зааснаас гадна дараах зүйлийг заавал тусгана:

57.3.1. хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих нэмэлт болзол, шаардлага;

57.3.2. уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд;

57.3.3. шалгаруулалтад оролцогчдыг урьдчилан бүртгэх хугацаа;

57.3.4. уралдаант шалгаруулалтын төслийг ирүүлэх эцсийн хугацаа;

57.3.5. гэрээний ерөнхий нөхцөл;

57.3.6.дэнчин, хураамжийн хэмжээ.

57.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийг удирдах үйл ажиллагааг менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр уралдаант шалгаруулалт явуулж болно.

57.5.Энэ хуулийн 50.2, 50.4, 50.5, 50.6, 50.7, 50.8, 50.10, 50.11, 53.3, 53.5-д заасан журам нь уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахад нэгэн адил үйлчилнэ.

57.6.Уралдаант шалгаруулалтын доод үнэ болон хураамж, дэнчинг энэ хуулийн 51, 52 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

57.7.Уралдаант шалгаруулалтын журмыг Төрийн өмчийн хороо батална.

### **58 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөл**

58.1.Уралдаант шалгаруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхэд дараах нэмэлт нөхцөл тогтоож болно:

58.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зэрэг байдлаар хөрөнгө оруулалт хийх;

58.1.2.хөрөнгийг тусгай зориулалтаар ашиглах үүрэг хүлээлгэх;

58.1.3.ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;

58.1.4.шинэ ажлын байр бий болгох;

58.1.5.тогтоосон шаардлагад нийцсэн техникийн, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

58.1.6.байгаль орчныг хамгаалах шаардлагыг биелүүлэх;

58.1.7.орон нутгийн болон тухайн бүс нутгийн иргэдэд шаардлагатай нийтийн үйлчилгээг хүргэх;

58.1.8.хөрөнгийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээдээс тогтоосон бусад нэмэлт нөхцөл.

### **59 дүгээр зүйл.Уралдаант шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах**

59.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд ялагчтай гэрээ байгуулна.

59.2.Уралдаант шалгаруулалтын ялагчтай байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

59.2.1.үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулж, технологийг шинэчлэх замаар хуулийн этгээдийн үр ашгийг нь дээшлүүлэх;

59.2.2.хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өөрчлөн байгуулах;

59.2.3.менежментийн гэрээг хэрэгжүүлэгч этгээдээс үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашиг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, дүгнэж үнэлэх шалгуур үзүүлэлт, журам болон менежментийн гэрээ хэрэгжүүлэгч этгээдийн цалин хөлс, урамшуулалт;

59.2.4.гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс шилжүүлэн өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

59.2.5.гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, барьцаалах хөрөнгө.

59.3.Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАН**

### **60 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт**

60.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт нь өмчлөгчийн хяналт, төрийн хяналт болон хуулийн этгээдийн дотоодын хяналтаас тус тус бүрдэнэ.

60.2.Төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

60.3.Төрийн хяналтыг энэ хуульд заасан журмын дагуу Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

60.4.Төрийн аудитын байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналтыг хэрэгжүүлнэ.

### **61 дүгээр зүйл.Өмчлөгчийн хяналт**

61.1.Энэ хуулийн 60.2-т заасан этгээд нь өмчлөгчийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

61.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээтэй танилцах, үүрэг чиглэл өгөх;

61.1.2.төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх;

61.1.3.өмчийн чиглэлээр хэрэгжүүлсэн мэргэжлийн болон дотоод хяналт шалгалт, аудитын тайлан, зөрчил, дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнтэй танилцах, үүрэг чиглэл өгөх.

61.2.Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь шаардлагатай бол дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:

61.2.1.өмч, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдээс хөрөнгө олж авсан, хөрөнгийг ашиглах зөвшөөрөл өгсөн, өмчийг удирдсантай холбоотой баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, асуулга, асуулт тавих;

61.2.2.өмч, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн бүртгэлд оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах зорилгоор газар дээр нь үзлэг, шалгалт хийхийг даалгах;

61.2.3.хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөх.

61.3.Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн зохион байгуулалтад хяналт тавих, холбогдох тайлан, мэдээллээр хангах үүргийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хариуцна.

## **62 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналт**

62.1.Энэ хуулийн 60.3-т заасан этгээд нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдах болон өмчийн хадгалалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

62.1.1.өмчийн бүртгэл, тооллогыг хэрэгжүүлсэн байдал, түүний үр дүнг хянаж, дүгнэлт гаргах;

62.1.2.хуульд заасны дагуу гаргасан тайланг хянаж, дүгнэлт гаргах;

62.1.3.хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх.

62.2.Хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

62.3.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

62.4.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг энэ хуулийн 62.1-д заасан хяналтаар илэрсэн алдаа дутагдал, зөрчлийн шалтгааныг тогтоох, эсхүл өмчийг удирдах ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу явуулна.

62.5.Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газрын хяналтын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд<sup>9</sup> зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

62.5.1.хяналт шалгалтыг хууль, журамд заасны дагуу бүрэн гүйцэд хийх;

62.5.2.илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр хугацаатай үүрэг бүхий албан даалгавар өгөх;

62.5.3.буруутай этгээдэд хариуцлага тооцох, төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагыг солих асуудлаар холбогдох эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх;

62.5.4.шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

62.5.5.төрийн болон орон нутгийн өмчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар шүүхэд нэхэмжлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

62.5.6.шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд мэдэгдэх;

62.5.7.төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагад Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулах;

62.5.8.хуульд заасан бусад.

<sup>9</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны №2 дугаарт нийтлэгдсэн.

62.6.Хяналтын байцаагч нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ дараах ажиллагааг явуулж болно:

62.6.1.ажлын байранд ажлын цагаар нэвтрэн орох;

62.6.2.өмч, хөрөнгөнд үзлэг, шалгалт хийх;

62.6.3.холбогдох баримт бичгийг хянах үзэх, түүнийг хуулбарлан авах;

62.6.4.хяналт шалгалттай холбоотой асуулт тавьж, хариулт, тайлбар авах;

62.6.5.шалгалтад шаардлагатай мэдээ, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

62.6.6.хуульд заасан бусад.

62.7.Хяналтын байцаагч нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр болон төрийн албан хаагчийн хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд холбогдох асуудлыг шалгах аас татгалзах үүрэгтэй.

62.8.Хяналтын байцаагч нь энэ хуулийн дагуу хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлагын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг хариуцна.

62.9.Хяналтын байцаагч нь энэ хуулийн 62.5.2-т заасан албан даалгаврын биелэлтийг шалгах, 62.5.3-т заасан саналын шийдвэрлэлтийг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

62.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд санхүүгийн хяналт шалгалт хийх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, өмчийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулах журмыг Төрийн өмийн хороо тус тус батална.

62.11.Шаардлагатай бол төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан баримтын иж бүрэн шалгалтыг хийж болно.

### **63 дугаар зүйл.Дотоодын хяналт шалгалт**

63.1.Өмчийн дотоодын хяналтыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ зүйлд заасан журмаар өөрөө, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Төсвийн тухай хуулийн 11.1.11, 12.1.6-д заасны дагуу төсвийн аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

63.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 63.1-д заасан төсвийн аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.

63.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бүс Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллана.

63.4.Өмч хамгаалах байнгын зөвлөлийг тухайн байгууллагын даргын шийдвэрээр үндсэн үйл ажиллагаа эрхэлсэн удирдах албан тушаалтан ахалж, нягтлан бодогч, эд хариуцагч, мэргэжлийн /инженер, техникийн зэрэг/ ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулна.

63.5.Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн салбар, харьяа байгууллага, хуулийн этгээдийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд салбарын

хэмжээний төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт, үнэлгээг зохион байгуулж, хийсэн хяналт шалгалтын тайланг жил бүрийн эхний улиралд багтаан өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

63.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь дотоодын хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулж, хяналт шалгалтын тайланг баталгаажуулан тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор Мэдээллийн нэгдсэн санд оруулна.

63.7.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг Төрийн өмчийн хороо батална.

#### **64 дүгээр зүйл.Тайлан, мэдээ гаргах**

64.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, албан газар энэ хуульд заасан, төрийн болон орон нутгийн өмчит компани нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд заасан холбогдох мэдээ, тайланг батлагдсан маягт, зааврын дагуу тухай бүр, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу, хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнах үүрэгтэй.

64.2.Төрийн өмчийн хороо дараах нэгтгэсэн тайланг гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:

64.2.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн хөрөнгө, ер төлбөрийн нэгтгэсэн тайланг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт дараа жилийн эхний улиралд багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

64.2.2.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт.

64.3.Засгийн газар энэ хуулийн 64.2.2-т заасан нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

64.4.Орон нутгийн өмчийн газар нь аймаг, нийслэлийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дараа жилийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

64.5.Энэ хуулийн 64.3-т заасан тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн хороо, харьяа орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар байгууллагын цахим хуудсандаа тус тус байршуулна.

64.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан тайлан мэдээ, бүртгэл, тооллогын дүнгээс гадна энэ хууль болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн 54.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн<sup>10</sup> 8.6.2, 8.6.4, 8.6.8, 8.6.12-т заасан холбогдох мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд нээлттэй байршуулах үүрэгтэй.

64.7.Төрийн болон албаны нууцад хамаарах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалттай мэдээллийг энэ хуулийн 64.5-д заасан журмын дагуу цахим хуудсанд байршуулахгүй.

64.8.Өмчийн төлөв байдлын тайланд төрийн болон орон нутгийн өмч, түүний хөдөлгөөн, хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдал, төрийн болон орон нутгийн өмчит

---

<sup>10</sup> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны №06 дугаарт нийтлэгдсэн.

компанийн үр ашиг, менежментийн гүйцэтгэлийн талаарх нэгдсэн мэдээллийг тусгасан байна.

64.9.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Засгийн газар, орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Төрийн өмчийн хороо батална.

## **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН**

### **65 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан**

65.1.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх/-д төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үр ашиг, менежментийн гүйцэтгэл болон энэ хуулийн холбогдох бусад тайлан мэдээлэл, хяналт шалгалтын талаарх мэдээллийг төвлөрүүлнэ.

65.2.Мэдээллийн нэгдсэн сан нь улсын төрөлжсөн бүртгэлийн мэдээлэлд хамаарах бөгөөд баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ. Мэдээллийн сан нь төрийн онцгой объектын зэрэглэлтэй байна.

65.3.Мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг дараах төрлөөр ангилан тусгана:

65.3.1.төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийн бүртгэл, тооллогын дүн, хөдөлгөөн /олж авах, шилжүүлэх, данснаас хасах/, өмч, хөрөнгийг удирдах этгээдийн талаарх мэдээлэл;

65.3.2.төрийн болон орон нутгийн байгууллага, албан газрын санхүүгийн болон өмчийн тайлан;

65.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх шийдвэр, гэрээний бүртгэл;

65.3.4.төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, үйл ажиллагааны болон санхүү, өмчийн тайлан;

65.3.5.хөрөнгийн удирдлагын хяналт шалгалтын тайлан;

65.3.6.өмчийн төлөв байдлын жил бүрийн нэгдсэн тайлан.

65.4.Мэдээллийн нэгдсэн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан өөрт хамаарах мэдээллийг агуулсан байна.

65.5.Мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах асуудлыг Төрийн өмчийн хороо хариуцна.

65.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь холбогдох бүртгэл, мэдээллийг Мэдээллийн нэгдсэн санд тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв оруулах үүрэгтэй.

65.7.Энэ хуулийн 65.6-д заасан үүргийн хэрэгжилтэд Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

65.8.Төрийн болон албаны нууцад хамаарах болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалтай мэдээллээс бусад Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

65.9.Энэ хуулийн 65.8-д заасан ил тод, нээлттэй байх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8, 8.9, 8.10-т заасан журмаар олон нийтэд хүргэнэ.

65.10.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх журмыг Засгийн газар батална.

## **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **66 дугаар зүйл.Гомдол хянан шийдвэрлэх**

66.1.Иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглах болон бусдад ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 92, 93 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

66.2.Энэ хуулийн 66.1-д заасан гомдлыг хүлээн авсан захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хуулийн 94-99 дүгээр зүйлд заасан журмын дагуу гомдлыг шийдвэрлэнэ.

66.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 66.2-т заасны дагуу захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

### **67 дугаар зүйл.Шилжилтийн зохицуулалт**

67.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө албан газар, улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл энэ хуулийн 4.1.2-т заасан албан газар, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд заасан компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах эсэхийг Засгийн газар шийдвэрлэнэ.

67.2.Засгийн газар энэ хуулийн 67.1-д заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналд үндэслэн гаргана.

67.3.Өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах арга хэмжээг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд багтаан зохион байгуулна:

67.3.1.энэ хуулийн 67.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах;

67.3.2.энэ хуулийн 66 дугаар зүйлд заасан Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

67.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг шинэчлэх.

67.4.Энэ хуулийн 12.2.14, 13.5.7, 14.2.9, 15.2.6, 16.3.6-д заасан өмчийн төлөв байдлын тайлан гаргах, хэлэлцэх, эрх бүхий байгууллагад хүргүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



## **68 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

68.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

68.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль<sup>11</sup>, эсхүл Зөрчлийн тухай хуульд<sup>12</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **69 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

60.1.Энэ хуулийг 2022 оны ... дүгээр сарын сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----000----

---

<sup>11</sup> Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны №7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>12</sup> Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны №24 дугаарт нийтлэгдсэн.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн зүйлийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсэг:

“39.9.Боловсролд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулах, боловсролын байгууллагын ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг өөр зориулалтаар бусдад ашиглуулах, шилжүүлэхийг хориглоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1.1</sup> дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “тусгайлсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “тусгайлсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Геодези, зураг зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “тусгайлсан” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг:

“15.6. Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөнд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахтай холбогдох харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3.5-д заасан журмаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай

1/ 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ашгийн төлөө бус хуулийн этгээд, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “тусгайлсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалт:

“4.1.18. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасныг”.

**2 дугаар зүйл.** Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.2.2 дахь заалтын “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Кино урлагийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Журмын төсөлд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.” гэсэн өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Кино урлагийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Концессын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тус тус заасан төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчийг” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн нийтийн болон орон нутгийн нийтийн өмчийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/ 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалт:

“4.1.9. “орон нутгийн өмч” гэж орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10.3, 10.4-т заасан хөрөнгийг”.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид” гэснийг “албан газар, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн чиг үүргийг хууль, эсхүл гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа этгээдэд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт доор дурдсан агуулга бүхий 16.1.14, 16.1.15 дахь заалт тус тус нэмсүгэй:

1/ 16 дугаар зүйлийн 16.1.14, 16.1.15 дахь заалт:

“16.1.14.төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогын дүнгийн тухай Засгийн газрын тайланг тухай бүр;

16.1.15.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын талаарх Засгийн газрын тайланг жил бүр.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Төрийн байгууллагын” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагын” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ойн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг:

“22.5.Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран зохих шийдвэр гаргана.”

**2 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Журмын төсөлд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.” гэсэн өгүүлбэр, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа” тусгайлсан” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.6 дахь заалтын “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “тусгай сан,” гэснийг “тусгай сан зэрэг” гэж, 4.1.4 дэх заалтын “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “компани” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн” гэснийг “компанийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “төрийн” гэсний дараа “тусгайлсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ  
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчид” гэснийг “төр, орон нутаг болон хувийн өмчид” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэснийг “албан газар” гэж өөрчилж, 7.1.8 дахь заалтын “, албан газар” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэснийг “төрийн байгууллага” гэж, 3.1.2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “албан газар” гэж, 3.1.3 дахь заалтын “хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчит компани” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “төрийн өмчлөлд байна” гэснийг “төрийн тусгайлсан өмч байна” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд нийт 89 зүйл, 268 хэсэг, 270 заалттай болно. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 29 удаагийн нэмэлт, өөрчлөлт орж, нийт 219 зүйл, хэсэг, заалт өөрчлөгдсөн байна.<sup>1</sup> Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг Улсын дээд шүүхээс тайлбарласан байна.<sup>2</sup>

### **Нэг.Үнэлгээ хийх болсон шалтгаан**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дараах шалтгаанаар үнэлгээ хийлээ:

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тодорхойлох;

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон;

-төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн өмчийн газраас төрийн өмчийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох болон үйл ажиллагаанд нь учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор санал авсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн судалж үзэхэд, дараах асуудлыг хөндсөн байна.<sup>3</sup>

#### **1.Төрийн өмчит хуулийн этгээдийн хяналтын тогтолцоог сайжруулах:**

1.1.төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг Компанийн тухай хуультай нийцүүлэх, хяналтын тогтолцоотой болгох (ТУЗ);

1.2.бусад хуультай нийцүүлэх;

1.3.төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулалтаар томилдог болох.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статус, үйл ажиллагаатай холбоотой:

2.1.төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статусыг тодорхой болгох, бэхжүүлэх, төрийн өмчийн удирдлагыг тогтвортой, нэгдмэл, төвлөрсөн байлгах;

2.2.төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, хөрөнгийн харилцааг зохицуулж байгаа журам, дүрэм, эрх зүйн актыг шинэчлэх, боловсронгуй болгох.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх судалгаанаас дэлгэрүүлж үзнэ үү.

<sup>2</sup> Улсын дээд шүүхийн 1997 оны 146, 237 дугаар, 1999 оны 79 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1, 56 дугаар зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус тайлбарласан байна.

<sup>3</sup> Төрийн өмчит хуулийн этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад асуудлаар ирүүлсэн саналын тухай танилцуулга, материалаас дэлгэрүүлж үзнэ үү.



3.Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох:

3.1.төлөөлөл хэрэгжүүлэх журмыг тодорхой болгох.

Түүнчлэн орон нутгийн Өмчийн газраас ирүүлсэн саналыг судалж үзэхэд, дараах асуудлыг хамгийн ихээр хөндсөн байна:<sup>4</sup>

1.Орон нутгийн өмчийн газрын статусыг тодорхой болгох, өмчийн газрыг тогтвортой ажиллуулах;

2.Орон нутгийн өмчийн газрын ажилтан улсын байцаагчийн эрхтэй байх;

3.Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон өмчийн газрын хоорондын харилцааг тодорхой болгон зохицуулах;

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас орон нутгийн шууд удирдлагаар хангадаг болох.

Төрийн өмчит хуулийн этгээд болон орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналд үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдийн хяналтын тогтолцоо, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статус, үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн асуудал, орон нутгийн өмчийн газрын статус, үйл ажиллагаа болон төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтоохоор хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

### **Хоёр.Үнэлгээний хүрээ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хийх үнэлгээний хүрээг дээр дурдсан үнэлгээ хийх зорилго, шалтгаанд тулгуурлан агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх байдлыг харгалзан:

-Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл;

-Гуравдугаар бүлэг: Төрийн өмчийн удирдлага;

-Дөрөвдүгээр бүлэг:Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх;

-Тавдугаар бүлэг: Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам;

-Зургаадугаар бүлэг: Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах;

-Есдүгээр бүлэг: Орон нутгийн өмчийн зүйлс гэсэн 6 бүлэг, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтаар тодорхойллоо.

### **Гурав.Үнэлгээний шалгуур үзүүлэлт**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хийх үнэлгээг зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр хийхээр тогтов. Учир нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан зардлыг тооцоолох боломжгүй тул зардлын өсөлт, бууралт болон зардал-үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь үр дүнгүй юм. Түүнчлэн зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэж байгаа асуудал, бэрхшээлийг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг бүхэлд нь зорилгод хүрсэн түвшнээр, Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл, Зургаадугаар бүлэг: Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах гэсэн хэсгийг зорилгод хүрсэн түвшингээр, Гуравдугаар бүлэг: Төрийн өмчийн удирдлага, Дөрөвдүгээр бүлэг: Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, Тавдугаар бүлэг: Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам хэсгийг практикт нийцэж байгаа байдлаар, Есдүгээр бүлэг: Орон нутгийн өмчийн зүйлс хэсгийг хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр тус тус үнэлнэ.

---

<sup>4</sup> Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналын нэгтгэл материалаас дэлгэрүүлж үзнэ үү.

## Дөрөв. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Үнэлгээний хамрах хүрээг дээр дурдсан үнэлгээний шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш болон тохиолдол судлах гэсэн харьцуулах хэлбэрээр харьцуулж үзэхээр тогтов.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Нэгдүгээр бүлгийг зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр, хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гэсэн харьцуулах хэлбэрээр үнэлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Гуравдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг, Тавдугаар бүлэг, Зургаадугаар бүлгийг практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтээр, тохиолдол судлах гэсэн харьцуулах хэлбэр, Есдүгээр бүлгийг практикт нийцэж буй байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлт, тохиолдол судлах харьцуулах хэлбэрээр үнэлнэ.

## Тав. Үнэлгээний дүгнэлт

### 5.1. Хуулийн Нэгдүгээр бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 1 дүгээр хүснэгтэд харуулав.

1 дүгээр хүснэгт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
<b>Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл</b> Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. (§1)	Зорилгод хүрсэн түвшин  Үндсэн зорилго: Төрийн байгууллагын эрхийг тодорхойлох;  Дагалдах зорилго: Тухайн харилцааг зохицуулах  -Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, хүрсэн бол ямар үр дүн гарсан бэ?	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш <sup>5</sup> ямар нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бэ?	-төрийн болон орон нутгийн өмчийн эрхийг хуулиар тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? -төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? -төрийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээг тодорхойлж,

<sup>5</sup> Нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.

			холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? -төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх?
Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсын эрдэнэсийн сан, Ирээдүйн өв сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай болон Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпорацийн болон Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад үйлчлэхгүй. (§2.2)	Зорилгод хүрсэн түвшин  Хуулийн үйлчлэх хүрээ нь хуулийн зорилтод нийцэж байгаа байдал  Практикт нийцэж буй байдал  Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй этгээдийн зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш ямар нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бэ?  Тохиолдол судлах  Бусад улсад сан, даатгалын өмчийн харилцааг хэрхэн зохицуулдаг вэ?	Хуулийн үйлчлэлд хамаарахгүй этгээдийг нэр заасан нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх?  Үйлчлэх хүрээтэй холбоотой ямар асуудал практикт үүсэж байна вэ? Тэдгээрийн эерэг, сөрөг үр дагавар юу байна вэ?

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилтыг 1 дүгээр зүйлд тодорхойлсон бөгөөд хуулийн үндсэн зорилтыг төрийн байгууллагын эрхийг тодорхойлох, дагалдах зорилгыг эд хөрөнгийн харилцааг зохицуулах хэмээн томъёолсон гэж үзэж болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 25 жилийн хугацаанд 29 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.<sup>6</sup> 29 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөс 2 нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хамаарах өөрчлөлт, 3 нь холбогдох хуультай нийцүүлсэн өөрчлөлт, 4 нь тус хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй хуулийн этгээдийг нэмсэн өөрчлөлт бөгөөд 22 удаагийн нэмэлт, өөрчлөлт нь төрийн өмчийн харилцааны зохицуулалт байна.

Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй хуулийн этгээдийг тухай бүр нэмснээр төрийн өөрийн өмч, түүний хөрөнгийн харилцааны зохицуулалтын ач холбогдол буурсан. Төрийн хөрөнгө, төсвийн санхүүжилтийн эх үүсвэр бүхий төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, данснаас хасах харилцаа төрийн хяналтын гадна үлдэх боломжтой болсон.

Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпораци зэргээр хуулийн үйлчлэлд хамаарахгүй этгээдийг нэрлэн заасан нь төрийн

<sup>6</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт гэсэн материалаас дэлгэрүүлж үзнэ үү.

өмчийн бодлого, зохицуулалтын нэгдмэл, төвлөрсөн байх зарчмыг хөндөж байгаа бөгөөд хуулийн зорилттой нийцэхгүй байна.

Төрийн өмчийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаанд хамрагдсан ихэнх улс нь Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн тухай хуультай бөгөөд уг хуулиар нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчилдэг хуулийн этгээдийн харилцааг зохицуулдаг байна.

## 5.2.Хуулийн Гуравдугаар бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Гуравдугаар бүлэг: Төрийн өмчийн удирдлага хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 2 дугаар хүснэгтэд харуулав.

2 дугаар хүснэгт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
Гуравдугаар бүлэг.Төрийн өмчийн удирдлага Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх (§8.1.1)	Практикт нийцэж буй байдал <sup>7</sup>  УИХ бүх ард түмнийг төлөөлдгийн хувьд төрийн өмчийн өмчлөгч байх нь практикт хэрхэн нийцэж байна вэ?	Тохиолдол судлах  УИХ төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх шийдвэр гаргах нь өнөөдрийн нөхцөл байдалд нийцэж байгаа эсэх?	УИХ-ын статусыг Үндсэн хуульд хэрхэн тодорхойлсон бэ? Монгол Улсын төрийн байгууламжийн хэлбэр?
Улсын Их Хурал төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах эрхтэй. (§8.1.4)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг УИХ гаргах зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгждэг вэ?	Тохиолдол судлах  Төрийн өмчийг барьцаалах шаардлага гардаг уу?  УИХ-аар төрийн өмчийг барьцаалах шийдвэр гарч байсан эсэх?	Төрийн өмчит компани үйл ажиллагаагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагаас зээл авах шаардлага тулгардаг эсэх? Зээл авахад төрийн эрх бүхий байгууллагын барьцаалах шийдвэр шаарддаг эсэх? УИХ төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах нь зохистой эсэх?
Нийгэмчлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргах эрхтэй. (§8.2)	Практикт нийцэж буй байдал  Нийгэмчлэх нь өнөөгийн практикт нийцэж байна уу?	Тохиолдол судлах  Нийгэмчлэх шийдвэр гаргах хууль зүйн үндэслэл байгаа эсэх?	УИХ-аас нийгэмчлэх шийдвэр гаргасан эсэх?  Үндсэн хуулийн зохицуулалтад нийцэх эсэх?
Улсын Их Хурал хувьчилж үл болох эд хөрөнгийн	Практикт нийцэж буй байдал  УИХ хувьчилж үл болох эд хөрөнгийн	Тохиолдол судлах  Бусад улсад хувьчилж үл болох эд хөрөнгийн	Хувьчилж үл болох эд хөрөнгийг нэрлэн жагсааж байгаа нь зохистой эсэх?

<sup>7</sup> Тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

жагсаалт батлах эрхтэй. (§8.1.5)	жагсаалт батлах зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ?	жагсаалт гаргадаг эсэх?	Хувьчилж үл болох салбарыг тодорхойлох нь хувьчилж үл болох эд хөрөнгийг зааснаас үр дүнтэй эсэх?
Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрх (§9)	Практикт нийцэж буй байдал  Засгийн газар төрийн өмчийн талаарх эрхээ бүрэн хэрэгжүүлж байна уу?	Тохиолдол судлах  Засгийн газар хуулийн этгээд байгуулах, түүний дүрмийг батлах бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	Засгийн газар төрийн өмчийн талаарх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэж байгаа ямар асуудал байна вэ? Эерэг, сөрөг үр дагавар байгаа эсэх?
Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх (§11)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу?  Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл байгаа вэ?	Тохиолдол судлах  Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг бусад улсад хэрхэн тодорхойлсон байдаг вэ?	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статусыг тодорхой болгох шаардлага байна уу? Төрийн өмчит хуулийн этгээдийн өмчийн удирдлагыг ТӨБЗГ бүрэн хэрэгжүүлж байна уу? Холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эдлэх эрхэд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэх?
Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээ (§12)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын хуулиар тодорхойлсон эрх хэмжээ нь бодит байдалд нийцэж буй эсэх?	Тохиолдол судлах  Төрийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг бусад улс хэрхэн зохицуулсан байдаг вэ?	Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагаанаас тусгаарлах хууль зүйн үндэслэл хангалттай бий эсэх? Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанаас аж ахуйн үйл ажиллагааг салгаж чадсан эсэх?

Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон боловч өнөөдрийн нөхцөл байдалд хуулийн зохицуулалт тодорхой бус, хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх” гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”

гэж, Хоёрдугаар зүйлийн 1-д “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн зөвхөн төрийн өмчийн өмчлөгч байх нь Үндсэн хуульд заасан “төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн статустай бүрэн нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг төрийн эрх барих дээд байгууллага хэрэгжүүлэхгүй байгаа нь нэгдмэл төрийн байгууламжтай манай улсад тохирохгүй байна.

Төрийн өмчийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаанд хамрагдсан 26 нэгдмэл улсын хувьд Хятад, Швед, Норвеги, Итали, Финлянд гэсэн 5 улс төрийн өмчөөс гадна орон нутгийн өмчтэй гэсэн мэдээлэл олдсон бөгөөд үлдэх 21 улс нь орон нутгийн өмчтэй гэсэн мэдээлэл олдоогүй болно.

Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлдөг, төрийн эрх барих дээд байгууллага болохын хувьд, түүнчлэн Монгол Улс нь нэгдмэл улс тул төрийн өмчийн мөн орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Иймд Улсын Их Хурлыг төрийн өмчийн, мөн орон нутгийн өмчийн өмчлөгч мөн гэж үзэж түүний бүрэн эрхэд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тухайлбал, өмчлөгч нь Улсын Их Хурал болох тул төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг Улсын Их Хурал өөрөө гаргах нь учир дутагдалтай юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “Улсын Их Хурал төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах эрхтэй” гэж заасан. Барьцаалах шийдвэрийг өмчлөгч гаргах нь хууль ёсонд нийцнэ. Гэхдээ төрийн бүх өмчийг барьцаалах шийдвэрийг зөвхөн Улсын Их Хурал гаргахаар зохицуулсан нь аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд зарим нөхцөлд хүндрэл үүсэж байна. Улсын төсвөөс санхүүжилт авдаггүй, аж ахуйн үйл ажиллагааг бие даан эрхэлж орлого олж, зохих хууль тогтоомжийн дагуу улсад татвар, хураамж, төлбөрөө төлдөг аж ахуй эрхлэгч хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад санхүүгийн асуудлаа шийдвэрлэх зорилгоор зээл авах шаардлага үүсдэг.

Төрийн өмчит хуулийн этгээд нь зээл авахад хөрөнгөө барьцаалах шаардлага тулгардаг. Банк, санхүүгийн байгууллага нь төрийн эрх бүхий байгууллагын хөрөнгө барьцаалахыг зөвшөөрсөн шийдвэрийг зайлшгүй шаарддаг. Иймд төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг гаргах субъектыг барьцаалах хөрөнгө, барьцааны хугацаа, эргэн төлөгдөх нөхцөл, нийтийн ашиг сонирхол зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж тогтоох нь зүйтэй байна.

Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж байгаа энэ хугацаанд төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргаж байгаагүй бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын гаргасан тоо баримтаас үзэхэд төрийн өмчит хуулийн этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан бичгийг үндэслэн автомашин, машин механизм зэрэг үндсэн хөрөнгө болон конторын барилга, гарааш зэрэг үл хөдлөх хөрөнгөө барьцаалж богино хугацаатай буюу 36 хүртэл сарын хугацаатай зээл авч байжээ.

Төрийн эрх бүхий байгууллага төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг барьцаалах хөрөнгө, барьцааны хугацаа, зээлийн зориулалт зэргээс хамааран гаргах нь төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд үүссэн богино хугацааны санхүүгийн хүндрэлийг даван туулахад эерэг үр дүн авчирна гэж үзэж байна. Түүнчлэн зээл болон барьцааны гэрээнд тавих хяналт хариуцлагын асуудлыг анхаарах нь зүйтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т “Нийгэмчлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргах эрхтэй” гэж заасан. Нийгэмчлэх шийдвэр Улсын Их Хурлаас мөн гарч байгаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавдугаар зүйлийн 2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн

эрхийг хуулиар хамгаална” гэж, 3-т “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж тус тус заасан болно. Иймд хуульд заагаагүй үндэслэлээр нийтийн болон хувийн өмчийг нийгэмчлэх шийдвэр гаргах нь Үндсэн хуулийн өмчлөгчийн эрхийг хүлээн зөвшөөрөх зарчимтай нийцэхгүй байна.

Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрхийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд тодорхойлохдоо, уг зүйлийн 5-д “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэж заасан байна. Засгийн газраас төрийн өмчит хуулийн этгээд байгуулах шийдвэр гаргахдаа түүний дүрмийг батлахыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад болон төрийн захиргааны холбогдох байгууллагад үүрэг болгодог. Энэ нь Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-т заасан “компани үүсгэн байгуулах хурлаар компанийн дүрмийг хэлэлцэж шийдвэрлэнэ” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.1-д заасан “компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн” гэж заасныг, Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчиж байна. Хуульд тусгайлан заасан бүрэн эрхийг хуульд зааснаас бусад үндэслэлээр буюу Засгийн газрын тогтоолоор шилжүүлж байгаа нь Захиргааны ерөнхий хуультай нийцэхгүй байна.

Түүнчлэн нөгөө талаас төрийн захиргааны байгууллага хуульд заагаагүй бүрэн эрх хэрэгжүүлэх нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуульд үндэслэх ёсыг зөрчсөн асуудал болно. Иймд төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, түүний дүрмийг батлах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, өнөөгийн практикийг харгалзан дахин авч үзэх шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг хуульчилжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй асуудал үүсэж байна. Тухайлбал, төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий гэж заасан ч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байна гэж хуульд тодорхой заагаагүй.

Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (компани)-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж, газрын хуралдаан нь хувьцаа эзэмшигчдийн хурал, газрын хурлын шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр мөн гэж үзэхэд учир дутагдалтай байна. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигч байж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхийг тодорхой заах шаардлагатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар агентлагт олгосон бүрэн эрхийг Засгийн газраас томилогдсон дарга, орон тооны бус найман гишүүн оролцсон газрын хуралдаан хэрэгжүүлдэг. Орон тооны бус найман гишүүн нь төрийн захиргааны төв байгууллагын удирдах албан тушаалтан байдаг. Иймд хуралдаанаас гаргаж буй хамтын шийдвэрийг “газрын тогтоол” гэх нь учир дутагдалтай бөгөөд “хорооны тогтоол” гэх нь шийдвэрийн агуулгад нийцэх төдийгүй шийдвэрийн ач холбогдлыг нэмэгдүүлнэ.

Түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн өмчийн газраас төрийн өмчийн бодлого, зохицуулалт нэгдмэл, төвлөрсөн байх, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг “Хороо”-ны түвшинд ажиллуулах санал, хүсэлт цөөнгүй ирүүлдэг.

Төрийн өмчит хуулийн этгээд дэх төрийн өмчийн төлөөллийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. Түүнчлэн төрийн өмчийн төлөөлөл гэдэг нь төрийн захиргааны байгууллагаас аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцох хэлбэр бөгөөд төр тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зөвхөн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд томилсон төлөөлөгчөөр дамжуулан оролцоно гэсэн зарчмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд тодорхой тусгаж өгөөгүй болно. Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” батлагдсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан тоо баримт<sup>8</sup>-аас үзэхэд төрийн өмчит компани (хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани) 68, төрийн өмчийн оролцоотой компани 13, төрийн өмчит үйлдвэрийн газар 23, хувь нийлүүлсэн нийгэмлэг 1 байна. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 105 хуулийн этгээд байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх зүйн статус, төлөөлөл хэрэгжүүлэгч байгууллагын талаарх мэдээллийг 3 дугаар хүснэгтэд харуулав.

### 3 дугаар хүснэгт

Д/д	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэлбэр	Хуулийн этгээдийн тоо	Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэг байгууллага								
			ТӨБЗГ	ХХААХҮЯ	СаЯ	ЗТХЯ	ЭХЯ	УУХҮЯ	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал	ЗГХЭГ	“Эрдэнэс Монгол” ХХК
1	Төрийн өмчит компани	68	24	2	6	2	27	2	1	1	14
	а.Төрийн өмчит хувьцаат компани	47	22		2		23				
	б.Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	21	2	2	4	1	4	1		1	6
2	Төрийн өмчийн оролцоотой компани	13	3								
	а.Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани		3					1	1		2
	б.Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани										6
3	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо	81									
4	Төрийн өмчит үйлдвэрийн газар	23									
5	Хувь нийлүүлсэн нийгэмлэг	1				1					
6	Нийт тоо /3+4+5/	105	54	2	6	2	27	2	1	1	14

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 54, Сангийн яам 6, Зам, тээврийн хөгжлийн яам 2, Эрчим хүчний яам 27, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2, “Эрдэнэс Монгол” компани 14, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2, Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал 1, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 1 хуулийн этгээдэд тус тус төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байна. Энэ нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хэрэгжүүлэх төрийн өмчийн бодлого нэгдмэл бус байгааг харуулж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого төвлөрсөн байхад анхаарах шаардлагатай байна. “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.4-2.8 дахь заалтаар тухайн хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг тусгайлан, эсхүл эш татан заасан бөгөөд 2.10 дахь заалтаар бусад хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг төрийн

<sup>8</sup> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт материалаас дэлгэрүүлж үзнэ үү.



өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан. Энэ зохицуулалттай холбоотойгоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээд нь эд хөрөнгөтэй холбоотой харилцааг бие даан шийдвэрлэх, улмаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт “хамаарагдахгүй” мэт хандаж байна. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилох, чөлөөлөх субъектыг тус журмаар тодорхойлсныг төрийн өмчтэй холбоотой бүх харилцаанд хэмээн “хавтгайруулан” үзэх нь үндэслэлгүй байна. Иймд төрийн өмчтэй холбоотой хуулийн этгээдийн хөрөнгийн харилцаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авдаг байх, хянуулдаг байх, тайлангаа ирүүлдэг байх зэрэг зохицуулалтыг тусгах, боловсронгуй болгох шаардлага байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийн хэмжээг тогтоох, төвлөрүүлэх асуудлыг нэгдсэн байдлаар судалж үзэх нь зүйтэй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлохдоо “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасан байна. Харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргахаар заасан болно. Эдгээр зохицуулалтыг дахин нягталж, найруулах шаардлагатай байна. Учир нь Төсвийн тухай хуульд нийцүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоосон байхад Төлөөлөн удирдах зөвлөл хуваарилахгүй гэж шийдвэрлэх тохиолдол байна.

Түүнчлэн, Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох ашгийг төвлөрүүлэх, түүнд хяналт тавих үүргийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төлөөлөл хэрэгжүүлдэггүй хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх асуудлыг хууль зүйн үүднээс дахин авч үзэх нь зүйтэй байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага нь төрийн албан хаагчтай адил үйл ажиллагаандаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шилэн дансны хуулийг тус тус мөрдөж ажилладаг хариуцлагатай албан тушаал байдаг. Гэтэл уг албан тушаалыг хаших этгээдийг хэрхэн сонгон шалгаруулах асуудал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдаагүй болно. Иймд төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилдог байх асуудлыг судлан үзэх шаардлагатай байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, захиргааны албан тушаалын жагсаалтыг Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, зарим тохиолдолд тухайн үйлдвэрийн газрын захирал баталж байжээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэж, тус хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно” гэж тус тус заажээ. Гэтэл салбарын зарим хуульд тухайн хуулийн этгээдийн дүрмийг батлах, орон тоог тогтоох эрхийг төрийн захиргааны төв байгууллагад олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд нэрлэн заасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 8 бүрэн эрхийн хүрээнд төрийн өмчийн

эзэмшилт, ашиглалт, хамгаалах ажлыг эрхлэх чиг үүргийг бүрэн гүйцэтгэх боломжгүй болно. Тухайлбал, төрийн өмчит хуулийн этгээдийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах, батлуулах, төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт шалгалт хийх, хариуцлага тооцох, төрийн өмчит хуулийн этгээдэд зээл олгох шийдвэр гаргах, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлах зэрэг эрхгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас журам боловсруулан баталж, төрийн өмчит хуулийн этгээдэд мөрдүүлэх асуудлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2016 онд тус тус хандсан боловч тэдгээр байгууллагаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, үгүй нөхцөлд Захиргааны ерөнхий хуулийг дагаж мөрдөх тухай хариу ирүүлсэн болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуулиар төрийн өмчит хуулийн этгээдийн дээр дурдсан харилцаа нь бүрэн зохицуулагдахгүй байгаа тул захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах эрхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад олгох заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмж тусгах шаардлага байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталж мөрдүүлэх шаардлагатай зарим журмыг дурдвал, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн харилцааг зохицуулах журам, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журам, төрийн өмчит компанийн дүрмийн загвар, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам, төрийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, дуудлагаар худалдах, данснаас хасах журам, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам, төрийн өмчийн хөрөнгө түрээслэгчийг сонгон шалгаруулах журам, хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам, түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ тогтоох, түрээсийн гэрээний загвар батлах гэх мэт. Эдгээр харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх нэгдсэн бодлого, зохицуулалт үгүйлэгдэж байна. Иймд Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дээр дурдсан харилцааг зохицуулах журам баталж мөрдүүлэх эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт олгох шаардлагатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэн гүйцэтгэх чиг үүргийг өөр байгууллагад олгосон зохицуулалт зарим хуульд байна. Тухайлбал, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлд “батлан хамгаалахын төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, шилжүүлэх, шинээр авах асуудлыг шийдвэрлэх, захиалгыг хянаж батлах”-ыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамааруулжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тодорхойлсон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх “төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах”-тай зөрчилдөж байна.

Дээр дурдсанаас үзэхэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх зүйн статус, эрх, үүргийг тодорхой болгох нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чухал нөлөө үзүүлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээг “эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж, холбогдох газарт оруулна” гэж заажээ. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг тодорхой бус байгаагаас нэг тайланг 2-3 байгууллагад хүргүүлэх, хяналт шалгалт давхардах, тухайн асуудлыг хэд хэдэн байгууллагад танилцуулж батлуулах зэрэг төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаа талаар

төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс санал, хүсэлт олноор тавьсан. (Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг танилцуулга материалаас дэлгэрүүлж үзнэ үү.)

Төрийн захиргааны төв байгууллагаас хууль тогтоомжоор тусгайлан олгоогүй чиг үүргийг хэрэгжүүлж төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмших, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөгчийг томилох, удирдамж өгч байгаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байгаа тул төрийн захиргааны төв байгууллагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг аж ахуйн чиг үүргээс бүрэн салгаж тусгаарласан зохицуулалт дутагдаж байна.

Иймд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны бусад байгууллагын эрх, үүргийг оновчтой тогтоох, чиг үүргийн давхардал үүсгэхгүй байх асуудлыг судлан үзэж, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

### 5.3.Хуулийн Дөрөвдүгээр бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Дөрөвдүгээр бүлэг: Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 4 дүгээр хүснэгтэд харуулав.

4 дүгээр хүснэгт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
Дөрөвдүгээр бүлэг.Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх Төрийн өмчит хуулийн этгээд (§13)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчит хуулийн этгээдийн талаарх ойлголт практикт нийцэж байгаа эсэх?	Тохиолдол судлах  Төрийн өмчит хуулийн этгээдийг бусад улсад хэрхэн тодорхойлсон бэ?	Төрийн 100 хувийн өмчит хувьцаат компани төрийн өмчит хуулийн этгээд мөн эсэх? Хэрвээ мөн бол төрийн өмчит хуулийн этгээдийн ямар ангилалд багтах вэ? Төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал нь төрийн өмчит хуулийн этгээдийг бүрэн хамарч чадаж байгаа эсэх?
Төрийн өмчит үйлдвэрийн газар (§15)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн этгээдийн ямар хэлбэрт хамаарах вэ? Төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн этгээдийн хувьд	Тохиолдол судлах  Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэр гаргалтыг компанийн удирдлагын шийдвэр гаргалттай харьцуулах?  Улсын төсөвт үйлдвэрийн газар бий эсэх?	Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийн харилцааг ямар хууль тогтоомжоор зохицуулдаг вэ?

	холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх?		
Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргаа (§18, §19, §20)	Практикт нийцэж буй байдал  Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын эдлэх эрх бодит байдалтай хэр тохирч байна вэ?	Тохиолдол судлах  Үйлдвэрийн газрын удирдлагын асуудлыг бусад улс хэрхэн зохицуулсан байдаг вэ?	Үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээний асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь үр дүнтэй вэ?
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог (§21)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн эд хөрөнгийн харилцааг уг хуулиар бүрэн зохицуулж чадсан эсэх?	Тохиолдол судлах  Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн харилцааг бусад улсад хэрхэн зохицуулж байна вэ?	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн эд хөрөнгийн харилцааг уг хуулиар бүрэн зохицуулж чадсан эсэх?

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ хэмээн тодорхойлж, төрийн өмчит хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гэж 3 ангилсан байна. Энэ ангилал нь төрийн өмчид үндэслэн байгуулагдсан болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг бүрэн хамарч чадаагүй байна.

Тухайлбал, уг хуулийн дөрөвдүгээр бүлгийн 21 дүгээр зүйлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогийг зохицуулсан боловч төрийн өмчит хуулийн этгээд нь дээр дурдсан 3 ангиллын алинд ч хамаарахгүй байна.

Түүнчлэн төрийн өмчит хуулийн этгээдийн дээр дурдсан ангиллын шалгуур үзүүлэлт тодорхой бус байна. Учир нь төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, чиг үүргээс хамааран төрийн байгууллага, албан газар болон төрийн өмчит үйлдвэрийн газар хэмээн ангилж гэж үзэж болохоор байна. Гэтэл уг зүйлд “төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг” гэж 2016 онд нэмснээр төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллын шалгуур үзүүлэлт тодорхойгүй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орно” гэж заасан бөгөөд уг хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ” гэж заажээ. Эндээс үйлдвэрийн газар гэдэг нь ямар хуулийн этгээд болохыг заагаагүй, түүнчлэн төрийн байгууллага, албан газрыг төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад гэж “бүрхэг” байдлаар тодорхойлсон, албан газар нь төрийн байгууллагаас ямар ялгаатай болох нь харагдахгүй байна. Улсын Их Хурлаас сүүлийн үед шинээр батлагдан гарч байгаа хууль тогтоомжид “Албан газар” гэсэн нэр томъёо тусгагдахаа больсон бөгөөд практикт хэрэглэгдэх нь цөөн болсон. Төрийн

байгууллагыг “улсын төсвөөс санхүүждэг” гэж тодорхойлсон нь төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийг бүрэн илэрхийлсэн тодорхойлолт болж чадаагүй юм.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна” гэж заасан байна. Гэтэл төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн хуулийн этгээдийн хэлбэр нь Иргэний хуультай зөрчилдөж байгааг өөрчилж Иргэний хуультай нийцүүлэх хэрэгтэй байна. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилдаг. Аж ахуйн тооцоотой буюу өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог үйлдвэрийн газар нь Иргэний хуульд заасан хэлбэрээр зохион байгуулагдах боломжтой байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газарт хяналтын тогтолцоо байхгүй тул захирал нь эрх бүхий байгууллагаас батлагдсан дүрмийн хүрээнд аливаа шийдвэрээ бие даан гаргадаг. Энэ нь төрийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих хяналтыг сулруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэж байна. Компанийн захирлын шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл хянаж ажилладаг байхад үйлдвэрийн газрын захирлын шийдвэрт тавих хяналтын механизм хангалтгүй байна.

Зарим улсад төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар, Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн тухай хуулиар, Тусгай хуулиар тус тус зохицуулж байна. Судалгаанд хамрагдсан 22 улсын 20 улс нь төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиас гадна тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

Судалгаанд хамрагдсан зарим улсад “төрийн өмчит аж ахуйн нэгж” гэсэн ойлголт хэрэглэгдэх хандлага түгээмэл байна. Төрийн өмчит аж ахуйн нэгж гэдэг нь өмчлөгч-төрийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд бөгөөд хууль зүйн статус нь төр энгийн хувьцаа эзэмшигчээр оролцдог компанийн хэлбэртэй байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжийг түүнчлэн төрийн өмчит компани, төрийн өмчит хуулийн этгээд, төрийн аж ахуйн нэгж, олон нийтийн өмчит корпораци, Засгийн газрын өмчит корпораци, Засгийн газрын аж ахуйн агентлаг гэх зэргээр улс бүрд харилцан адилгүй нэрээр нэрлэдэг байна. Бусад улсад төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар, Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн тухай хуулиар, Тусгай хуулиар тус тус зохицуулж байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хэрэглэгдэж байгаа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компани зэрэг нэр томъёог сүүлд батлагдаж байгаа хуулийн нэршил, Компанийн тухай хуульд хэрэглэгдэж байгаа нэр томъёотой уялдуулах, хуулийн этгээдийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлгүй хуулийн этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй болгох гэсэн санал олноор ирсэн байна.<sup>9</sup>

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяанд 2020 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит компани 68, төрийн өмчийн оролцоотой компани 13, төрийн өмчит үйлдвэрийн газар 23, хувь нийлүүлсэн нийгэмлэг 1 байна<sup>10</sup>. Түүнчлэн зарим төрийн захиргааны төв болон бусад байгууллагын харьяанд төрийн өмчит үйлдвэрийн газрууд ажиллаж байна.

<sup>9</sup> Төрийн өмчит хуулийн этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад асуудлаар ирүүлсэн саналын тухай танилцуулгаас дэлгэрүүлж үзнэ үү.

<sup>10</sup> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсээс гаргасан жагсаалтад үндэслэв.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газар ямар асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай, ямар асуудлаар Сангийн яамтай, ямар асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хэрхэн харилцахыг тодорхой болгох шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт бүрхэг, давхардал их, хуулийн этгээдэд хүндрэл үүсгэх заалт байгааг өөрчлөх нь зүйтэй байна.

#### 5.4.Хуулийн Тавдугаар бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Тавдугаар бүлэг: Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 5 дугаар хүснэгтэд харуулав.

5 дугаар хүснэгт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
Тавдугаар бүлэг.Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам (§24-§31)	Практикт нийцэж буй байдал  Төрийн өмчийн хөрөнгийн зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?	Тохиолдол судлах  Бусад улсад төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөрөнгийн зохицуулалтыг хэрхэн хийдэг вэ?	Төрийн өмчийн хөрөнгийн зохицуулалт нь үр дүнтэй байгаа эсэх?

Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр худалддаг, үнэ төлбөргүй шилжүүлдэг бол төрийн өмчийн хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр худалдаж, шилжүүлж, акталж данснаас хасдаг. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 2017 оны тоон үзүүлэлтээс харахад нийт тогтоолын 57 хувийг элэгдлийн хугацаа дууссан хөдлөх хөрөнгийг акталж данснаас хасах, шилжүүлэх, худалдах зэрэг хөрөнгийн хөдөлгөөний зохицуулалтын шийдвэр эзэлж байна.

Франц, Финлянд, Солонгос зэрэг улсад төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зохицуулалтыг хийдэг бөгөөд төрийн байгууллага нь хөдлөх хөрөнгийн зохицуулалтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандартаа баримтлан хийж, тайлан мэдээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлдэг байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл төрийн байгууллага бүрд байх, төрийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд тусгагдаагүй. Төрийн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тодорхой зохицуулж өгөх нь төрийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалтад тавих байгууллагын хяналтыг сайжруулах үр дүнтэй юм.

#### 5.5.Хуулийн Зургаадугаар бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Зургаадугаар бүлэг: Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 6 дугаар хүснэгтэд харуулав.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
Зургаадугаар бүлэг. Төрийн өмчийн хөрөнгийг хувьчлах (§32- §65)	Зорилгод хүрсэн түвшин	Тохиолдол судлах  Хувьчлалын асуудлыг бусад улсад хэрхэн зохицуулсан байдаг вэ?	Монгол Улсад өмч хувьчлал хангалттай хийгдсэн эсэх?
	Төрийн өмчийг хувьчилснаар хувийн хэвшлийг дэмжих, хөрөнгө оруулалт татах зорилго хангагдсан эсэх?		
	Практикт нийцэж буй байдал		
	Хуульд заасан хувьчлалын зохицуулалт нь хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай зохицуулалт мөн эсэх?		

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 32-65 дугаар зүйлээр төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах арга, хувьчлалын хөтөлбөр, хувьчлалд бэлтгэх, мэдээлэл хүргэх, хувьчлах эд хөрөнгийг үнэлэх, өмч хувьчлан авах этгээдтэй байгуулах гэрээ, хувьчлалын тайлан, орлого болон хувьчлах арга тус бүрийн талаар дэлгэрэнгүй заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс 2000 он хүртэл хугацаанд аж ахуйн нэгжийг дуудлагын худалдааны аргаар, 2001-2004 оны хооронд үнэ цэнэ бүхий аж ахуйн нэгжийг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилж байжээ. 2005 оноос хойших хугацаанд өмч хувьчлалыг дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын аргаас гадна төрийн өмчит хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих, нэмэлт хувьцаа гарган нийтэд санал болгох, концессын гэрээ байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бусад хэлбэрийг ашиглан хувийн хөрөнгө оруулалтыг татах зэрэг арга хэлбэрээс сонгон хэрэгжүүлж иржээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баримт мэдээллээс өмч хувьчлалаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг 7 дугаар хүснэгтэд харуулъя.

Д/д	Өмч хувьчлах хөтөлбөр болон үндсэн чиглэл	Хувьчилсан аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн тоо	Хувьчлалын орлого (тэрбум)
1	Төрийн өмчийг 1991-1995 онд хийсэн хувьчлал	835	17.5
2	Төрийн өмчийг 1996-2000 онд хувьчлах хөтөлбөр	922	47.4
3	Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл	83	62.6
4	Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл	34	63.1
5	Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл	30	13.3

6	Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл	Үндсэн чиглэл батлагдаагүй.	
7	Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл	25	26.0
	Нийт дүн	1929	229.9

Улсын хэмжээнд 1991-2016 онд нийт 1929 аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийг хувьчилж 229.9 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Дээр дурдсан тоо баримтаас харахад өмч хувьчлалын зохицуулалт нь эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлийг дэмжих гэсэн тухайн үеийн үндсэн зорилгодоо хүрсэн гэж үнэлж болохоор байна.

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль 2010 онд батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр хөрөнгийн үнэлгээг тусгай зөвшөөрөл эзэмшигч үнэлгээчин хийх болсон. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороогүй тул зарим заалт нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуультай зөрчилдөх болсон. Тухайлбал, уг хуулийн 37 дугаар зүйлээр хувьчлах эд хөрөнгийг үнэлэх харилцааг зохицуулсан бөгөөд хувьчлах доод үнэ тогтоох журмыг Засгийн газар батална гэж заажээ. Улмаар Засгийн газрын 2001 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Худалдах доод үнэ тогтоох журам” хүчин төгөлдөр үйлчилж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 50 дугаар зүйлээр шинжээч, түүний, эрх үүргийг зохицуулсан бөгөөд худалдах доод үнэ тогтоох болон шинжээчийн зохицуулалт нь бодит байдалтай нийцэхгүй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан хувьчлалын тайлан гэсэн зохицуулалт нь өнөөгийн бодит байдалтай нийцэхгүй байна. Хувьчлалын тайлан бичих загварыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, хувьчлалын тайланг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэжээ. Хувьчлалын тайлан болон бусад зохицуулалтыг бодит байдалтай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Олон улсад хувьчлалыг хөрөнгө оруулалт татах, засаглалын үр нөлөөг нэмэгдүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор хийдэг бөгөөд хувьчлалын загварыг менежмент, хэрэгжүүлэх байдлаар нь төвлөрсөн, төвлөрсөн бус, холимог загвар хэмээн 3 ангилж үздэг. Монгол Улс нь хувьчлалыг төвлөрсөн загвараар зохион байгуулдаг улсын нэг юм.

Хувьчлалыг зохион байгуулах арга хэлбэр олон янз байж болох бөгөөд олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улсуудад хувьчлалын дараах 4 арга хэлбэр түгээмэл ашиглагддаг байна.

- хөрөнгийн биржээр дамжуулан хувьцааг нь олон нийтэд санал болгох,
- худалдааны арга,
- ажилтанд нь худалдах,
- холимог арга.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36, 39, 47 дугаар зүйлийн зарим заалтын агуулга давхардсан байна. Тухайлбал, хувьчлалын арга тус бүрд урилгыг зарлан мэдээлэх, зард тусгах мэдээ зэрэг зохицуулалтыг нэгтгэн тусгах боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын тогтоолоор батлагддаг “Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Засгийн газрын тогтоолоор батлагддаг “Төрийн өмчийг хувьчлах жагсаалт”-д үйл ажиллагааны үндсэн чиглэлийг өөрчлөхгүй байх нөхцөлтэйгөөр хувьчлах гэсэн нөхцөл шаардлага тавьдаг. Энэ нь Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт заасан “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг



зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэж заасантай нийцэхгүй байна. Төр хувьчлалын дараах хяналт хэрэгжүүлэх алтан хувьцаа, тодорхой хэмжээний хувьцаа эзэмших, хяналтын эрхээ хадгалах гэсэн үндсэн 3 арга байдаг. Иймд хувьчлалын дараах төрийн хяналтыг Иргэний хуульд заасан өмчлөгчийн эрхэд нийцсэн бөгөөд олон улсад түгээмэл нэвтэрсэн арга хэрэгслээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### 5.6.Хуулийн Есдүгээр бүлгийн үнэлгээний дүгнэлт

Хуулийн Есдүгээр бүлэг: Орон нутгийн өмч хэсэгт хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг 8 дугаар хүснэгтэд харуулав.

8 дугаар хүснэгт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
Есдүгээр бүлэг.Орон нутгийн өмчийн зүйлс (§74-§81)	Практикт нийцэж буй байдал  Орон нутгийн өмчийн зохицуулалт практикт хэр нийцэж байна вэ?  Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Тохиолдол судлах Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа орон нутгийнханд хүлээн зөвшөөрөгдсөн үү?	Орон нутгийн өмчийн газрын эрхлэх үйл ажиллагаа тодорхой байгаа эсэх?

Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолын 4 дэх заалтаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагаатай албатай) хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосон байдаг. Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог ихэвчлэн тухайн орон нутгийн Засаг дарга баталдаг байна.<sup>11</sup> Орон нутгийн өмчийн газар нь 6-14 орон тоотой бөгөөд Говьсүмбэр, Дундговь, Увс аймгийн орон нутгийн өмчийн газар 6, Орхон, Төв аймгийн орон нутгийн өмчийн газар 14, Нийслэлийн өмчийн удирдлага, ашиглалтын газар 65 орон тоотой байна.

Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналын дийлэнх хэсгийг орон нутгийн өмчийн газрын статусыг тодорхой болгох, орон нутгийн өмчийн газрыг тогтвортой ажиллуулах, өмчийн газрын ажилтан улсын байцаагчийн эрхтэй байх, түрээсийн болон дуудлага худалдаа, хөрөнгийн хөдөлгөөнийг зохицуулах журам гарган мөрдүүлэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газрын хоорондын харилцааг тодорхой болгох, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Орон нутгийн өмчийн газрыг шууд удирдлагаар хангадаг болох зэрэг санал ирүүлсэн байна.<sup>12</sup>

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсээс гаргасан орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтээс харахад орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 18 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3 хувьцаат компани, 1 нөхөрлөл, 138 үйлдвэрийн газар, нийт 160 хуулийн этгээд орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

<sup>11</sup> Ховд аймгийн өмчийн газрын бүтэц, орон тоог аймгийн ИТХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор баталсан.

<sup>12</sup> Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналын нэгтгэл материалаас дэлгэрүүлж үзнэ үү.

Үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж үзвэл цэвэр, бохир ус, ус хангамж ариутгах татуурга, дулаан хангамж-58, эм, эмнэлгийн үйлчилгээ-26, гэрэлтүүлэг, хог хаягдал, ногоон байгууламж, хот тохижилт-21, амралт, сувилал, нийтийн хоолны үйлчилгээ-11, төрийн үйлчилгээ-11, худалдаа, үйлчилгээ-10, ойн аж ахуй-7, цахилгаан, эрчим хүчний үйлдвэрлэл-5, бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 11 хуулийн этгээд байна.

2016 оны тайлангаар нэгтгэлд хамрагдсан 160 хуулийн этгээдэд 5606 ажилтан, албан хаагч ажиллаж 105.6 тэрбум төгрөгийн орлого олж, 111.9 тэрбум төгрөгийн зардал гарган, 7.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Судалгаанд хамрагдсан 160 хуулийн этгээдээс 94 хуулийн этгээд буюу 60 хувь нь 2016 онд алдагдалтай ажилласан байна.

Тайлангийн нэгтгэлээс үзэхэд, Архангай аймагт 1 орон нутгийн өмчит хуулийн этгээд<sup>13</sup> байгаа бол Хөвсгөл аймагт 37 хуулийн этгээд<sup>14</sup> байгаа нь орон нутагт өмчийн талаарх бодлого харилцан адилгүй байгааг харуулж байна. Орон нутаг дахь хуулийн этгээдийн тоог 1 дүгээр графикт үзүүлэе.

1 дүгээр график



Өмнөговь аймгийн 51 хувийн өмчийн оролцоотой “Таван толгой” ХХК-ийн санхүүгийн тоон үзүүлэлтүүд нэгдсэн дүнд тусгаагүй бөгөөд уг компани нь 2016 онд 177 ажилтантай үйл ажиллагаа явуулж, 181.3 тэрбум төгрөгийн орлого олж, 111.2 тэрбум төгрөгийн зардал гарган 54.04 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Улсын Их Хурал, Засаг дарга нь Засгийн газрын, Орон нутгийн өмчийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчит хуулийн этгээдтэй адил эрх эдлэхээр, орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмаар зохицуулахаар заасан нь тодорхой бус байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх эрхийн хүрээнд батлан гаргаж байгаа зарим журмыг орон нутгийн өмчийн газар үйл ажиллагаандаа мөрдөхийг орон нутгийн удирдлагуудад зөвлөдөг. Түүнчлэн орон нутгаас ирүүлсэн хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хэлэлцэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол гаргадаг болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь орон нутгийн өмчийн газартай дээр дурдсан 2 байдлаас өөрөөр шийдвэр гаргадаггүй болно.

<sup>13</sup> Архангай аймгийн өмчийн газар 9 орон тоотой.

<sup>14</sup> Хөвсгөл аймгийн өмчийн газар 10 орон тоотой.

Түүнчлэн Монгол Улсад нийслэл, 21 аймаг нь орон нутгийн өмчийн талаар харилцан адилгүй шийдвэр гаргаж байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хийсэн шалгалтын тайлангаас харагдаж байна. Иймд орон нутгийн өмчийн асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд боловсронгуй болгон зохицуулах шаардлагатай байна.

### **Зургаа. Үнэлгээний зөвлөмж**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл, Гуравдугаар бүлэг: Төрийн өмчийн удирдлага, Дөрөвдүгээр бүлэг: Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, Тавдугаар бүлэг: Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам, Зургаадугаар бүлэг: Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах, Есдүгээр бүлэг: Орон нутгийн өмчийн зүйлс гэсэн 6 бүлэг, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж үзэхэд хуулийн зохицуулалт нь бодит байдалтай нийцээгүй, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон, бусад хуультай болон зарим зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилтэй байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 1997 оноос 2020 оны хооронд 29 удаа "бодлогын" чанартай биш "бүтцийн өөрчлөлт"-ийн чанартай нэмэлт, өөрчлөлт орсноос хуулийн зүйл, хэсэг, заалтыг хэрэглэхэд ойлгомжгүй байдал үүсэж улмаар хуулийн зохицуулалтын ач холбогдол буурсан байна.

Мөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл нэлээд үүссэн нь үнэлгээний дүгнэлтээр тодорхой байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зайлшгүй шинэчлэн найруулах, мөн холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

### **АЖЛЫН ХЭСЭГ**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**  
**Cabinet Secretariat of Government of Mongolia**

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ**

*/Үнэлгээний тайлан/*

**Улаанбаатар хот  
2022 он**

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээ нь Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн<sup>1</sup> зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>2</sup> 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилготой.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 1996 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээг үндэслэн бүхэлд нь сайжруулах зорилгоор хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<sup>3</sup> хэлбэрээр боловсруулагдсан байна.

Мөн тус хуулийн төсөлтэй холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай зэрэг 17 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг<sup>4</sup> боловсруулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>5</sup> /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараахь үе шатаар хийж гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д<sup>6</sup> заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

<sup>1</sup> Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 9 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төсөл. <https://cabinet.gov.mn>

<sup>2</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Сүүлийн нэвтрэлт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

<sup>3</sup> “25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон” Хууль тогтоомжийн тухай хууль.

<sup>4</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүд.2022 он. <https://cabinet.gov.mn>

<sup>5</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Сүүлийн нэвтрэлт 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдөр

<sup>6</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9-т “...хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

## **Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:**

### **➤ Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь хуулийн төслийн шинэчлэлээр тухайн зохицуулалтын хүрээнд тулгамдсан бэрхшээл, зөрчил, хийдлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь анх дэвшүүлсэн зорилго буюу хуулийн төслийн үзэл баримтлалд<sup>7</sup> тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн түүнийг шийдвэрлэж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

### **➤ Практикт хэрэгжих боломж:**

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан төрийн болон орон нутгийн өмчийг удирдах бүтэц, зохион байгуулалт, тэдгээрийн чиг үүргийг оновчтой тогтоож, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалган тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон.

### **➤ Ойлгомжтой байдал:**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Иймд энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд<sup>8</sup> заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

### **➤ Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчил, хийдэлгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг<sup>9</sup> хангасан эсэхийг шалгах зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 онд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойших 26 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс гадна холбогдох бусад хуулийн шинэчлэл хамаарч байна.

<sup>7</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлал. 2022 он. <https://cabinet.gov.mn>

<sup>8</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

<sup>9</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

Тухайлбал, 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2006 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай, Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулиуд байна.<sup>10</sup>

Өнөөдрийн байдлаар тус хуульд нийт 30 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн бүтцийн үндсэн хэлбэр болох зүйлийн зохицуулалтын 74.6%-д нь нэмэлт, өөрчлөлт орсон байна.<sup>11</sup> Эдгээр өөрчлөлтийн дийлэнх нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд биш харин салбарын бусад хууль шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Үүнээс дүгнэхэд хуулийн зохицуулалтын дийлэнх хэсэгт нэгдсэн бодлого, зарчмаар биш салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<sup>12</sup>

Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ашигт ажиллагаа алдагдсан, хөрөнгийн өгөөжгүй байдал нь төр эдийн засгийг зохицуулах чиг үүргийг гүйцэтгэхээс гадна хувьцаа эзэмшигчийн хувьд бизнесийн харилцаанд хэрхэн оролцох зохист харилцааг бий болгох шаардлагыг хөндөж байна.

Өөрөөр хэлбэл, төр ямар салбарт компани байгуулж болох, эсхүл хувьцааг олж авах, захиран зарцуулах боломжтой, мөн хувьцаанд ногдох эрхийг хэрхэн хэрэгжүүлэх механизмыг хуулийн хүрээнд тодорхой зохицуулалт шаардлагатай байна.

Иймд төрийн “эдийн засгийг зохицуулагч”-ийн чиг үүргийг хувьцаа эзэмшигчийн чиг үүргээс нь салангид хэлбэрээр зохицуулахаас гадна төр нь хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч болохын хувьд зах зээлийн харилцаанд оролцохдоо Компанийн тухай хуульд заасан бусад хувьцаа эзэмшигчдээс ялгаатай, давуу эрх эдлэхгүй байх хууль зүйн нөхцөлийг бүрдүүлэх, нөгөө талаас төр хувьцаа эзэмшигчийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд ил тод, хяналттай байдлыг хангах тусгай үүргийг хуульчлан тогтоох зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулийг<sup>13</sup> батлан мөрдүүлэх шаардлага тулгарсан.

Ийнхүү дээр дурдсан нөхцөл байдал болон нийгмийн харилцааны өөрчлөлт, Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн шинэчлэлд нийцүүлэх, холбогдох бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжтой уялдуулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтаас үзэхэд хуулийн зорилт, харилцааны хүрээ, нийтлэг зарчим, эрх бүхий байгууллагын эрх хэмжээ, өмчийг удирдах үйл ажиллагааны журмыг тодорхойлохдоо зохицуулалтыг сайжруулах чиглэлийг баримталжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн хуулийн зохицуулалтаас зарчмын хувьд эрс ялгаатай өөрчлөлт хийгээгүй байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг тус хуулийн хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “**хүлээн зөвшөөрөгдөх байдал**” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу<sup>14</sup> тусгайлан хийх тул

<sup>10</sup> Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн судалгаа. 2021 он.

<sup>11</sup> Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн судалгаа. 2021 он.

<sup>12</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он.

<sup>13</sup> Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл. 2022 он. <https://mojha.gov.mn>

<sup>14</sup> 8.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “**зардал тооцох**” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

## ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Аргачлалын 3.2-т заасны дагуу сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 59, 60 дугаар зүйл	Хуулийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн саналд дүн шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах

### 1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд<sup>15</sup> тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараахь зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор тус хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, тусгай хуулиар зохицуулдаг харилцаанаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг хамруулах;

2.Хуулийн нэр томъёог Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх зэрэг тусгай зарчмыг тусган хуульчлах;

8.1.4.энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;

<sup>15</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2021 он. <https://cabinet.gov.mn>



3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн нийтийн өмчийн хөрөнгийн өмчлөгч нь Улсын Их Хурал, төрийн тусгайлсан хөрөнгийн өмчлөгч нь Засгийн газар, орон нутгийн өмчийн хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өмчлөгч байх зарчмыг хэвээр хадгалж, улмаар өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх субъект болох Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээний давхцлыг арилгаж, харилцан уялдаатай байдлаар зохицуулах;

4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ангиллыг тэдгээрийн хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилох зэрэг асуудлыг тухайлсан төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар зохицуулахаар хуульчилна;

5.Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, орон нутгийн өмч болон хувийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг эдийн засгийн хэмнэлттэй, зохистой, шударга байдлаар хэрэгжүүлэх журмыг нарийвчлан хуульчлах;

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсэг (төрийн нийтийн өмч, төрийн тусгайлсан өмч, орон нутгийн өмчийн)-ийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг зохицуулах;

7.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч төрийн хяналт шалгалтыг хариуцан гүйцэтгэх этгээдийн хэмжээг тодорхой зохицуулах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

➤ **Хуулийн үйлчлэх хүрээний талаар:**

1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилтыг өргөжүүлэн томъёолж, тус хуулиар зохицуулах харилцааны хүрээг тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг нэгтгэн тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, хуулийн үйлчлэлд хамаарахгүй болон тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлтэй<sup>16</sup> уялдуулан тодорхойлжээ.

Тухайлбал, улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан болон Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалт, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өмч ашиглуулах болон Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглахтай холбоотой харилцаа, түүнчлэн газар, ой, ургамал, ан амьтан, усны сан бүхий газар зэрэг ашиглалт болон бүртгэл, тооллогыг тусгай журмаар зохион байгуулдаг төрийн болон орон нутгийн өмчтэй холбогдох харилцааг тусгайлсан хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Харин төрийн болон орон нутгийн өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх зарчмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой тодорхой харилцааг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг

<sup>16</sup> Тус хуулийн төслийг ХЗДХЯ хариуцан боловсруулсан болно. [www.mojha.mn](http://www.mojha.mn)

зохицуулалтыг баримтлах бөгөөд тусгайлсан хуулиар зохицуулагдаагүй харилцаанд энэ хууль нөхөн үйлчлэхээр зохицуулжээ.

➤ **Хуулийн зохицуулалтыг Үндсэн хуульд нийцүүлэх талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тогтоож, төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмч, орон нутгийн өмчид хамаарах өмчийн төрлийг зааглан зохицуулжээ. Үүнд, төрийн нийтийн өмчид Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байхаар заасан байгалийн баялаг, хөрөнгийг хамруулсан бол төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчид төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой хөрөнгийг нэрлэн тодорхойлсон байна.

➤ **Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болох Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээг шинэчлэн тодорхойлжээ.

Энэхүү шинэчлэлийн хүрээнд өнөөгийн хууль хэрэглээний практикт үүсээд байгаа чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, харилцан уялдаатай, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд анхаарсан. Тухайлбал, Улсын Их Хурал нь төрийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд төрийн нийтийн өмчид хөрөнгө олж авах, төрийн өмчийг удирдах эрхийг хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт олгох, төрийн өмчит компани байгуулах стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалт батлах, тус салбарт компани байгуулах, хяналтын багцаас доошгүй хувийг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах зөвшөөрөл олгох, тооллогын дүн, өмчийн талаарх тайлантай танилцах, өмчлөгчийн хувьд хуульд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх онцгой эрхтэй байна.

Засгийн газар нь хуулиар олгосон эрхийн хүрээнд өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлж, үр нөлөө, ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцахаар чиг үүргийг тодорхойлсон байна.

Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын өмчийг удирдах чиг үүргийг зааглан тодорхойлсон байна. Орон нутгийн өмчит компани байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах, эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах, орон нутгийн өмчит компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг томилох, харьяа нэгжид хамаарах орон нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх шийдвэр гаргах эрх хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан байна.

➤ **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангиллын талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрөлд төрийн байгууллага, албан газраас гадна “улсын төсөвт үйлдвэрийн газар”, “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” зэрэг Иргэний хуулиар зохицуулаагүй хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд тусгасныг өөрчилж, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулж, улсын төсөвт үйлдвэрийн газрыг албан газрын ангилалд хамруулсан байна.

Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шинэ ангиллын дагуу “төрийн байгууллага”, “албан газар” гэх ойлголтыг нэр томъёогоор тайлбарлаж, тэдгээрийн хөрөнгө удирдах эрхийг нь ялгамжтай байдлаар зохицуулсан байна.

Түүнчлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг өргөжүүлж, өмчийг удирдах ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан байна.

Мөн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компани байгуулах, татан буулгах болон төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, газар, газар эзэмших эрхийг шилжүүлэх, зориулалтыг нь өөрчлөх асуудлаар дүгнэлт гаргах, компанийн менежментийн гүйцэтгэлийг үнэлэх, өмчийн төлөв байдлын талаарх жил бүрийн тайлан болон өмчийн улсын нэгдсэн тооллогыг зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна.

Түүнчлэн орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, удирдах үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг нэгдсэн журмаар хэрэгжүүлэх боломжийг хангах зорилгоор орон нутгийн өмчийн газрын чиг үүргийг тодорхойлжээ.

Мөн хуулийн шинэчлэлттэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинэчлэлийг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 1 жилийн хугацаанд багтаан зохион байгуулахаар зохицуулжээ.

Өөрөөр хэлбэл, одоогийн ангиллын дагуу улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах асуудлыг Засгийн газрыг шийдвэрийн дагуу зохион байгуулахаар шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан байна.

➤ **Өмчийг ашиглах, шилжүүлэх үндэслэл, журмын шинэчлэлийн талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хөрөнгө олж авах, үнэлж бүртгэх, эзэмших, ашиглах, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг хөрөнгийн харилцаатай холбоотой зохицуулалтын журмыг шинэчилсэн байна. Тухайлбал, төрийн болон орон нутгийн өмчийн газар, газар эзэмших эрх болон бусад үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх асуудлыг Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хэрэгжүүлэх бол төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, мөн хөдлөх хөрөнгийг худалдах асуудлыг өөрөө шийдвэрлэх боломжийг олгож, хөрөнгийн хөдөлгөөний шуурхай байдлыг хангасан.

Түүнчлэн төрийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, зохицуулалтыг оновчтой болгож, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, шууд шилжүүлэх зэрэг аргыг хэрэглэх үндэслэл, журмыг нарийвчлан тогтоосон. Мөн төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлсний дараах хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

➤ **Өмчийн бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцооны талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсэг (төрийн нийтийн өмч, төрийн тусгайлсан өмч, орон нутгийн өмчийн)-ийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг илүү нарийвчлан зохицуулсан. Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, хязгаарлагдмал эрх, оюуны өмчийг ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гэрээний бүртгэлийн шинэ төрөл бий болгож, холбогдох мэдээллийг ил тод байх зарчмыг тусгасан байна.

➤ **Өмчийн хяналт шалгалт, сахилга, хариуцлагыг сайжруулах талаар:**

Өмчлөгч болон төрийн хяналт, мөн дотоодын хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулсан бөгөөд Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх

бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газар нь төрийн хяналтыг хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

Энэ чиг үүргийн дагуу төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Орон нутгийн өмчийн газарт улсын байцаагч ажиллаж өмчийн бүртгэл, тооллогыг хэрэгжүүлсэн байдал, түүний үр дүнг хянах, жилийн болон хагас жилийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт гаргах, мөн хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Өмчийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн тухайн жилийн хөдөлгөөн, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг жил бүр гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг Засаг дарга, Засгийн газар хүлээх бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь мэдээ, тайлангаа олон нийтэд ил тод, байгууллагын цахим хуудсандаа байршуулах үүргийг хүлээхээр зохицуулжээ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн "Мэдээллийн нэгдсэн сан"-г бүрдүүлж, санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хангах үүргийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна. Төрийн болон албаны мэдээлэлд хамаарахаас бусад мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байхаар тусгажээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хуулийн төсөлд бүрэн тусгасан гэж дүгнэж байна.

## **2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:**

Хуулийн төслийн 59, 60 дугаар зүйлд заасан зохицуулалтыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг бууруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Хуулийн төслийн 58 дугаар зүйлд зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын хяналт нь:

1. Өмчлөгчийн хяналт;
2. Төрийн хяналт;
3. Дотоодын хяналт гэсэн төрлөөс бүрдэхээр заажээ.

Өмчлөгчийн хяналтыг төрийн өмчийн хувьд Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга дараах хэлбэр, аргаар хэрэгжүүлэхээр байна.

<b>Хяналтыг хэрэгжүүлэх хэлбэр</b>	<b>Хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ</b>
<ul style="list-style-type: none"><li>• Өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээтэй танилцах, үүрэг чиглэл өгөх;</li><li>• Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн ажлын үр дүн, хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх;</li></ul>	<p>Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдээс хөрөнгө олж авсан, хөрөнгийг ашиглах зөвшөөрөл өгсөн, өмчийг удирдсантай холбоотой баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, асуулга, асуулт тавих;</p> <p>Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн бүртгэлд оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг</p>

<ul style="list-style-type: none"> <li>• Өмчийн чиглэлээр хэрэгжүүлсэн мэргэжлийн болон дотоод хяналт шалгалт, аудитын тайлан, зөрчил, дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнтэй танилцах, үүрэг чиглэл өгөх.</li> </ul>	<p>нягтлах зорилгоор газар дээр нь үзлэг, шалгалт хийхийг даалгах;</p> <p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөх.</p>
--	--

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 3.1.1, 3.1.7-д Улсын Их Хурал нь “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хангуулах” болон “хууль хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй тулгамдсан асуудлыг тогтоох, Улсын Их Хурлын хяналт шалгалтын явцад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах замаар төрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх” зорилгоор асуулт, асуулга тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх, төсвийн хяналт, хяналтын сонсгол хийх, хянан шалгах түр хороо байгуулах аргаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр заажээ.

Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байх бөгөөд хуулийн 9 дүгээр зүйлд “...тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх, төсвийн хяналт, Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийхдээ...төлөвлөж цаглавар гаргана” гэж, мөн хуулийн 15, 16 дугаар зүйлд нэгдсэн хуралдаанаар сонсох мэдээлэл, Улсын Их Хурлаар хэлэлцэх тайлан, илтгэл, мэдээллийг нэрлэн заасан байна.

Харин Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт хяналтын хэлбэрт хамаарах мэдээлэл, тайлан, илтгэлд “төрийн өмчийн улсын нэгдсэн тооллогын дүн болон өмчийн төлөв байдлын жил бүрийн тайлан” тусгагдаагүй байна.

Иймд өмчийн улсын тооллогын дүн болон өмчийн төлөв байдлын жил бүрийн тайланг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх, сонсох, эсхүл холбогдох байнгын хороонд хүргүүлэх гэсэн ялгаатай ажиллагааны аль төрөлд хамаарахыг тодорхой болгож, хууль хоорондын зөрчлийг арилгахад анхаарах шаардлагатай байна.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д “Засгийн газар энэ хууль, бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан, Ерөнхийлөгчөөс санал болгосон асуудлыг хуралдаанаараа хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ” гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журмын<sup>17</sup> 4.1.2-т “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудал”-ыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр тус тус заасан байна.

Орон нутгийн өмчийн тооллогын дүн, төлөв байдлын жил бүрийн тайланг хэлэлцэх асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэн шийдвэрлэх боломжтой бол Засаг даргын хувьд мөн хуулийн 59, 60, 62, 63 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

Харин хуулийн төсөлд заасны дагуу өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх субъект болох Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээний ялгаатай байдлыг харгалзан “холбогдох тайлан, мэдээллийг хурлаар хэлэлцэх, эсхүл танилцах эсэх”, мөн “асуулга, асуулт тавих, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ ямар аргаар хэрэглэх эрхтэй” болохыг холбогдох хуулийн зохицуулалттай уялдуулан тодруулж, хуулийн төслийн 59 дүгээр

<sup>17</sup> Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 351 дүгээр тогтоол. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn).

зүйлийн зохицуулалтыг нарийвчилж, томъёоллыг тодорхой болгоход анхаарах шаардлагатай байна.

Хуулийн төслийн 60 дугаар зүйлд заасан “төрийн хяналт”-ын зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой боловч хяналтын байцаагчийн хувьд газар дээр нь хойшлуулшгүй хэрэгжүүлэх арга хэмжээ буюу битүүмжлэх, хураан авах зэрэг ажиллагааг хийх эсэх нь тодорхойгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

### **3. Ойлгомжтой эсэх:**

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хууль зүйн техник, боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг<sup>18</sup> хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллага, иргэд, судлаачдаас ирүүлсэн саналд хуулийн төслийн агуулга, бичвэрийг ойлгомжтой болгох чиглэлд хамаарах санал байгаа эсэхийг нягтлан анализ хийсэн болно.

Хуулийн төсөл нь 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатайг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн хэлбэрээр бичигдсэн бөгөөд нийт 13 бүлэг, 67 зүйлтэй байна.

Хуулийн төслийн бүтэц, хэлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан шаардлагад нийсэн эсэхийг хянахад:

- Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.
- Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасантай нийцсэн байна.
- Хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томъёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, үг үсгийн алдааг анхаарах шаардлагатай байна.

Хуулийн төсөлд холбогдох яамд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн байгууллага, Нээлттэй нийгэм форум, Монголын Хуульчдын холбоо, “Өмгөөллийн ивээл баг” ХХН зэрэг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод зэрэг нийт 30 гаруй байгууллагаас ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах талаар тодорхой саналуудыг ирүүлсэн байна.

Эдгээр саналыг харгалзан төслийн үг найруулга, бичвэрийн томъёоллыг ойлгомжтой болгоход анхаарах, Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 31, 32 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангахад анхаарах нь зүйтэй байна. Тухайлбал:

---

<sup>18</sup> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10 дахь заалт.

- ✓ Төслийн 9.2-т “Орон нутгийн өмч” гэсэн байдлаар нэгтгэн зохицуулсан нь 9.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна” гэж заасантай зөрчилдсөн төдийгүй аймаг болон сумын, нийслэл болон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээг тодорхой зааглан зохицуулах боломжийг хязгаарлаж байна. Иймд аймаг, нийслэл болон сум, дүүргийн өмчийг зааглан тодорхойлж, улмаар хуулийн төслийн 14, 15 дугаар зүйлд заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын чиг үүргийг дахин нягталж, давхардал, хийдлийг арилгах;
- ✓ Өмчийн тооллогын дүн болон өмчийн төлөв байдлын тайланг бэлтгэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх үүргийг сум, дүүргийн түвшинд Засаг даргад хүлээлгэж, орон нутгийн тооллогын дүн болон өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг Орон нутгийн өмчийн газар хариуцахаар хуулийн төслийн 15, 16 дугаар зүйлд өөрчлөлт оруулах;
- ✓ Төслийн 11.2.8-д “Улсын Их Хурал нь өмчийн төлөв байдлын тайлантай танилцах”-аар заасан боловч Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байгааг анхаарч, хууль хоорондын уялдааг хангах;
- ✓ Төслийн 13 дугаар зүйлд заасан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй уялдуулан 28.2-т заасан “Улсын болон орон нутгийн тооллого явуулах журам, аргачлал”-ыг тус байгууллага батлахаар өөрчлөх, мөн дотоодын тооллого явуулах журмыг хуульд нарийвчлан заасан тул тусгай журам батлах шаардлагатай эсэхийг дахин нягтлах, мөн 13.5.12-т заасан сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах зэрэг чиг үүрэг нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт шууд хамаарахгүй тул томъёоллыг ойлгомжтой болгох;
- ✓ Төслийн 19 дүгээр зүйлд заасан “албан газар”-ыг орон нутагт байгуулах асуудлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх, мөн төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэнд, боловсрол, соёлын байгууллагын хувьд тусгайлсан хуулиар зохицуулагддаг тул эдгээр албан газрыг байгуулах, татан буулгах асуудлыг холбогдох хуулиар зохицуулахаар нэмэлт оруулах;
- ✓ Төслийн зохицуулалтын нэр томъёог жигдлэх. Тухайлбал, “өмч хөрөнгийн улсын үзлэг”, “улсын тооллого”, “улсын үзлэг тооллого”, мөн “нэгдсэн дүн”, “нэгтгэсэн дүн” гэх зэргээр өөр, өөр томъёолсон байгааг анхаарах;
- ✓ Төслийн 9.2.2, 9.2.3, 12.3, 16.1.3, 18.5, 23.2, 63.3.1 дэх заалтын үг, үсгийн алдааг засах, хуулийн төсөлд хэрэглэсэн эш татсан зохицуулалтыг нягтлах.

#### 4. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд заасан стандарт асуултуудад хариулах байдлаар шалгах бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь хамруулахаар тооцлоо.

Хуулийн төслийн зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 дахь заалт болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг дараахь байдлаар үнэлсэн болно. Үүнд:

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар

	хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагалдуулан нийт 20 хуулийн төсөл боловсруулсан байна.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд хуулийн төслийн зарим заалт өөр хоорондоо, давхардсан, зөрчилдсөн байх тул залруулах шаардлагатай.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Тийм	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эргэн нягталж, зохих өөрчлөлтийг оруулах шаардлагатай.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх, үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн шаардлагатай төсөлд	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт



	зохицуулалтыг орхигдуулсан эсэх		зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Зарчим, хяналт шалгалтын нийтлэг журамд ерөнхий байдлаар зохицуулсан.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй. Зарчим, хяналт шалгалтын нийтлэг журамд ерөнхий байдлаар зохицуулсан.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн зохицуулалт байхгүй, харин хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим хууль тогтоомж, болон хуулийн төслийн зарим заалт өөр хоорондоо давхардал, хийдэл үүсгэсэн байх тул алдааг засварлах, зарим нэмэлт зохицуулалтыг тусгах зэргээр хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шаардлагатай байна.

### **ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Засгийн газрын санаачилсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд, хуулийн төсөлд ирүүлсэн санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа:

#### **Дүгнэлт:**

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.
- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төсөлд өмчийг удирдах ажиллагааны журмыг нарийвчилж, хяналтыг өндөржүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаж, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарсан нь сайшаалттай байна. Гэвч практикт хэрэгжих байдлыг сайжруулах зорилгоор зохицуулалт хоорондын уялдааг хангах, зарим зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.
- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан, ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.
- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

#### **Зөвлөмж:**

Хуулийн төсөлд дараахь агуулгын чанартай зохицуулалт нэмэх, зүйл, заалтыг тодруулах зорилгоор өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд:

- Хуулийн төслийн 3 дугаар зүйл буюу “Хуулийн үйлчлэх хүрээ”-нд хамаарах зохицуулалтыг дахин нягталж, томъёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах;
- Хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан “Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг”-ийг дахин нягталж, тодорхой болгох, эрэмбэ дарааллын зохистой байдлыг хангах;
- Орон нутгийн өмчийн ангиллыг тодорхой болгож, аймаг, нийслэл болон сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын чиг үүргийг зааглан зохицуулах, харилцан уялдааг хангахад анхаарах;
- Өмчийн тооллогын дүн болон өмчийн төлөв байдлын тайланг бэлтгэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх үүргийг сум, дүүргийн түвшинд Засаг даргад хүлээлгэж, нэгдсэн дүн, тайланг Орон нутгийн өмчийн газар хариуцахаар хуулийн төслийн 15, 16 дугаар зүйлд өөрчлөлт оруулах;
- Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх субъект болох Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээний ялгаатай байдлыг харгалзан тайлан, мэдээллийг хэлэлцэх, эсхүл танилцах эсэх, мөн асуулга, асуулт тавих, хяналт шалгалт хэрэгжүүлэх аргыг хэрэглэх байдлыг тодруулж, хуулийн

төслийн 59 дүгээр зүйлийн зохицуулалтыг нарийвчилж, томъёоллыг тодорхой болгоход анхаарах;

- Төслийн 11.2.8-д “Улсын Их Хурал нь өмчийн төлөв байдлын тайлантай танилцах”-аар заасан боловч Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байгааг анхаарч, хууль хоорондын уялдааг хангах;
- Энэ хуулийн хүрээнд батлан мөрдүүлэхээр заасан хэм хэмжээний акт буюу журам, аргачлал шаардлагатай эсэх, мөн тэдгээрийг батлах эрх бүхий субъектын оновчтой байдлыг нягталж, журмаар зохицуулах харилцааны хүрээг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн тодорхой болгоход анхаарах;
- Төслийн 19 дүгээр зүйлд заасан “албан газар”-ыг орон нутагт байгуулах асуудлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх, мөн төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэнд, боловсрол, соёлын байгууллагын хувьд тусгайлсан хуулиар зохицуулагддаг тул эдгээр албан газрыг байгуулах, татан буулгах асуудлыг холбогдох хуулиар зохицуулахаар нэмэлт оруулах;
- Төслийн 43.1.2 болон 43.4-т заасан “өмчийг бусдын эзэмшилд шууд шилжүүлэх” асуудлыг тодруулж, үндэслэл, журмыг нарийвчлах;
- Төслийн 60 дугаар зүйлд заасан “төрийн хяналт”-ын зохицуулалт практикт хэрэгжих боломжтой боловч хяналтын байцаагчийн хувьд газар дээр нь хойшлуулшгүй хэрэгжүүлэх арга хэмжээ буюу битүүмжлэх, хураан авах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, нэмэлт боловсруулалт хийх;
- Төслийн зохицуулалтын нэр томъёог жигдлэх, утга найруулгыг сайжруулах, үг, үсгийн алдааг засах. Тухайлбал, төслийн 9.2.2, 9.2.3, 12.3, 16.1.3, 18.5, 23.2, 63.3.1 дэх заалтын бичвэрийг нягтлах;
- Тус хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг дахин хянах. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эргэн нягталж, зохих өөрчлөлтийг оруулах. Мөн энэхүү үнэлгээний зөвлөмжийн дагуу зарим чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шинээр боловсруулах.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

### Хуулийн төсөл, үзэл баримтлал:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2022 он;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2021 он;
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах хуулийн төслүүд. 2022 он;
4. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл. 2022 он;
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2021, 2022 он.

### Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
3. Хууль тогтоомжийн тухай хууль;
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль;
5. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль;
6. Захиргааны ерөнхий хууль;
7. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
8. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
9. Банкны тухай хууль;
10. Боловсролын тухай хууль;
11. Эрүүл мэндийн тухай хууль;
12. Соёлын тухай хууль;
13. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.

### Судалгаа, бусад баримт, мэдээлэл:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он;
2. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тордуулах нь. 2021 он. ННФ;
3. Монгол Улсын орон нутгийн өмчийн харилцаа. 2021 он. ХЗҮХ, Өмгөөллийн Ивээл баг;
4. Монгол Улсын төрийн байгууллагын эрх зүйн байдал. 2021 он. ХЗҮХ, Bogd research institute;
5. Төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт-Япон улсын жишээ. 2021 он. ННФ.



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**  
**Cabinet Secretariat of Government of Mongolia**

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГА/-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО**

*/Үнэлгээний тайлан/*

**Улаанбаатар хот**  
**2022 он**

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

## Нэг.Ерөнхий зүйл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг<sup>1</sup> баталсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "Аргачлал" гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцож, улмаар холбогдох ачааллыг багасгах, зардлыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг:

- 1.төрийн байгууллагын зардал;
- 2.хуулийн этгээдийн зардал;
- 3.иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр *хувь хүн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй* тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй.

Иймд энэхүү тооцооллын хүрээнд *иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох шаардлагагүй* бөгөөд харин төрийн байгууллагын хувьд шинээр хүлээлгэсэн зарим чиг үүрэгтэй холбоотой үүсэх тодорхой зардлыг тогтоож, хялбарчлах хувилбарыг санал болгоно.

1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах зорилгоор хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн зорилт, харилцааны хүрээ, нийтлэг зарчим, төрийн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээ, өмчийг удирдах үйл ажиллагааны журмыг шинэчлэн тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг нарийвчилж, хэрэгжих баталгаа, үр өгөөж, хариуцлагыг нэмэгдүүлж байгаа тул төрийн байгууллага, албан тушаалтны хувьд тус чиглэлд хүлээх чиг үүрэг хэвээр хадгалагдаж байна. Харин цөөн хэдэн чиглэлээр эрх бүхий этгээдэд нэмэлт үүргийг хүлээлгэжээ.

Тухайлбал, жил бүр өмчийн төлөв байдлын талаарх тайлан гаргах, түүнийг тодорхой үе шатаар хэлэлцэх, мөн төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг тодорхой чиг үүрэгтэй холбоотой төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхээс гадна төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын шинэчлэлттэй холбоотой тодорхой хэмжээний шууд зардал гарахаар байна.

Иймд энэхүү тооцоололд иргэн болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг хамруулахгүйгээр төрийн байгууллага буюу улсын төсөвт нөлөөлөх зардлыг тооцсон болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход Аргачлалын дагуу доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- Төрийн байгууллагад шинээр хүлээлгэсэн үүргийг оновчтой тодорхойлох;<sup>2</sup>
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>3</sup>

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын санаачилсан хуулийн төсөл, 2021 он.

<sup>2</sup> Зардлын тооцоог хийх аргачлалын 2.3, 4.3 дахь зохицуулалт.

<sup>3</sup> Зардлын тооцоог хийх аргачлалын 2.4.4, 4.4 дэх зохицуулалт.

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>4</sup>
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.<sup>5</sup>

### **Хоёр.Төрийн байгууллагад үүсэх зардал**

Хуулийн төсөлд тусгасан шинэ чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн байгууллага буюу улсын төсөвт тодорхой зардал үүсэхээр байх тул Аргачлалын дагуу хүний нөөц, захиргааны болон шууд зардал гэсэн хувилбараар зардлыг тооцлоо.

Үүнд:

#### **2.1.Өмчийн төлөв байдлын тайланг жил бүр гаргах, хэлэлцүүлэх:**

Хуулийн төслийн 62.2-т “Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага...өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт хүргүүлнэ” гэж заасан бөгөөд мөн төслийн 12.2.13-т “төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг хэлэлцэн, холбогдох шийдвэр гаргах, тайланг Улсын Их Хуралд танилцуулах” үүргийг Засгийн газарт хүлээлгэсэн байна.

Мөн хуулийн төслийн 14, 15, 16 дугаар зүйлд Аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүр өмчийн төлөв байдлын тайланг гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх бөгөөд сумын тайланг аймгийн Өмчийн газар, дүүргийн тайланг нийслэлийн Өмчийн газар нэгтгэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр тусгасан байна. Харин хуулийн 15.2-т харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч болон нэгжийн өмчийн талаарх мэдээллийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоосон хугацаанд хариуцан нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр байна.

Өмчийн төлөв байдлын тайланд “төрийн болон орон нутгийн өмчийн нөөц, хөрөнгийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийн талаар тухайн жилд гарсан хөдөлгөөнийг тусгасан” байхаар заажээ.

Тус тайланг гаргах хүрээнд дараахь субъектүүд тус бүр тодорхой үүрэг хүлээж байгааг тодруулж үзвэл:

Үүрэг хүлээгч			Гүйцэтгэх чиг үүрэг
1	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	Холбогдох мэдээ, тайланг баталсан маягт, зааврын дагуу тухай бүр, хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнах (62.1)	Тайлан, мэдээ боловсруулах Тайланг хүргүүлэх
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга	Нэгжийн өмчийн төлөв байдлын тайланг бэлтгэж, ИТХ-д танилцуулах	Мэдээллийг нэгтгэн тайлан боловсруулах Тайланг хүргүүлэх
3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Нэгжийн өмчийн төлөв байдлын тайланг хэлэлцэж, Засаг даргад үүрэг чиглэл өгөх	Тайланг хуралдаанаар хэлэлцэх
4	Орон нутгийн өмчийн газар (аймаг, нийслэлийн Өмчийн газар)	Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг бэлтгэж, төрийн өмчийн Агентлагт хүргүүлэх (16.3.5)	Тайланг нэгтгэн боловсруулах Тайланг хүргүүлэх

<sup>4</sup> Зардлын тооцоог хийх аргачлалын 4.4.3.1 дэх зохицуулалт.

<sup>5</sup> Зардлын тооцоог хийх аргачлалын 2.1, 4.1 дэх зохицуулалт.

5	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг бэлтгэж, Засгийн газарт хүргүүлэх	Тайланг нэгтгэн боловсруулах Тайланг хүргүүлэх
6	Засгийн газар	Төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг хэлэлцэж, УИХ-д хүргүүлэх	Тайланг хуралдаанаар хэлэлцэх УИХ-д хүргүүлэх
7	Улсын Их Хурал	Төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайлантай танилцаж, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх	Тайланг хэлэлцэх

Өнөөдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг бүртгэлийг батлагдсан тусгай маягтын дагуу хийдэг бөгөөд нийт 26 төрлийн маягт ашиглаж байна.

Тухайлбал, төрийн өмчит хуулийн этгээд нь Төрийн өмчийн бүртгэлийн ТӨХ-1-ээс ТӨХ-11, “Захиргааны статистикийн” ТӨ-1-ээс ТӨ-15 гэсэн бүртгэлийг хөтөлж, жил бүр холбогдох мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлдэг бол орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар нэгтгэн хүргүүлдэг байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь энэхүү мэдээллийг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд тайлагнадаг бөгөөд 2021 оны байдлаар Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар болон 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийн 4800 гаруй хуулийн этгээдийн мэдээ, тайланг хүлээн авч нэгтгэн тайлагнасан байна.<sup>6</sup>

Өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тайланд дараахь мэдээллийг тусгадаг. Үүнд:

1. Төрийн болон аймаг, нийслэлийн (орон нутгийн) өмчит хуулийн этгээдийн тухайн оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн мэдээ;
2. Төрийн болон аймаг, нийслэлийн (орон нутгийн) өмчит хуулийн этгээдийн тухайн оны статистикийн мэдээ, тайлан (12 маягтаар);
3. Нийслэл, 21 аймгийн төрийн<sup>7</sup> болон орон нутгийн<sup>8</sup> өмчит нийт 5704 хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайлан, мэдээ г.м.

Үүнээс дүгнэхэд хуулийн төслийн 62.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн бүртгэл, мэдээллийн тайлан гаргах болон хуулийн төслийн 16.3.5-д заасан Орон нутгийн өмчийн газар (аймаг, нийслэлийн Өмчийн газар), мөн хуулийн төслийн 13.5.6-д заасан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамаарах “Өмчийн төлөв байдлын тайлан гаргах” асуудал нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд шинээр хүлээлгэсэн үүрэг биш байна.

Харин хуулийн төслийн 12.2.12-т заасан өмчийн төлөв байдлын тайланг жил бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, Улсын Их Хуралд хүргүүлэх, мөн хуулийн төслийн 11.2.8-д заасан Улсын Их Хурлын чуулганаар өмчийн төлөв байдлын тайланг жил бүр хэлэлцэх зохицуулалттай холбоотой Засгийн газар болон Улсын Их Хуралд тодорхой ачаалал нэмэгдэхээр байна.

Гэвч тайланг хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг хянах асуудал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д “Засгийн

<sup>6</sup> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээлэл. 2022 он.

<sup>7</sup> Төрийн өмчит 1057 хуулийн этгээдийн мэдээлэл.

<sup>8</sup> Орон нутгийн өмчит 4647 хуулийн этгээдийн мэдээлэл.



газар энэ хууль, бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ...асуудлыг хуралдаанаараа хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ” гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журмын<sup>9</sup> 4.1.2-т “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудал”-ыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр заасан чиг үүрэгт хамаарч байна.

Мөн тайланг УИХ-ын чуулганаар хэлэлцэх, эсхүл танилцах асуудал нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 3.1.1, 3.1.7-д “Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хангуулах... зорилгоор мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх” зэрэг аргаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хамаарч байна.

Түүнчлэн хуулийн төслийн 62.4-т заасан өмчийн төлөв байдлын тайлан, түүнд хамаарах мэдээллийг Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох байгууллага, хуулийн этгээд өөрийн цахим хуудсандаа байршуулах үүрэг нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд уялдуулан хэрэгжүүлэх боломжтой байна.

Иймд өмчийн төлөв байдлын тайланг жил бүр гаргах, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газар болон Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхтэй холбоотой улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй хэмээн дүгнэж байна.

## **2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах:**

Хуулийн төслийн 63 дугаар зүйлд “төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого болон холбогдох тайлан, хяналт шалгалтын талаарх мэдээлэл” бүхий Мэдээллийн нэгдсэн санг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтлөхөөр заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг 1996, 2000, 2003, 2007, 2011, 2015 онд буюу нийт 6 удаа явуулжээ.<sup>10</sup> Өнөөдрийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн маягтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас батлан мөрдүүлж байна.

Энэхүү бүртгэлийн маягтын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг авч нэгтгэн орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг гаргадаг.<sup>11</sup>

Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-д нэгтгэдэг бөгөөд энэхүү системээс төрийн байгууллагаас гадна иргэд, олон нийт ч холбогдох мэдээллийг авах боломжтой байдаг байна.<sup>12</sup>

Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлд 2006 оноос эхлэн 4 төрлийн системийг ашиглаж байсан бөгөөд 2013 оноос “Төрийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийг БНСУ-ын “КОЙКА” олон улсын байгууллагын 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар боловсруулж, 2015 оноос эхлэн дүүргэлт хийж, бүртгэлийн ажиллагаанд ашиглаж эхэлжээ.

<sup>9</sup> Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 351 дүгээр тогтоол. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn).

<sup>10</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын мэдээлэл. 2021 он. ТӨБЗГ.

<sup>11</sup> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын таницуулга. 2022 он.

<sup>12</sup> Монгол Улсын орон нутгийн өмчийн харилцааны тулгамдсан асуудал- 2021 он. ХЗҮХ, Өмгөөллийн иэвээл баг.

Энэхүү системд 6690 байгууллагын эзэмшил газар, барилга байгууламж, нийтийн эзэмшил, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, түүх, соёлын дурсгалт зүйлс, санхүүгийн тайлан, оюуны өмч гэх мэт 16 төрлийн 1.176.029 мэдээлэл бүртгэгдсэн байна.<sup>13</sup>

Гэвч “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем” нь бусад төрийн байгууллагын мэдээллийн сантай холбогдоогүй, цаашид нэмэлт хөгжүүлэлт хийх боломж хязгаарлагдмал зэрэг сул талтай тул шинээр систем бүрдүүлэх шаардлага тулгараад байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн систем үүсгэх, хөрөнгийн хөдлөлийн бүртгэлийг цахимжуулах шаардлагын хүрээнд дараахь хэрэгцээ, шаардлагыг хангасан бүртгэлийн систем (hardware & software)-ийг боловсруулж, ашиглалтад нэвтрүүлэх шаардлагатай гэж тооцон, холбогдох<sup>14</sup> зорилтыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт<sup>15</sup> тусгажээ. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх мэдээллийг нэгтгэх, холбогдох мэдээллийн сангаас мэдээлэл татах болон өгөгдлийн санд цуглуулсан мэдээллийг шийдвэр гаргалтад ашиглах;
- ✓ Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг орон зайн мэдээллийн сантай холбох;
- ✓ Өмчийн бүртгэлтэй холбоотой процесс, тайлан, мэдээлэлд анализ дүн шинжилгээ хийх;
- ✓ Хөрөнгийн ангиллын нэгдсэн кодчиллыг бий болгож, бүртгэлийг тухайн хөрөнгийн дэлгэрэнгүй шинж чанар бүрээр бүртгэх боломжийг бий болгох, түүхчилсэн мэдээллийн санг үүсгэх;
- ✓ Төрөл бүрийн аналитик тайланг динамик байдлаар үүсгэх;
- ✓ Ухаалаг гар утсанд суурилсан аппликэйшнийг нэвтрүүлж, хэрэглэгчийн өөрийн ажлын онцлогт тохируулан уян хатан байдлаар удирдах боломжтой байх.

Өөрөөр хэлбэл, тусгай симтемиг бий болгож ашигласнаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн төлөв байдал, тэдгээрийн хөдөлгөөн, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Компанийн засаглал (хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, төлөвлөгөө гүйцэтгэл г.м), үйл ажиллагааны үр дүн тайлагнал, эрхийн бүртгэл (өмчлөх, эзэмших, түрээслэх, узуфрут, сервитут г.м), мөн хяналт шалгалт, үнэлгээний мэдээллийг бүрэн хамруулах боломжтой болох бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан өмчийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, хяналттай холбоотой зохицуулалтын хэрэгжилт бүрэн хангагдах болно.

Мөн систем нь төр, орон нутгийн өмч бий болох, түүнтэй холбоотой үүсэх бүхий л байгууллагын бүртгэлийг нэгтгэх, актлах, иргэдэд дуудлагаар борлуулах, бүртгэлээс хасах хүртэлх бүхий л процессыг бүртгэх боломжтой бөгөөд Сангийн яам, Автотээврийн үндэсний төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Татварын ерөнхий газар, Аудитын ерөнхий газар, Үндэсний дата төв, E-mongolia зэрэг бүртгэл, мэдээллийн системтэй холбогдсон байх шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний<sup>16</sup> 4.1.4.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник

<sup>13</sup> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын таницуулга. 2022 он

<sup>14</sup> “4.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2020 он.

<sup>15</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>16</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох” арга хэмжээг төлөвлөсөн байна.

Он	Арга хэмжээ	Санхүүжилт /сая.төг/
2021	Төлөвлөлт болон санхүүжилтыг шийдвэрлэх	
2022	Програм хангамжийг сайжуулах төлөвлөгөө гаргаж, техник хангамжийн төсвийг батлуулах	800.0
2023	Мэдээллийн санг бий болгох ажлыг хэрэгжүүлэх	300.0
2024	Мэдээллийн санг төрийн байгууллагын бусад системтэй холбох	100.0

“Мэдээллийн нэгдсэн системийн бодлогын даалгаврыг боловсруулах” зорилго бүхий Ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулж байгаа бөгөөд 2022 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу програм хангамжийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан байна.

Иймд хуулийн төслийн 63 дугаар зүйлд заасан “Мэдээллийн нэгдсэн сан” бүрдүүлэх арга хэмжээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэх бүрэн боломжтой байх тул энэ чиглэлд урьдчилан төлөвлөсөн төлөвлөгөөт санхүүжилтээс гадуур нэмэлт зардал шаардахгүй хэмээн дүгнэж байна.

### **2.3.Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтыг шинэчлэх**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүртгэлээр төрийн өмчит компани (хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани) 69, төрийн өмчийн оролцоотой компани 14, төрийн өмчит үйлдвэрийн газар 23, хувь нийлүүлсэн нийгэмлэг 1, улсын төсөвт үйлдвэрийн газар 22, ЗГХЭГ болон яамдын харьяа үйлдвэрийн газар 19 байна.

Харин орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 13 хувьцаат компани, 231 үйлдвэрийн газар, өрхийн эмнэлэг 74, нийт 349 хуулийн этгээд орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.<sup>17</sup>

Эдгээр төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалттай нийт 295 хуулийн этгээд байгаагаас 242 буюу 82 хувь нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 53 буюу 18 хувь нь улсын болон орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар байна.

Иймд хуулийн шинэчлэлийн дагуу аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг тодорхой шалгуурыг харгалзан татан буулгах, эсхүл компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, улсын болон орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрыг татан буулгах, эсхүл албан газрын зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Төсвийн орлогын бодлогын шинэчлэлийн хүрээнд тодорхой шалгуурыг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр холбогдох судалгааг хийж байгаа бөгөөд урьдчилсан мэдээллээр 20 орчим хуулийн этгээдийг татан буулгах боломжтой хэмээн тооцоолж байна.<sup>18</sup>

Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолд “Төрийн өмчит компанийн эрсдэлийн үнэлгээ, чиг үүргийн болон үр дүнгийн шинжилгээ хийж, өөрчлөн байгуулах, үнэт цаасны

<sup>17</sup> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээлэл. 2022 он.

<sup>18</sup> Ажлын хэсгийн урьдчилсан тооцоолол. 2022 он.

анхдагч зах зээлд нэмэлт хувьцаа гаргах боломжтой эсэх санал боловсруулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын эрхэлж байгаа үйл ажиллагаа нь хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой, мөн санхүүгийн эрсдэл өндөртэй, үр ашиггүй бол татан буулгах, нэгтгэх, эсхүл худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болно.

Иймд 20 орчим төрийн болон орон нутгийн өмчит компани болон үйлдвэрийн газрыг татан буулгана гэж тооцвол 265 орчим компани болон үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулахаар байна.

Хуулийн төслийн 65.2-т зааснаар энэхүү шинэчлэлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Орон нутгийн өмчийн газар хамтран хэрэгжүүлэх тул хүний нөөцийг шинээр бий болгох шаардлагагүй. Одоогийн байдлаар нийслэл болон аймгийн Орон нутгийн өмчийн газарт нийт 250 орчим мэргэжилтэн ажиллаж байна.

Иймд хүний нөөцийн болон захиргааны зардал нэмэлтээр гарахгүй, холбогдох байгууллага хүний нөөц, үйл ажиллагааны зардалдаа багтаан хэрэгжүүлэх боломжтой хэмээн тооцож байгаа тул Аргачлалд заасны дагуу хүний нөөц болон захиргааны зардлыг тусгайлан тооцоогүй болно.

Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулахтай холбоотой тамга тэмдэг, гэрчилгээний үнэ болон бүртгэлийн хураамж, банканд харилцах данс нээлгэх зэрэгт дунджаар 64.000 орчим төгрөгийн шууд зардал гарах<sup>19</sup> тул 265 аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулна гэж тооцвол нийт 16,960,000.00 төгрөгийн шууд зардал гарахаар байна.

<b>Нэгж зардал</b>	<b>Тохиолдлын тоо</b>	<b>Нийт зардал</b>
64.000 төгрөг	265	16,960,000.00

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардал болон үр өгөөжийг харьцуулж үзвэл төрийн болон орон нутгийн төсөв, хөрөнгийн алдагдал, хүний нөөцийн давхардал, зардлын хэтрэлт зэрэг эрсдэлийг арилгаж, улмаар улсын төсвийн хэмнэлт, ашиг ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөө бий болохоор байна.

Иймд хуулийн төслийн 65 дугаар зүйлд заасан шилжилтийн үеийн зохицуулалтыг хэрэгжүүлэх нь улсын төсөвт ямар нэгэн байдлаар дарамт учруулах, үргүй зардал гаргах эрсдэлгүй хэмээн дүгнэж байна.

-----oOo-----

<sup>19</sup> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээлэл. 2022 оны 3 дугаар сарын 23

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээлэл. 2022 он;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль;
4. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
6. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол;
7. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 351 болон 2021 оны 345 дугаар тогтоол;
8. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт;
9. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2022 он;
10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2022 он;
11. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. 2021 он;
12. Монгол Улсын орон нутгийн өмчийн харилцааны тулгамдсан асуудал-Цуврал судалгаа. 2021 он. ХЗҮХ, Өмгөөллийн Ивээл баг;
13. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн илтгэл. 2022 он. ЗГХЭГ, ХЗДХЯ.

## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

*Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон  
Төрийн болон орон нутгийн өмчит компанийн  
тухай хуулийн төслийн талаар*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 14:00-17:30 цагийн хооронд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба зэрэг төрийн байгууллагаас гадна төрийн болон орон нутгийн өмчит компаниудаас “Эрдэнэс таван толгой” ХК, “И-Монголиа Академи” УТҮГ, “Төрийн орон сууцны корпораци” ХХК зэрэг байгууллагын төлөөлөл, нийт 110 гаруй оролцогч оролцсон.

Түүнчлэн, дээрх хэлэлцүүлэгт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн, судлаачид, “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын судлаач нар оролцож, хуулийн төслүүдийн талаар асуулт асууж, санал, шүүмж хэлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, Сангийн яамнаас Төрийн өмчит компанийн шинэчлэл сэдэвт илтгэл, танилцуулгыг хийсэн.

Хэлэлцүүлэгт оролцогч нараас төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, компанийн засаглалын талаар, ялангуяа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагыг томилох, сонгох процесс, түүний ил тод байдлыг хангах, компанийн хяналтын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх, компанийн ногдол ашгийн бодлогын талаар голлон асууж, саналаа хэлсэн болно.

Мэдээний линк: <https://mojha.gov.mn/?p=7555>

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР,  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 14:00-16:30 цагийн хооронд Хууль зүй, дотоод хэргийн яамны хурлын 701 тоот танхимд зохион байгуулна.

**Нэг.Хэлэлцүүлэг дараах хөтөлбөрийн дагуу явагдана:**

Д/д	Цаг	Үйл ажиллагаа	Албан тушаалтан
1	13:30-14:00	Бүртгэл	Хууль зүйн бодлогын газар
2	14:00-14:10	Нээлт	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар
3	14:10-14:35	Танилцуулга Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул
4	14:35-14:45	Асуулт, хариулт	Оролцогчид
5	14:45-15:10	Танилцуулга Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цолмон
6	15:10-15:20	Асуулт, хариулт	Оролцогчид
7	15:20-15:35	Цайны завсарлага	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
8	15:35-15:50	Танилцуулга Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар баримтлах чиглэл	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Б.Тэлмүүн
9	15:50-16:20	Нэгдсэн хэлэлцүүлэг	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг
10	16:20-16:30	Хаалт	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг

**Хоёр.Хэлэлцүүлэгт дараах нэр бүхий хүмүүс оролцоно:**

Д/д	Нэр	Албан тушаал
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</b>		
1	Б.Ганбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга
2	Д.Батбаатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
3	Н.Мягмар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга
4	П.Зоригтбаатар	Засгийн Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга
5	Д.Саруул	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт
6	Д.Нямдэлгэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын референт
7	Б.Төрбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч

8	Д.Энхцэцэг	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт
<b>Хууль зүй, дотоод хэргийн яам</b>		
9	Х.Нямбаатар	Хууль зүй, дотоод хэргийн сайд
10	П.Сайнзориг	Төрийн нарийн бичгийн дарга
11	Д.Цолмон	Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
12	Э.Энхтуяа	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
13	З.Энхболд	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
14	Л.Хосбаяр	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
15	Н.Жамъянхүү	Хууль зүйн бодлогын газрын шинжээч
<b>Яам, агентлаг, бусад төрийн байгууллага</b>		
16	Б.Тэлмүүн	Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга
17	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга
18	Б.Сүх-Очир	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга
19	Ш.Бат-Эрдэнэ	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн
20	Э.Батболд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга
21	Б.Ерэн-Өлзий	Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
22	Н.Бат-Эрдэнэ	Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга
23	Б.Жавзанжаргал	Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
24	Н.Энхбат	Соёлын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
25	Д.Мөнхцэцэг	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
26	С.Сүхболд	Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга
27	Д.Нямхүү	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Салбарын хөрөнгө оруулалт хариуцсан шинжээч
28	Б.Баттөмөр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Нийгмийн хамгааллын бодлогын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
29	Г.Гантөр	Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
30	Б.Солонго	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
31	Д.Байгалмаа	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Ерөнхий нягтлан бодогч
32	Д.Сэлэнгэ	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
33	Б.Ундрал	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
34	Ц.Должинсүрэн	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн ахлах мэргэжилтэн
35	С.Ундрах	Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомт, чөлөөт бүсийн газрын ахлах мэргэжилтэн
36	Х.Батсайхан	Соёлын яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
37	Л.Ганзориг	Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн ахлах ымэргэжилтэн
38	Д.Оюунсүрэн	Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
39	Б.Энхтуул	Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн



40	Э.Ихбаяр	Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
41	С.Сүхболд	Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газры дарга
42	Б.Мөнхбат	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
43	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга
44	А.Ариунболд	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга
45	Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга
46	Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга
47	Д.Дэлгэрмаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
48	Д.Энхтуяа	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн
49	Ц.Цогтжаргал	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Салбарын эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн
50	Д.Сэрээдорж	Харилцаа холбооны зохицуулах хорооны дэд дарга
51	З.Эрдэнэчулуун	Харилцаа холбооны зохицуулах хорооны ЗУХАГ-ын дарга
52	Ц.Баярбаатар	Харилцаа холбооны зохицуулах хорооны Дотоод аудит, хяналтын албаны дарга
53	Т.Ууганбат	Харилцаа холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга
54	Б.Нямдулам	Харилцаа холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
55	Т.Мөнхнаран	Харилцаа холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
56	П.Золбоо	Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
57	Т.Зулмандах	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүүгийн мэдээ, тайлан хариуцсан ахлах шинжээч
<b>Нийслэлийн Засаг даргын тамгын газар</b>		
58	Д.Мөнх-Эрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх
59	Б.Мөнгөншагай	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
60	М.Баяраа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
61	Б.Болор-Эрдэнэ	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч дарга
62	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга
63	Д.Баялагцэнгэл	Хууль тогтоомж, эрх зүйн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
64	Л.Нарангоо	Гэрээний бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн
65	Н.Төрболд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Хуулийн мэргэжилтэн
<b>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>		
66	Б.Батбямба	Нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга
<b>Төрийн болон орон нутгийн өмчит компани</b>		
67	М.Батбаяр	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга
68	Т.Цолмон	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Гэрээ, эрх зүйн хэлтсийн дарга
69	М.Энхмэнд	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын дарга
70	Э.Түвшинтөр	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Эрсдэлийн удирдлага хариуцсан мэргэжилтэн

71	Л.Онгонцэцэг	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Захиргаа, үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
72	Г.Болдсайхан	“РТҮС” УТҮГ-ын Хуулийн зөвлөх
73	Г.Амгалан	“И-Монгол Академи” УТҮГ-ын Ерөнхий нягтлан бодогч
74	В.Мөнгөнсүх	“Төрийн орон сууцны корпораци” ХХК-ийн Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газрын дарга
75	Н.Баярчимэг	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн Гүйцэтгэх захирал
76	Б.Дэнсмаа	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн Захиргаа, удирдлагын газрын захирал
77	О.Отгонбаяр	“Монгол Шуудан” ХК-ийн Хуулийн зөвлөх
<b>МУИС-Хууль зүйн сургууль</b>		
78	Б.Амарсанаа	МУИС-ХЗС-ийн захирал
79	Г.Давааням	МУИС-ХЗС-ийн багш
80	Б.Оюунжаргал	МУИС-ХЗС-ийн багш
81	Б.Баасандорж	МУИС-ХЗС-ийн багш
<b>Бусад</b>		
82	О.Батхүү	Монголын Хуульчдын холбооны Олон улсын эрх зүйн хорооны тэргүүн
83	П.Баяр	Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны гишүүн
84	Д.Буянзаяа	Өмгөөлөгч
85	Б.Жавхланбаяр	Өмгөөлөгч
86	Н.Нямжаргал	Өмгөөлөгч
87	Д.Оросоо	Өмгөөлөгч
88	Ц.Байгалмаа	Өмгөөлөгч
89	Д.Баасансүрэн	Өмгөөлөгч
90	Б.Тунгалагнаран	Өмгөөлөгч
91	Б.Жавхланбаяр	Өмгөөлөгч
92	Д.Эрдэнэчимэг	“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
93	С.Халиунаа	Хуульч, судлаач
94	Л.Анхбаяр	Хуульч, судлаач
95	Б.Үйлсдэлгэр	Хуульч, судлаач
96	Д.Содномдаржаа	Хуульч, судлаач
97	Ч.Отгонбаатар	Хуульч, судлаач
98	Э.Эрдэнэхишиг	Хуульч
99	Б.Гаваа	Хуульч
100	Л.Ишжамц	Хуульч

## “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ”

2022 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, Засгийн газрын зарим гишүүнийг шинээр томилсонтой холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг танилцуулах хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 10:00-12:00 цагийн хооронд Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ерөнхийлөгчийн хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл болон бусад хуульч, судлаачид оролцсон.

Хэлэлцүүлгийн эхэнд хуульч, судлаач Н.Баярмаа “Төрийн болон орон нутгийн өмчийн шинэчлэл”, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар баримтлах чиглэл” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн танилцуулгыг тус тус хийсэн болно.

Мэдээний линк: <https://mongolia.gov.mn/news/view/26448>

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

### Нэг.Хэлэлцүүлгийн хөтөлбөр

<b>Д/д</b>	<b>Цаг</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Албан тушаалтан</b>
1		<b>Нээлт</b>	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат
2	10:00-10:20	<b>Илтгэл</b> <i>“Төрийн болон орон нутгийн өмчийн шинэчлэл”</i>	- Хуульч, судлаач Н.Баярмаа
3	10:20-10:40	<b>Танилцуулга</b> <i>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар баримтлах чиглэл</i>	- Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн
4	10:40-11:00	<b>Танилцуулга</b> <i>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл</i>	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар
5	11:00-11:20	<b>Танилцуулга</b> <i>Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл</i>	- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг
6	11:20-12:00	<b>Нэгдсэн хэлэлцүүлэг</b>	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг
7		<b>Хаалт</b>	- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан

**Хоёр.Хэлэлцүүлэгт оролцогчид**

<b>Д/д</b>	<b>Нэр</b>	<b>Албан тушаал</b>	<b>Гарын үсэг</b>
<b>Улсын Их Хурал</b>			
1	Б.Энхбаяр	Улсын Их Хурлын гишүүн	
<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар</b>			
2	А.Бямбажаргал	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх	
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</b>			
3	Д.Амарбаясгалан	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	
4	Ү.Амарбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх	
5	Б.Ганбат	Тэргүүн дэд дарга	
6	Н.Мягмар	Хууль, эрх зүйн газрын дарга	
7	П.Зоригтбаатар	Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга	
8	Д.Саруул	Хууль, эрх зүйн газрын ахлах референт	
9	Б.Төрбат	Хууль, эрх зүйн газрын шинжээч	
10	Г.Дөлгөөн	Хууль, эрх зүйн газрын шинжээч	
<b>Хууль зүй, дотоод хэргийн яам</b>			
11	Х.Нямбаатар	Хууль зүй, дотоод хэргийн сайд	
12	Б.Солонгоо	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд	
13	П.Сайнзориг	Төрийн нарийн бичгийн дарга	
14	Д.Цолмон	Хууль зүйн бодлогын газрын дарга	
15	Э.Энхтуяа	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	
16	Н.Жамъянхүү	Хууль зүйн бодлогын газрын шинжээч	
<b>Сангийн яам</b>			
17	Б.Тэлмүүн	Татварын бодлогын газрын дарга	
18	М.Санжаадорж	Төсвийн зарлагын хэлтсийн дарга	
19	Б.Сүх-Очир	Өрийн удирдлагын хэлтсийн дарга	
20	Ш.Бат-Эрдэнэ	Мэргэжилтэн	
21	Ц.Наранзул	Мэргэжилтэн	
<b>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар</b>			
22	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	
23	Ц.Баяр-Эрдэнэ	Хэлтсийн дарга	
24	Д.Дэлгэрмаа	Хэлтсийн дарга	
25	Ц.Түвшинзаяа	Хэлтсийн дарга	
26	Д.Нарангэрэл	Хэлтсийн дарга	
27	Н.Ганболд	Хэлтсийн дарга	
<b>Бусад</b>			
28	Н.Баярмаа	Хуульч, судлаач	
29	Ж.Эрхэмбаатар	Хуульч, судлаач	
30	Х.Баасанжаргал	“Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-ын гүйцэтгэх захирал	
31	Б.Болорсайхан	“Стратеги академи” ТББ-ын гүйцэтгэх захирал	

**“Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн шинэчлэл” сэдэвт  
хэлэлцүүлгийг хааж Монгол Улсын сайд, Засгийн газрын  
Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангийн хэлэх үг**

2022.09.09

Төрийн ордон

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санаачлан зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон Та бүхэнд талархлаа илэрхийлье.

Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “төрийн өмчийн ангиллыг түүний зориулалт, шинж чанараас хамаарч зөв зохистой хуульчлах, зориулалт тус бүрээр удирдах, захиран зарцуулах, эрх, үүргийг зөв хуваарилах” чиглэлд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр тусгасан.

Түүнчлэн, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх” зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийт болон мэргэжлийн байгууллага, судлаачдын дунд хэлэлцүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулснаар дээрх хоёр хуулийн төслийн талаар нэгдсэн ойлголт, мэдээллийг өгөх, хоорондын уялдаа, нийцлийг хангах, сайжруулахад чухал алхам болно гэж дүгнэж байна.

Нөгөө талаар, Монгол Улсын Засгийн газраас эрх зүйн шинэчлэл, хөгжлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн “төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн өмчийн төрөл, хэлбэрийг зохистой тогтоож, байгалийн баялгийн үр өгөөж нь ард түмэнд ногдох зарчмыг хэрэгжүүлэх, төрийн өмчийн бүртгэл, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх” зорилт хангагдахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хувьд өнөөдрийн хэлэлцүүлгийн үр дүнд гарсан та бүхний санал, зөвлөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд анхаарч ажиллах болно гэдгээ илэрхийлье.

Хэлэлцүүлэгт хүрэлцэн ирж, идэвх, санаачилгатай оролцсон Та бүхэнд баярлалаа.

Хэлэлцүүлгийг үүгээр өндөрлөж байна.

# Хуулийн төсөлд санал авсан байдал

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын [cabinet.gov.mn](http://cabinet.gov.mn) цахим хуудсанд 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байршуулсан.
- Ингэхдээ тус цахим хуудасны “Хуулийн төсөлд санал авч байна” гэсэн баннер хэсэгт хуулийн төслийн нэрээр линк үүсгэж, нэвтэрч орсноор дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж болохоор оруулсан.

Хуулийн төслийн талаарх саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бичгээр болон [turbat@cabinet.gov.mn](mailto:turbat@cabinet.gov.mn) цахим хаягаар ирүүлэх талаар мэдээнд дурдсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан иргэд, олон нийтээс санал ирээгүй болно.





## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловруулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д санал авч байна.

Саналаа [tuibat@cabinet.gov.mn](mailto:tuibat@cabinet.gov.mn) хаягаар болон бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандан ирүүлнэ үү.

Холбоо барих утас: 262958

### МЭДЭЭНИЙ АНГИЛАЛ

Орон нутгийн мэдээлэл

"АЛСЫН ХАРАА-2050"

### ШИНЭ МЭДЭЭ

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ: Засаг орныг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэв маяг, гадны орныг хөрөнгө оруулалтын нэгдмэл байдал чухал  
2022-10-28

Газрын тос боловсруулах үйлдвэрийн хоёр, гуравдугаар багцны барилга угсралтын ажлыг 2023 оны дунд  
2022-10-28

Д.Амарбаясгалан: Тавантолгой бүлэг ордоос Цагаанхад суурьшилтай бүс хуртат нүүрс тээвэрлэх тээврийн хэрэгсэлийг тоог нэмэгдүүлнэ  
2022-10-28

Амьтат жуулчлалыг Үндсэндэй хорооны өндөгтэйгээр хуралдлааар тус салбарын ирэх зүйл орчныг сайжруулахаар ярилцла  
2022-10-28

[https://cabinet.gov.mn/wp-content/uploads/draft\\_law.pdf](https://cabinet.gov.mn/wp-content/uploads/draft_law.pdf)



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг  
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх үүрэг бүхий  
Ажлын хэсгийн бүрэлдэхүүний мэдээлэл

Д/д	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Д.Амарбаясгалан	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга	
2.	Б.Ганбат	ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга	99107271
3.	Н.Мягмар	ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга	99109376
4.	П.Сайнзориг	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	88110079
5.	Д.Саруул	ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын Ахлах референт	88098212
6.	Б.Цэнгэл	ТӨБЗГ-ын дарга	99114512
7.	Д.Цолмон	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга	88101375
8.	Б.Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
9.	Б.Төрбат	ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч	88007383
10.	Ц.Баяр-Эрдэнэ	ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга	88117950
11.	Д.Дэлгэрмаа	ТӨБЗГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	88033540
12.	Д.Нарангэрэл	ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга	99069881